

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр, Мягмар гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:

1-9

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:

10-66

-
- | | |
|--|-------|
| 1. Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 9 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ | 11-26 |
| 2. Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ | 26-46 |
| 3. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэг нарын 13 гишүүн 2025.07.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ | 46-66 |
-

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
9 дүгээр сарын 16-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 35 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: С.Амарсайхан, Ц.Идэрбат, Ц.Мөнхбат, Т.Мөнхсайхан, С.Одонтуяа, У.Отгонбаяр, Р.Сэддорж.

Байнгын хорооны дарга Б.Бейсен хэлэлцэх асуудлын 4-т байгаа Ургац хураалтын явц, дүн байдлын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл, 5-д байгаа Өвөлжилтийн бэлтгэл ажлын явцын талаарх Монгол Улсын Шадар сайдын мэдээллийг сонсох асуудлыг хариуцсан сайд нар эзгүй байгаа тул хойшлуулав.

Нэг. Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 9 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батшагай, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн ахлах референт Э.Цолмонжаргал, Монгол Улсын Шинжлэх ухааны академийн гишүүн А.Бакей, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Хуулийн мэргэжилтэн Б.Алтанцэцэг, “Монголын махны холбоо” ТББ-ын гүйцэтгэх захирал Н.Батсуурь, “Монголын хөдөөг хөгжүүлэх фермерүүдийн холбоо” ТББ-ын тэргүүн Г.Даваадорж, “Монголын тариаланчдын үндэсний холбоо” ТББ-ын тэргүүн Б.Одонхүү, “Биотериал” ХХК-ийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга Г.Сувдаа, Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуй, биотехнологийн сургуулийн захирал Д.Гүрбазар, мөн сургуулийн Агроэкологийн сургуулийн багш З.Эрдэнэчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, Ж.Түвшинжаргал, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Б.Уянга, С.Ганбаатар, М.Ганхүлэг нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, хууль санаачлагч М.Мандхай, Монгол Улсын Шинжлэх ухааны академийн гишүүн А.Бакей, Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуй, биотехнологийн сургуулийн захирал

Д.Гүрбазар, “Биотериал” ХХК-ийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга Г.Сувдаа, нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Ц.Туваан, Б.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 7
Бүгд: 20
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, С.Замира нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

1.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 6
Бүгд: 20
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Л.Мөнхбаясгалан нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 80.0 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

2.Малчны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 5
Бүгд: 21
76.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 81.0 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

3.Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 5
Бүгд: 21
76.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 4
Бүгд: 21
81.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсений “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 85.7 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

5.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 5
Бүгд: 21
76.2 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 4
Бүгд: 21
81.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 4
Бүгд: 22
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсений “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 86.4 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батшагай, Хүнсний аюулгүй байдлын шинжээч Д.Энхмаа, Зөвлөх инженер Ж.Туяацэцэг, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Хуулийн мэргэжилтэн Б.Алтанцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, Ж.Түвшинжаргал, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, З.Мэндсайхан, Б.Уянга, А.Ундраа, Ж.Батжаргал, Б.Бейсен нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, хууль санаачлагч М.Мандхай, Хүнсний аюулгүй байдлын шинжээч Д.Энхмаа, Зөвлөх инженер Ж.Туяацэцэг, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Хуулийн мэргэжилтэн Б.Алтанцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Замира, Б.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, Б.Бейсен нар үг хэлэв.

Б.Бейсен: Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	10
Бүгд:	23

56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

1.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	9
Бүгд:	22

59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
-------------	----

Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Баяжуулсан хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 8
Бүгд: 22
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 8
Бүгд: 22
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 10
Бүгд: 22
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Зөрчлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 8
Бүгд: 22
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Органик бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 8
Бүгд: 22
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 7
Бүгд: 22
68.2 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 8
Бүгд: 22
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 8
Бүгд: 22
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэг нарын 13 гишүүн 2025.07.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батшагай, Хүнсний аюулгүй байдлын шинжээч Д.Энхмаа, Зөвлөх инженер Ж.Туяацэцэг, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Хуулийн мэргэжилтэн Б.Алтанцэцэг, Анагаах ухааны доктор С.Өнөрсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, Ж.Түвшинжаргал, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэг танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Б.Бат-Эрдэнэ, Б.Уянга, Ж.Батжаргал, Мандхай нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, хууль санаачлагч С.Лүндэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батшагай, Хүнсний аюулгүй байдлын шинжээч Д.Энхмаа, Зөвлөх инженер Ж.Туяацэцэг, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Хуулийн мэргэжилтэн Б.Алтанцэцэг, Анагаах ухааны доктор С.Өнөрсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Б.Бейсен: Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

1.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Малчны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Таримал ургамлын үр, сортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9
Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 9

Бүгд: 22
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

9. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 10
Бүгд: 22
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 41 минут үргэлжилж, 30 гишүүнээс 23 гишүүн хүрэлцэн ирж, 76.7 хувийн ирцтэйгээр 18 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
14 цаг 35 минут.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц 53,3%-тай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 9 дүгээр сарын 16-ны хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүн бүрээр танилцуулъя. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн ирсэн байна. Буланы Бейсен гишүүн ирсэн байна. Гонгорын Дамдинням гишүүн ирсэн байна. Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн байна. Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн байна. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ирсэн байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн ирсэн байна. Сонгобайн Замира гишүүн ирсэн байна. Загджавын Мэндсайхан гишүүн ирсэн байна. Агваанлуvsангийн Ундраа гишүүн ирсэн байна. Пүрэвийн Батчимэг гишүүн ирсэн байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн байна. Сүрэнжавын Лүндэг гишүүн ирсэн байна. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна. Болдын Уянга гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Хөдөө аж ахуйн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Улсын Их Хурлын гишүүн Мандхай нарын 10 гишүүнээс 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх.

2 дугаар асуудал. Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Улсын Их Хурлын гишүүн Мандхай нарын 10 гишүүнээс 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх.

3 дахь асуудал Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Улсын Их Хурлын гишүүн Лүндэг нарын 13 гишүүнээс 2025 онд 7 сарын 4-ний өдөр өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх.

4. 5 дахь асуудал Ургац хураалтын явц, дүн байдлын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох

5-д Өвөлжилтийн бэлтгэлийн ажлын явц талаар Монгол Улсын Шадар сайдын мэдээг сонсох. Энэ 2 асуудлыг Хөдөө аж ахуйн сайд, Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн, бодлого зохицуулалтын газрынхан бүх аймгуудаар зуншлага, өвөлжилтийн бэлтгэл ажилтай холбогдуулан танилцаж байгаа учраас энийг хойшлуулж байна. Хэлэлцэх асуудалд саналтай гишүүд байна уу. Байхгүй байна.

Хөдөө аж ахуйн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.

Хууль санаачлагчийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Хөдөө аж ахуйн дэд хорооны дарга Мандхай танилцуулна. Мандхай гишүүний микрофон өгье.

М.Мандхай: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн товч танилцуулгыг хийе.

Хөдөө аж ахуйн салбар нь манай улсын эдийн засгийн үндсэн тэргүүлэх салбар бөгөөд хүн амын гол нэрийн хүнсний үндэсний хөнгөн аж үйлдвэрийн түүхий эдийн зонхилох хэрэгцээг хангаж, хүнс, хөнгөн аж үйлдвэр, худалдаа үйлчилгээний салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспортод шууд болон дам хэлбэрээр онцгой үүрэг гүйцэтгэдэг.

Монгол Улсын нийт ажиллах хүчний 24,5%, 2024 оны байдлаар ДНБ-д хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 3,9%-ийг эзэлж байна. 2023 оны байдлаар ДНБ-д хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 7,9%-тай байсан. 1 жилийн дараа гэхэд 3,9%-ийг эзэлж байгаа. Тэгэхээр өөрөө энэ салбар маань улирлын чанартай, дээрээс нь энэ салбарын хувьд ийм тогтворгүй байдал үүсэж байгааг бас онцлох нь зүйтэй. Хөдөө аж ахуйн дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, тогтвортой хөгжлийн суурийг бэхжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, нөөцийн ашиглалтыг сайжруулах, төрөөс хөдөө аж ахуйг хөгжүүлэх, дэмжихэд баримтлах бодлогын суурь зарчмыг тодорхой болгох, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөн тэсвэрлэх тогтвортой хөгжүүлэх хэрэгцээ шаардлагатай байгаа билээ.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолоор баталсан Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 1.1.1-д Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан. Иймд Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалж, тус салбарт үүсээд буй нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасны дагуу Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлэн анхдагч хуулийн төслийг боловсрууллаа.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлд тус хууль нь төрөөс хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлогын суурь зарчмыг тодорхойлж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн төрөлжилт, өртгийн сүлжээний нэгдмэл цогц байдлыг хангах, тогтвортой хөгжлийг дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулахаар тусгасан.

Хуулийн төсөл нь 6 бүлэг 22 зүйлтэй. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрэлт, нийлүүлэлт, нөөц, ашиглалт, бүтээмжийн дүн шинжилгээ хийх, түүнд суурилан тогтвортой хөгжүүлэх зорилтот хөтөлбөрийг баталж, өөрөө хэрэгжүүлэх, орон нутгийн түвшинд уг зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг зохион байгуулахаар онцлон заав.

Түүнчлэн Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд төрөөс үзүүлж байгаа дэмжлэгийг оновчтой болгох, чанар бүтээмжтэй уялдуулах зорилгоор нийт дэмжлэгийн хэмжээ эдийн засгийн өгөөжийг тооцдог байх харилцааг хуульчлан орууллаа.

Хуулийн төсөлд хөдөө аж ахуйн өртгийн сүлжээний үе шат бүрд нэмүү өртөг шингээх боломжийг бүрдүүлэхийн тулд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн ангилал,

төрөлжилт, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн өртгийн сүлжээг хөгжүүлэх харилцааг тодорхой болгосон. Түүнчлэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд чанараас хамаарсан үнийн тогтолцоог бүрдүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүний нөөцийн бодлого, судалгаа, хөгжүүлэлтийг төлөвшүүлэх, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид хөрөнгө оруулагчдыг дэмжих хэлбэр, чиглэл, шалгуурыг тогтоох, бүртгэл, хяналтын нэгдсэн сүлжээ бий болгох зэрэг дараах зарчмын шинжтэй зохицуулалтын харилцааг тусгав.

Хуулийн төсөлд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн үнэлгээ хийхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан. Мөн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд холбогдох зохистой дадал, стандарт, техникийн зохицуулалтыг мөрдөх, шаардлагыг хангуулах чанартай уялдсан үнийн тогтолцоог хөгжүүлэхэд чиглэсэн идэвхжилтийн төрийн дэмжлэг олгох нөхцөлтэй уялдуулав. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дэх төрийн удирдлагын тогтолцооны цар хүрээг тогтоож, бүртгэл хяналтын нэгдсэн цахим систем бий болгох харилцааг хуульчлан тусгав. Хуулийн төслийн дагалдах нэр бүхий 7 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар боловсруулсан.

Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг D-Parliament цахим сайтад 2025 оны 4 сарын 15-ны өдөр байршуулж, олон нийтээс хуулийн төсөлд санал авсан. Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн салбарын эрдэмтэд, судлаачид, аж ахуйн нэгж, иргэд, мэргэжлийн холбоод, фермер, малчдын төлөөлөл, олон улсын байгууллагын төлөөллийг оролцуулан 2 удаа хэлэлцүүлэг зохион байгуулж, санал шүүмжийг хэлэлцүүлгийн явцад болон цаасаар хүлээн авсан. Нийт 101 санал 50 гаруй бичгээр саналуудыг өгсөн байна.

Улсын Их Хурлын даргын 2024 оны 42 дугаар захирамжаар байгуулагдсан Улсын Их Хурлын гишүүдэд хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг танилцуулж, санал шүүмжийг авав. Дээр дурдсан хэлэлцүүлгүүдийн явцад болон цахимаар цаасаар ирүүлсэн санал шүүмж тус бүрийг дэд ажлын хэсэг дээр хэлэлцэн хуулийн төслөөр зохицуулж байгаа харилцаанд шууд хамааралтай саналыг хуулийн төсөлд тусгаж зарим зохицуулалтын хэсгийг хасах, нэмэх өөрчлөлт оруулан хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулсан.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, холбогдох танилцуулга, судалгаа, тайланг Засгийн газарт санал, дүгнэлт авахаар хүргүүлж, саналыг авсан болно.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл батлагдсанаар эдийн засаг, нийгмийн дараах ач холбогдол үр дүн гарна гэж үзэж байна. Үүнд:

Улс орны эдийн засгийн үндсэн салбар болох хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийн суурийг бэхжүүлж, төрийн урт, дунд хугацааны бодлогын хэрэгжилтийг дэмжиж, дэд салбар хоорондын харилцан уялдаа нэгдмэл байдлыг хангах эрх зүйн орчныг сайжруулна.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлэх төрийн дэмжлэгийн чиглэл, шалгуурыг тодорхой болгосноор хөдөө аж ахуйд хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлж, салбарын эдийн засгийн өсөлт, экспортыг дэмжинэ.

Хөдөө аж ахуйн өртгийн сүлжээнд төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, мэргэжлийн байгууллага, холбоодын хамтын ажиллагаа бэхэжнэ гэж үзэж байна.

Иймд, нэр бүхий Улсын Их Хурлын гишүүдээс санаачлан боловсруулсан Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл, дагалдах хуулийн төслийг хэлэлцэж өгнө үү.

Б.Бейсен: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хүрэлцэн ирсэн ажлын хэсгийг танилцуулъя. Д.Довчинсүрэн Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Д.Есөн-Эрдэнэ Газар, тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулалтын газрын дарга, Б.Батшагай Хүнс, хөдөө аж ахуйн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Э.Цолмонжаргал Парламентын судалгааны хөгжлийн хүрээлэнгийн ахлах референт, А.Бакей Эдийн засгийн шинжлэх ухааны доктор, Монгол Улсын Шинжлэх ухааны академийн гишүүн, академич, Б.Алтанцэцэг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Хууль бодлогын мэргэжилтэн, Н.Батсуурь “Монголын махны холбоо” ТББ-ын гүйцэтгэх захирал, Г.Даваадорж “Монголын Хөдөөг хөгжүүлэх фермерүүдийн холбоо” ТББ-ын тэргүүн, Б.Одонхүү “Монголын тариаланчдын үндэсний холбоо” ТББ-ын тэргүүн, Г.Сувдаа “Биотериал” ХК-ийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга, Д.Гүрбазар ХААИС-ийн Мал аж ахуй, биотехнологийн сургуулийн захирал, Хөдөө аж ахуйн ухааны доктор, Монгол Улсын тэргүүний мал зүйч, З.Эрдэнэчимэг Агроэкологийн сургуулийн багш, Хөдөө аж ахуйн ухааны доктор.

Хууль санаачлагчийн танилцуулгатай холбогдуулан санал хэлэх, асуулт асуух гишүүд нэрс өгнө үү. Туваан гишүүнээр тасаллаа. Туваан гишүүн асуулт асууя.

Ц.Туваан: Энэ хуулийг дэмжинэ. Ер нь манай хөдөө аж ахуйн салбар яг салбарынхаа хүрээнд ийм эцэг ч гэдэг юм уу Үндсэн хууль шиг малгай хууль байхгүй. Ийм зохицуулалтгүй. Яг салбар салбар дээрээ харилцаануудаа зохицуулаад ирсэн ийм тал бол байгаа. Тэгэхээр энэ дээр энэ хуулийг бас анхдагч хууль болоод нэлээн тийм Үндсэн хууль шиг ерөнхий зохицуулалт малгай болоод явах хууль гэж ингэж харж байгаа. Манай хөдөө аж ахуйн салбар дээр бас яг ний нуугүй хэлэхэд тулгамдаж байгаа асуудлууд бол маш их байна. Олон байна. Мэдээж бүгдийг нь ярих боломжгүй. Тэгэхдээ энэ дотор бол үйлдвэрлэлийн асуудал, дээрээс нь мал аж ахуйн салбар, газар тариалангийн салбар, хүнсний салбарууд дотор ч гэсэн маш олон асуудлууд, ялангуяа энэ дунд боловсон хүчний асуудал маш их хөндөгдөж байгаа. Малчдын асуудал ч гэсэн үнэхээр ноцтойгоор хөндөгдөж эхэлж байгаа. Тэгэхээр энэ асуудлуудыг бас хэр тусгасан юм бол. Малчдын асуудлыг, дээр нь мал аж ахуйн салбарт байгаа энэ малын эмч, зоо техникүүдийн асуудал, газар тариалангийн салбарт байгаа агрономи, инженерүүдийн асуудал гээд ийм суурь яг үнэн тулгамдаад байгаа асуудлаа ямаршуу судалгаатайгаар, ямаршуу заалт болгож оруулсан юм бол гэдэг нэг ийм асуудал байгаа юм.

2 дугаарт нь бол мэдээж дэлхийд энэ хөдөө аж ахуйн салбар бол татаас урамшуулалгүйгээр явдаггүй. Энэ өөрөө ард түмний хүнсийг найдвартай баталгаатай хүнсээр хангалттай хангах гэдэг ийм үндсэн зорилгынхоо хүрээнд бол үндэсний аюулгүй байдлын асуудалтай холбогдож ирдэг гэдэг утгаараа энэ урамшууллын бодлого бол явдаг. Тэгэхээр энэ урамшуулалтай холбоотой бодлого энэ хуульд маань чухам яаж сая хууль санаачлагчийн үгэнд бас гарч байна. Тэгэхээр энэ зүйл нь бол хаанаа, яаж ямаршуу байдлаар туссан бэ гэдэг нэг ийм асуудал байгаа.

Гуравдугаарх нь бол энэ хуулиуд дээр бусад хуулиуд дээр энэ хөдөө аж ахуйн салбар луу чинь дур дураараа ингээд шууд нэг хууль санаачлаад л гаргаад ирдэг. Үүний хамгийн тод жишээ бол энэ гурилын импортын татварыг тэглэж хаяад, энэ салбарыг үндсэнд нь нураагаад хаячихсан асуудал байгаа шүү дээ. Хожимдоод л дууссан хойно бид нар дуугараад, буцааж хүчингүй болгоод л ингээд явж байгаа асуудал. Тэгэхээр энэ асуудлыг ер нь бас яг энэ малгай хуулиасаа аваад хориглох, шууд дураараа ингээд нэг ийм бодлогыг нэг хэсэг хүн шууд өөрчлөөд явчихдаггүй байх гэдэг энэ зохицуулалт ер нь орсон юм болов уу гэсэн ийм асуултуудад хариулт авъя.

Б.Бейсен: Хууль санаачлагч хариулъя. Дараа ажлын хэсэг хариулт өгье. Мандхай гишүүний микрофон өгье.

М.Мандхай: Маш чухал асуулт асуулаа. Ер нь хөдөө аж ахуйн салбарын маш чухал нэг асуудал бол хөдөө аж ахуйн өртгийн сүлжээ гэж зүйл байгаа. Өнөөдөр манай яг салбарт бол 30 орчим хөдөө аж ахуйн салбар, дэд салбаруудыг зохицуулсан хуулиуд бол байгаа. Тэгээд эдгээр хуулиудыг хооронд нь уялдаа холбоог хангаж ажиллах ийм зайлшгүй бас эрх зүйн болон эдийн засгийн ийм нөхцөл байдал үүсэж байгаа. Ийм учраас Хөдөө аж ахуйн малгайн хуулийг бол бид нар бас бол боловсруулж гаргаж ирсэн ийм ач холбогдолтой. Тэгээд энэ дотроо мэдээж өртгийн сүлжээг зохицуулах, цаашдаа энийг мэргэжлийн түвшинд тогтвортой хөдөө аж ахуйг авч явах гол асуудал бол өөрөө энэ хүний нөөцтэй холбоотой асуудал байгаа. Тэгэхээр ер нь бас энэ хуулийн гол практик, шаардлага хэрэгцээ юу вэ гэхлээр жил ирэх тусам ХААИС-д мэргэжлийн хамгийн чухал техникийн боловсон хүчнээр сурах элсэлтийн тоо бас буурч байгаа нь өөрөө бас анхаарал хандууштай. Энэ нь ч өөрөө бас манай тандан судалгаанд бол тусгагдаж орж ирсэн байгаа. Тэгэхээр энийг бид нар бас хууль, эрх зүйн орчинд нь дэмжиж өгч ажилладаг байх үүднээс төрөөс хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлогын зарчмыг бол 5 дугаар зүйлд нарийн оруулаад, энэ дээр хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхжуулах, залгамж халааг тасралтгүй бэлтгэх тогтолцоог бол хуулиараа зохицуулж өгсөн ийм ач холбогдолтой юм.

Мөн малчны асуудал бол Малчны хуулиар бол зохицуулагдаж байгаа. Гэхдээ хуулийн төслийн 14 дүгээр зүйл дээр та бүхэн харах юм бол хүний нөөцийн асуудлыг бол илүү нарийвчилж тусгасан заалтыг оруулж өгснөөрөө онцлогтой байгаа юм. Жишээлбэл, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн зорилтыг шийдвэрлэхэд шаардагдах мэргэшсэн хүний нөөцийн хэрэгцээг мэргэжил, мэргэшлийн түвшнээр нь урт, дунд хугацаанд тодорхойлж хэрэгцээг хангах арга хэмжээг энэ хуулийн 12.1-д заасан зорилтод бол бас хөтөлбөрт нь нарийвчилж тусгасан байгаа. Тэгээд бүтэн энэ хүний нөөцтэй холбоотой асуудлыг 14 дүгээр зүйл дээр бол нэлээн нарийвчилж оруулж өгсөн. Тэгээд үлдсэн асуултуудыг нь бас манай экспертүүд хариулаад явчхаарай.

Б.Бейсен: 6 номерын микрофон. Бакей академич хариулъя. 6 номерын микрофон.

А.Бакей: Туваан гишүүний асуултад хариулъя. Ер нь бол хөдөө аж ахуйн салбарын хөгжилд өндөр хөгжилтэй, буурай хөгжилтэй аль ч орны хувьд бол зайлшгүй төрөөс дэмжлэг үзүүлдэг. Энэ бол зүй ёсны асуудал. Яагаад гэвэл хүн амын хүнсний аюулгүй байдалтай холбоотой асуудал учраас. Гагцхүү энэ дэмжлэг нь бол хөгжлийн түлхэц, хөшүүрэг болох ёстой зарчим нь. Тэгэхээр энэ агуулгаар бол 18 дугаар зүйлд энэ асуудлыг тусгасан байгаа бүхэлд нь. Тэгэхээр гол асуудал

нь юу вэ гэхээр зэрэг төрөөс дэмжлэг үзүүлэх хэлбэр нь ямар байх вэ. Тэгээд шалгуур, шаардлага нь ямар байх вэ. Ямар чиглэлийн үйлдвэрлэл үйл ажиллагаанд тэргүүн ээлжид/минут дуусав/

Б.Бейсен: 6 номерын микрофон нэмж өгье.

А.Бакей: Одоо шаардлагын хувьд бол тавигдах шаардлагын хувьд зохих стандартыг хангасан, зохистой дадлыг нэвтрүүлсэн, импортын орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн гэх мэт маш тодорхой шаардлагууд тавигдсан байгаа. Үүнээсээ гадна бол уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд бол хамгийн тулгамдсан асуудал болох хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээх чадавхыг бэхжүүлэхтэй холбоотой ийм үйлдвэрлэл, үйл ажиллагааг дэмжих, дасан зохицохтой холбоотой үйл ажиллагааг дэмжих, бэлчээрийн газрын доройтлыг бууруулах, доройтлоос сэргийлэх энэ чиглэлийг дэмжих сум дундын хэрэгцээг хангах өвс, тэжээлийн нөөцийг агуулах, тэжээлийн үйлдвэр байгуулах гэх мэт ийм тодорхой зүйлүүдийг зааж өгсөн байгаа. Баярлалаа.

Б.Бейсен: Хариулт болсон уу. Туваан гишүүн тодруулъя. Мандхай гишүүн нэмж хариулъя.

М.Мандхай: Түрүүн Туваан гишүүн бас гурилтай холбоотой асуудлыг, гурил хориглох энэ гэнэтийн ийм шийдвэр гаргаад хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрлэл дээр ийм асуудал үүсэх үү гэдэг асуудал дээр энэ хуулиар бол төрөөс хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлогын зарчмыг тодорхойлж өгч байгаа. Тэгэхээр энэ бодлого дээр бол бид нар та бүхэн харах юм бол 5.2.6 дээр хөдөө аж ахуйн хөдөлмөрийн үнэлэмж, бүтээмж, эдийн засгийн өгөөж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах гэдэг зарчмыг бол оруулсан. Мөн 5.2.7-д хөдөө аж ахуйн түүхий эд бүтээгдэхүүний эрэлт нийлүүлэлтийг тогтворжуулах, шударга өрсөлдөөнийг дэмжих гэдэг заалтыг бол зарчим болгож баримтлахаар бас тусгасан байгаа. Тэгээд манайхаас бас нэмээд хариулах уу.

Б.Бейсен: 3 номер нэмж хариулъя.

Г.Сувдаа: Туваан гишүүний асуултад тодруулга нэмэлт өгье. Ер нь хуулийн төслийн 16 дугаар дугаар зүйлд бид нар хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэлийн 3 бүлэг асуудлыг тусгасан байгаа. Тэгэхээр энэ урамшуулал болоод аливаа нөгөө хөдөө аж ахуйн үйлдвэрлэлтэй гэнэт нөгөө ийм эдийн засгийн болоод нийгмийн ийм эрсдэлүүд үүсэхэд бол энэ зохицуулгыг хийхийн тулд орж ирсэн. Тухайлбал түрүүн Туваан гишүүний хэлсэн үнийн хэлбэлзэл, санхүүжилтийн хүртээмж, төрийн байгууллагын төрийн дэмжлэг, тэгээд өрсөлдөх чадварын асуудал гэх мэтчилэн нь бол эдийн засгийн бүлгийн эрсдэл гэсэн ангиллаараа бол зохицуулалт хийе гэсэн байдлаар яг хуулийн төсөлдөө тусгасан байгаа. Баярлалаа.

Б.Бейсен: Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: Хэдүүлээ тэгээд ярилцаад явъя. Тэгээд бас нэлээн нарийн юмнууд байгаа. Тэгээд дагаж нэлээд олон хуульд өөрчлөлт оруулах юм шиг байна. Тэгэхээр энэ дээр хэдүүлээ энэ хуулийг тийм бас лоозонгийн шинж чанартай биш, ядахдаа салбар салбарт тодорхой үр дүн ахиц гарсан ийм хууль болоод батлагдчихвал бас бид нарын энэ хуулийг баталж байгаагийн 1 үр дүн гарах байх гэж бодож байна. Монгол Улсад малчдын залуу халаа гэдэг бол аюулын харанга дэлдчихсэн байгаа шүү. Энийг хэдүүлээ тэр Малчны хуульд байгаа гээд орхичхолгүй, шаардлагатай

бол дагуулаад Малчны хуульд нь өөрчлөлт оруулдаг юм уу, нэг газар оруулж өгмөөр байгаа юм. Энэ газар тариалангийн салбар дээр гэхэд энэ жил ийм эрсдэлт нөхцөл үүсчихсэн шүү дээ. Одоо нөгөө муу хэдэн тариаланчид хөөрхий ургацаа алдчихсан, зээлтэй, зээлийн хүүтэй ийм зүйл дээр яах вэ энэ тэр гэдэг ч юм уу иймэрхүү нэг ийм тодорхой үр дүн гаргах заалтуудаа нэмээд.../минут дуусав/

Б.Бейсен: Санал хэллээ. Болдын Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе. Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй бол нэлээн дэлгэрэнгүй нарийн танилцаж байгаа. ... За алагсчихъя.

Б.Бейсен: Ганбаатар гишүүн асуултаа асууя.

С.Ганбаатар: Хөдөө аж ахуйн энэ анхдагч хуулийн төслийг дэмжиж байна. Монгол орон чинь ер нь хөдөө аж ахуй, мал аж ахуйн л орон шүү дээ. Тэгээд тэрийгээ мартталаа л бид уул уурхай ухааж, маргааш дэлхий сөнөх гэж байгаа юм шиг л баахан л ухлаа шүү дээ. Тэндээс нь хамгийн гол нь жирийн иргэдэд, улс оронд ямар ашиг байна вэ л гэж би 20 жил асуулаа. Тэгээд цаад утгаараа мал аж ахуй, хөдөө аж ахуйгаа дээрэлхэж, энэ зэрлэг капитализм чинь ер нь хүн, байгаль 2-т л хамгийн осолтой шүү дээ. Тэгээд энэ дээр миний 1 дүгээр асуулт ер нь бол эдийн засаг, нийгмийн шинжлэх ухааны нэг хэсэг нь байгаль орчны шинжлэх ухаан гэж ярьдаг байсан. 20 жилийн өмнө. Одоо энэ олон ган гачиг энэ олон цөлжилт болсноос хойш дэлхий юу гэж ойлгож байна вэ гэсэн эрдэмтэд бүр тодорхойлсон. Байгаль орчны шинжлэх ухааны нэг хэсэг нь эдийн засгийн шинжлэх ухаан юм байна л гэж ойлгоод байгаа. Энэ дээр ер нь бол тэгээд л малын ам руу орох юм байхгүй бол тэгээд л бид бүгдээрээ дуусаа шүү дээ. Тэгэхээр энэ цөлжилттэй холбоотой судалгаа шинжилгээ нь яг хөдөө аж ахуй л ярьж байгаа бол энэ талаар ямар арга хэмжээнүүд авна гэж тооцож байгаа вэ. Энэ дээр зүгээр л байгаль орчны гээд нэг ийм 16 дугаар зүйл дээр ийм бэлгэдлийн маягтай байна. Механизм нь байна уу. Хариуцлага тооцдог, мөнгө тавьдаг арга зам нь юу байна вэ. 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт Дэлхий даяараа, дэлхий ч яах вэ, Монгол бол хөдөө аж ахуй, мал аж ахуй гэхлээр нэг л тийм шинжлэх ухаанаас, инновацаас хол гэж дандаа боддог. Израил одоо та нар МРЗ, dualcore зохиосон л гэж дандаа боддог байх. Үгүй шүү дээ. Регэйшн гэж услалтын систем хөдөө аж ахуйдаа инновац оруулснаараа л тэдний эдийн засаг хөгжсөн. Тэр шиг энэ дээр нэг тийм тунхгийн чанартай ийм судалгаа шинжилгээ байна гээд л хаячихсан байна. Энэ дээр яаж мөнгө тавих вэ. Яаж хариуцлага тооцох вэ. Энэ дээр олон дарга нарын тухай бүтцүүд их байна л даа.

Миний 3 дахь асуулт яаж хяналт тавих вэ. Хариуцлага тооцох вэ. Дарга улс болчихлоо шүү дээ. Хариуцлага тооцдог, хяналт тавьдаг механизмууд нь анхдагч малгайн хууль дотроо байхгүй юм бол энэ хөдөө аж ахуй дээр баахан төсөл энэ 20, 30 жил хэрэгжлээ. Тэгээд улс төрчдийн гараар л тэгээд л дуусаж байгаа шүү дээ. Араас нь яг нөгөө үр шимийг нь хүртдэг хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарын эрдэмтэн мэргэдийн дуу хоолой таг. 0. Эрдэмтдийн дуу хоолой гараад, тэрийг нь тойрч улс төрчид ярьдаг механизм энэ дотор байгаа юц. Тэгэхгүй тэгээд л гишүүн болоод .../минут дуусав/

Б.Бейсен: Хууль санаачлагч Мандхай гишүүн хариулъя. Дараа нь ажлын хэсэг хариулъя.

М.Мандхай: Ганбаатар гишүүний хэлж байгаа ер нь бол яах вэ зарчимтай би бас санал нэгдэж байгаа. Тэгээд хуулийг одоо бас ажлын хэсэг байгуулагдаад, дахиад өргөн хүрээнд хэлэлцүүлэг хийгдээд явахад илүү бас орхигдуулсан хариуцлагын тогтолцоог өшөө нэмэх юман дээр бас санал нарийвчилж боловсруулаад оруулах бүрэн боломжтой гэж бас хэлье. Бид нар бол яах вэ, ер нь бол энэ Хөдөө аж ахуйн тухай хуулийн нэг чухал зүйл бол бид нарын орхигдуулаад байгаа нэг асуудал нь бид нар ингээд урт хугацааны хөгжлийн бодлого, Алсын хараа 2050, тэгээд дунд хугацааны Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль гээд бас байгаа удирдлагын тухай хууль гээд. Тэгээд энэ байгаад бодлогын баримт бичгүүд дээр тавьсан заалт өөрөө яг бодитой хуульчлагдаж хэрэгжихгүй явж ирсэн нэг ийм алдаатай тогтолцоо байгаад байна. Тийм учраас бид нар бол аль болох энэ урт хугацааны хөгжлийн бодлого болон дунд хугацааны орхигдуулсан эсвэл ерөнхийлөн заагаад ойлгомжгүй байгаа юмыг Хөдөө аж ахуйн салбарын бодлого болгож ялангуяа энэ хуульд бол бас оруулж ирэх гэж оруулсан. Үүний нэг чухал зүйл бол өөрөө энэ тогтвортой хөдөө аж ахуй гэж юу юм бэ гэдгийг бас бид нар оруулж өгснөөрөө онцлогтой. Тогтвортой хөдөө аж ахуйг хэрэгжүүлэхийн тулд байгаль орчин, уур амьсгалын энэ нөхцөл байдалд бид нар яаж тэсвэртэй, зөв зохион байгуулалттай явах вэ гэдэг дээр бас саналуудыг нэмье гэж бодож байна. Гэхдээ 16 дугаар зүйлд Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэл түүнээс урьдчилан сэргийлэх гэдэг бас зүйлийг оруулсан. Энэ дотроо бид нар Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэлийг бас 3 түвшинд нь хувааж ямар ч байсан бид нар энэ ангиллын дагуу үнэлдэг байя. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авъя. Хариу арга хэмжээ авах энэ үйл ажиллагааг бол байгаль орчныг бүүр нарийвчилж оруулж өгсөн байгаа.

Мөн бид нар энэ нөлөөллийн эрсдэлд үүнтэй зэрэгцүүлээд бэлчээрийн асуудал, тариалан, газрын доройтол, усны хомсдол, генетик нөөцийн төлөв, уур амьсгалын өөрчлөлт, энэ хүлэмжийн хийн ялгаруулалт хог хая дэгдлийн менежментийн талаар бас бид нар тусгаж өгсөн байгаа. Ингээд үүнтэй холбогдуулаад энийг бид нар сөрөн тэсвэрлэж, хамгаалж сэргийлэхийн тулд үүнтэй зохицсон эдийн засгийн өгөөж, дээрээс нь бүтээгдэхүүн хэлбэлзэл, санхүүжилтийн хүртээмжийг энэ төрийн дэмжлэг нь өөрөө яг энэндээ чиглэж судалгаа шинжилгээ үнэлгээ дээр үндэслэж хуваарилдаг байя гэдэг асуудлыг бас оруулж өгсөн байгаа.

Дараагийн нэг асуудал бол түрүүн хэлсэн. Хариуцлагын тогтолцоог бид нар 5 дугаар бүлэг дээр бол Хөдөө аж ахуйн салбарын удирдлага зохицуулалтыг оруулсан. Энэ дээр бас тодорхой түвшинд бид нар ямар ч байсан ялангуяа энэ саяын хэлсэн энэ ургамал, мал амьтан, эрүүл мэнд, ген, тэгээд л энэ уур амьсгалын өөрчлөлт, шинжлэх ухааны илүү инновац дээр тулгуурлаж төрийн үйлчилгээний төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд бол хариуцуулъя. Дээрээс нь энэ хяналт тавих, дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх чиг үүргийг бас улсын хэмжээнд Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь өөрөө хэрэгжүүлдэг байя гэдэг асуудлыг хамгийн гол нь төлөвлөлттэй байя, хяналттай байя, дүн шинжилгээ хийе. Энийгээ өөрөө үнэлдэг байя. Энийг нь өөрөө хариуцаж байгаа төрийн захиргааны төв байгууллага нь өөрөө хэрэгжүүлдэг байх механизмыг бол энэ хуулиараа зохицуулж өгсөн байгаа. Би өөр орхигдуулсан асуудал байх юм бол бас манай салбарын экспертүүд нэмээд хэлээрэй.

Б.Бейсен: 6 номер. Бакей академич. Дараа нь 5 номер Батсуурь гуай хариулах юм байна.

А.Бакей: Баярлалаа. Хуулийн төслийн 18.7-д бол Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн мөнгөн ба мөнгөн бус дэмжлэгийн нийт хэмжээ, бүтээмж, эдийн засаг, нийгэм, байгаль орчны нөлөөлөл, өгөөжийг жил бүр тооцож, үр дүнд суурилсан төсөв, бодлогын арга хэмжээг төлөвлөх, дэмжлэгийг оновчтой тогтоож, хуваарилахад ашиглана гэж механизмыг нь заасан байгаа. Өөрөөр хэлбэл одоо бол үндсэндээ яг тоон үзүүлэлтийг дэмжсэн дэмжлэг давамгайлж байгаа. Одоо бол жил болгон энэ үр дүнгээ тооцож, байгаль орчинтой холбоотой, үр өгөөжтэй холбоотой чанартай холбоотой энэ шалгуур үзүүлэлтээр үндсэндээ дүгнэнэ л гэсэн үг. Дээр нь 18.10 дээр Үндэсний баялгийн сангаас хөдөөгийн хөгжил, Хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэл, бүтээмж, экспортыг нэмэгдүүлэх..../минут дуусав/

Б.Бейсен: 6 номер гүйцээж хариулъя. 6 номерын микрофон.

А.Бакей: Тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлж, энэ хуулийн 18.3-18.6-д заасан дэмжлэгийг үзүүлнэ гэж байгаа. Тэгэхээр энэ баялгийн сантай бас зохих хэмжээгээр холбосон ийм өгүүлбэр орчихсон байна.

Б.Бейсен: 5 номер Батсуурь хариулъя.

Н.Батсуурь: Баярлалаа. Ганбаатар гишүүний тэр асуусан асуулт бол маш их чухал асуулт юм. Ер нь бол энэ хуулийн гол үзэл санаа, зохицуулах хэм хэмжээ нь бол яг энэ гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг нь хангуулдаг болох асуудал хэрэгтэй байгаа юм. Одоо бол Хөдөө аж ахуйн яам, Засгийн газрын түвшинд бодлогоо тодорхойлчихдог. Яг газар дээрээ нөгөө бодлого нь ерөөсөө ингээд уялдаж, хэрэгжиж өгдөггүй. Тийм учраас энэ хуулийн 12.6-д нэлээн тодорхой заасан байгаа. 12.5-д бас тодорхой заасан байгаа. Тэр орон нутгийн Засаг дарга Хөдөө аж ахуйн салбарын бодлогынхоо хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлыг нь бол орон нутгийн Засаг дарга, тэр аймгийн Засаг дарга, сумын Засаг дарга хариуцна. Тэр хүн гэрээнийхээ үр дүнг Хөдөө аж ахуйн сайдад тайлагнадаг байхаар ингэж зохицуулж өгч байгаа. Хөдөө аж ахуйн яам бол энэ хяналт шинжилгээ үнэлгээгээрээ энэ .../минут дуусав/

Б.Бейсен: 5 номер гүйцээж хариулъя.

Н.Батсуурь: Тогтолцоо руу оруулж өгч байгаа. Ингэснээрээ бол энэ үндэсний хэмжээнд улсын хэмжээнд бүх бодлого бол хэрэгжих, тэрний хариуцлага тооцох энэ механизмуудыг нь оруулж өгч байгаа. Тэгээд эцэст нь бол энэ хуулийн санкц дээр хэрвээ энэ хуулийг хэрэгжүүлээгүй зөрчил гаргасан байх юм бол албан тушаалын хариуцлага тооцдог, тэр ажлынх нь байран дээр тэнцэж байна уу, үгүй юу гээд тэр хүнтэй хариуцлага тооцох ийм үндэслэл нь бол гарч өгч байгаа. Тэгэхээр Их Хурлын гишүүд маань тэрийг илүү тодорхой болгоод энэ хариуцлагын механизм дээр нь бүр сайжруулаад явах бололцоотой байгаа шүү. Бид бол ер нь тэр албан тушаалтай нь хариуцлага тооцдог байя л гэсэн санаагаар энд заалт оруулчихсан байж байгаа. Баярлалаа.

Б.Бейсен: Ганбаатар гишүүн тодруулъя.

С.Ганбаатар: Би ер нь дараа нь бас тодорхойлж асуулт асууна. Зүгээр энэ дээр бол ерөнхий юмнуудаа ярьчихъя. 5.2.9 дээр уг нь та нар их гоё юм заасан байгаа шүү дээ. Төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа, оролцоог хангана гэж байгаа юм. Энэ бол их чухал даа. Саяын 12.5, 16.6, 18.7-оос илүү одоо жишээ нь 12.5 дээр ярих юм бол

тавиулсан дарга тавьсан даргатайгаа л хэлэлцээр хийх л тухай ярьж байгаа юм шүү дээ. 1 Засаг дарга 1 сайдтай гэрээ хийнэ гэдэг чинь тэгээд юу хэлэх вэ дээ тэр 2 бие биедээ. Харин 5.2.9 дээр төр хувийн хэвшил хоорондоо хэлэлцээр хийнэ. Энэ хэлэлцээрийг хууль гэж үзнэ гэж олон улсын яг энэ хөдөө аж ахуйг хөгжүүлж байгаа газруудад бол үр шимийг нь хүртэх гэж байгаа тэр малчдын байна уу, тариаланчдын байна уу, тэр сонирхлын бүлгийн төлөөллийн байгууллагууд нь засаг төртэй хэлэлцээрийн ширээнд суугаад хэдүүлээ ингэе ингэе гэдэг юмнуудаа яриад, мөнгө төгрөгөө тохирчихсон байхад тэр дээр новшроод хулхидаад дарга нар чинь ухаантай царайлчих юм бол энэ дээрээ шууд/минут дуусав/

Б.Бейсен: Мандхай гишүүн хариулъя. Санал хэлсэн юм уу. Санал хэлсэн байна. Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Баярлалаа. Анхдагч хуулийн төслийг бас дэмжиж байгаа. Бас өргөн барьсан хүмүүсийн бүрэлдэхүүнд бас байгаа юм. Одоо хэлэлцэх эсэх асуудлын тухай бид бүхэн ярьж байна. D-Parliament дээр бас орсон хувилбар дээр тодорхой бас иргэд олон нийтийн саналуудыг бас авч, 2, 3 шатны хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан байгаа. Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хамгийн эхэнд өгчих нь зөв гэж бодож байна. Яг нарийвчлаад 2 асуултыг тодруулаад бас манайхан нэмээд хэлэх нь зөв байх гэж бодож байна.

Боловсон хүчинтэй холбогдолтой асуудал дээр бас янз янзын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээд эхэлсэн байгаа. Малчны тухай хуульд заасан нэг боломж нь бол 10 жилээс дээш мал маллаж байгаа малчин иргэдийн хүүхдийг Мал аж ахуй, тэжээл бэлтгэлийн чиглэлээр сургана гэдэг ийм зохицуулалтыг оруулаад ингээд явж байгаа. Энэ хөтөлбөр, арга хэмжээний бас үр дүнг Гүрээ захирал ирсэн байх шиг байна. Олон нийтэд танилцуулчих нь зөв гэж бодож байна. Энэ намрын элсэлтүүд ямар байсан бэ гээд. Энийг танилцуулж байгаа нь цаашдаа анхдагч хуулиар өөр бусад ямар боломжуудыг эрэлхийлж явах нь зөв бэ гэдэг бид нар ийм бэлэн туршлагатай болж авч байгаа юм. Энэ зөв юм уу, буруу юм уу гэдгийг харах боломжтой болж авч байгаа юм.

Хамгийн чухал 1 зүйлийг бид нар энэ хуулиараа бий болгох боломжууд юу байх вэ гэдэг дээр нэлээн сайн бас цаашдаа анхаарал хандуулж бас явна гэж бодож байгаа. Ер нь бүхий л улс үндэстэн хөдөө аж ахуйн салбараа тодорхой бодлогын хүрээнд дэмжлэг урамшууллын тодорхой бодлогын хүрээнд дэмжиж босгож ирдэг. Тэгээд энэ байгалийн эрс тэс нөхцөл байдалд байгаа энэ салбарын гол анхан шатад ажиллаж байгаа малчид, тариаланчдыг дэмжих бодлогууд бол тогтвортой явах ийм зайлшгүй шаардлагууд бас байдаг. Тэгэхээр шат шатад түүхий эд бэлтгэлийн шат шатад тодорхой бодлого, дэмжлэгүүдийг илүү тогтворжуулах чиглэл дээр гол анхаарлууд энэ дээр байгаа байх. Ялангуяа манай хэрэгжиж байгаа энэ Хүнсний хувьсгал, Цагаан алт, Шинэ хоршоо гээд эдгээр хөтөлбөрүүд аль нэгэн сайд, аль нэгэн удирдлагаас үл хамаараад цаашдаа тогтвортой үргэлжлээд явах энэ боломж, бололцоо энэхүү хуулиар олдох уу. Ялангуяа энэ дэмжлэгийн механизмыг бид бүхэн энэ салбарыг ойлгодог, мэддэг хэн нэгэн гарч ирэхийг хүлээх биш, цаанаасаа суурь асуудал нь хийгдээд явах энэ боломжийг бий болгох, цаашилбал хөдөө аж ахуйг дэмжих санхүүгийн ийм чиглэлийн банктэй болох энэ тэр гээд олон асуудлын тухай бид бүхэн бас тодорхой саналуудыг ярьдаг. Тэгэхээр энэ хүрээнд яаж тусчих вэ гэдгийг бас дэлгэрүүлээд мэдээлэл өгчих нь зөв байх гэж бодож байна. Ингээд 3 асуулт.

Б.Бейсен: Мандхай гишүүн хариулъя.

М.Мандхай: Ганхүлэг гишүүндээ баярлалаа. Бас их чухал асуудал хөндөж байгаа учраас. Тэгээд ер нь бол хүний нөөцийн асуудал угаасаа яалт ч үгүй хөдөө аж ахуйн салбарт тулгамдаж байгаа асуудлын нэг болсон учраас бид нар хүнсээ гол хангаж байгаа салбарынхаа хүний нөөцийг бэлдэхгүйгээр энэ салбар бол явахгүй. Тэгээд түүний бас нэг гол хүний нөөц бол өөрөө мэдээж түүхий эд бэлдэж байгаа малчид маань байгаа. Тэгэхээр бид нар малчныг сургах, мэдлэг туршлага солилцох, тэдгээрийн залгамж халааг бэлтгэхтэй холбогдсон харилцаа бол өөрөө Малчны тухай хуулиар нарийвчлан зохицуулагдаж байгаа. Гэхдээ бид нар аль болох энэ хүний нөөцийн сургалтын зардлыг орон нутгийн төсвөөс нь хариуцаж төгсөлтийн дараах ажлын байранд нь ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд бас дэмжлэг үзүүлэхээр ажиллаж байгаа. Яагаад гэхээр энэ хуульд өөрөө тогтвортой хөдөө аж ахуйг явуулахын тулд мэдээж яам бол өөрөө бодлогоороо дэмжинэ. Бусад аймаг, орон нутгийн түвшинд бол өөрсдийнхөө аймаг сумын хөдөө аж ахуйн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг боловсруулаад, тэгээд түүндээ тохирсон хүний нөөцийн эрэлт хэрэгцээг тодорхойлоод, ингэж байж энэ эрэлт нийлүүлэлтийн судалгаа дээр түшиглэж байж хүний нөөцийг нь бэлдэхэд өөрөө орон нутаг дэмждэг, эргээд тэрийгээ ажлын байраар хангах тэр орчныг бүрдүүлэх дээр бол нарийн бас заалтыг тусгаж өгсөн байгаа. Яг одоо хэрэгжиж байгаа Хүнсний хувьсгал, Атрын 4 дүгээр аян ч гэдэг юм уу, Цагаан алт, Шинэ хоршоо гэсэн хөдөлгөөнүүдийн хүрээнд хүний нөөц, боловсон хүчнийг бэлтгэх асуудлыг бол ХААИС бол яг хариуцаад, хөтөлбөрүүдийг боловсруулаад, сургагч багш нарыг бэлдээд явж байгаа. Тэгээд энэнтэй холбоотой нарийвчилсан мэдээллүүдийг Гүрбазар багш мэдээлэл хуваалцана.

Б.Бейсен: 3 номер хариулъя.

Д.Гүрбазар: Та бүхэнд баярлалаа. Өнөөдрийн байдлаар Малчны тухай хуулийн зохицуулалтын хүрээнд мал аж ахуй, тэжээл, бэлчээр судлал чиглэлээр мөн Мал аж ахуй, мал зүйчийн чиглэлээр гээд нийтдээ энэ жилийн шинээр элссэн оюутны тоо бол 70 орчим хүн байна. Мөн дээрээс нь эчнээ хэлбэрээр орж ирж байгаа, бүртгэл явагдаж байгаа одоогийн байдлаар бас 20 гаруй. Ингээд нийтдээ энэ жилийн хувьд бол яг энэ хуульд заасан 2 хөтөлбөрийн хүрээнд 100 орчим хүүхэд элсчих байх гэсэн ийм бодолтой байна. Өдрийн ангид буюу 4 жилийнхээр Мал аж ахуй дээр 27 хүүхэд байна. Тэжээл бэлчээр дээр 20 орчим хүүхэд байна. Мал зүйгээрээ ахиад 20 орчим гээд бодохоор 70 гаруй хүүхэд энэ жилийн хувьд нэмэгдсэн. Өнөөдрийн байдлаар манай дээр яг Мал аж ахуй, тэжээл бэлчээрийн хүрээнд дээр суралцаж байгаа 300 орчим оюутан байж байна гэсэн үг.

Ер нь бол энэ хуулийн хүрээнд бас нэмэлтээр тусалсан байгаа асуудал бол малчныг давтан сургахаас гадна албан болон албан бус сургалтуудыг хийх, мөн бэлтгэгдсэн боловсон хүчнүүдийг давтан .../минут дуусав/

Б.Бейсен: 3 номер гүйцээж хариулъя.

Д.Гүрбазар: Давтан сургалтаар мэргэжил дээшлүүлэх заалтууд бас энэ дээр туссан байж байгаа.

Б.Бейсен: Мандхай гишүүн тодруулаад хариулъя.

М.Мандхай: Мэдээж ХААИС-ийн бас сургалтын хүрээ бол мэдээж тоотой. Тэгэхээр бид нар энэ хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн албан болон албан бус сургалтаар боловсрол эзэмших, бие даан суралцахад мэдээллээр хангах, зөвлөн туслах, мэргэшүүлэх, сургах чиг үүргийг Хөдөө аж ахуйн чиглэлийн

сургалтын байгууллага, салбарын судалгаа хөгжлийн болон бусад сургалтын төв, мэргэжлийн холбоо, насан туршийн суралцахуйн төв тус тус хэрэгжүүлнэ гэж зааж өгснөөрөө илүү эдгээр байгууллагуудыг хөдөө аж ахуйн албан болон албан бус сургалтуудыг бас явуулах тэр нөхцөлийг бас хуульдаа зааж өгснөөр яг энэ чиглэлийн сургалтууд бас нэлээн хөгжих ийм орчныг энэ хуулиараа зохицуулж өгсөн байгаа.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Тэгэхээр яах вэ, Гүрээ захирал аа. Ер нь цаашид илүү яаж өргөжүүлэх тал дээр нь бас жоохон саналуудаа илүү нарийвчлаад бас гаргаад явсан нь дээр байх. Тодорхой, маш тодорхой заалтаар оруулаад, ямар үр дүн гарч байна вэ гэдгийг одоо бид нар хэмжих боломжтой болж байгаа юм. Тэгэхээр энийг ер нь илүү өргөжүүлэх ёстой юу, үгүй юу гэдэг дээр бусад кэйсүүдээ ч гэсэн тариалангийн чиглэлээр, бусад чиглэлээр иймэрхүү хөтөлбөрүүд байх нь үр дүнтэй юу, үгүй юу гэдгийг бид нар харж болж байна гэсэн санаа юм байгаа юм.

2 дахь нь тэр хэлэлцүүлэгтэй холбогдолтой мэдээллийг бас эхэлж байгаа учраас бас хэлчих нь зөв байх. Эрдэмтэд ажлын хэсэг мөн 2, 3 удаагийн уулзалтууд гарч, энд анхны төслөөсөө ямар ямар байдлаар өөрчлөгдөөд явж байна вэ гэдгийг.

3 дахь нь хүнсний хувьсгалын хөтөлбөр 2 жилийн дараа зогсоно. 5 жилийн хөтөлбөр байгаа. 3, 4 дэх жил рүүгээ орсон байгаа. Атрын хөтөлбөр бас тодорхой хугацааны дараа яваад дуусна. Хоршоо хөдөлгөөн 2 дахь жил рүүгээ орсон. Цагаан алт бас ингээд явж байгаа гээд ингээд хамгийн ихдээ 5 жил болоод энэ хөтөлбөрүүд бол дуусчихна. Тэгэхээр энэ хөнгөлөлттэй зээлүүд зогсох уу л гэж асуу байгаад байгаа юм.

Б.Бейсен: Мандхай гишүүн хариулъя.

М.Мандхай: Нийтдээ үндсэндээ D-Parliament дээр хуулийн төсөл танилцуулга үзэл баримтлалыг бол тавихад 100 гаруй иргэд, мэргэжлийн байгууллагуудаас санал ирсэн. 2 удаагийн хэлэлцүүлгээр бид нар эхний хэлэлцүүлгийг илүү фермер, малчдын төлөөлөл, мэдээж бас бодлогын яам агентлаг, мэргэжлийн байгууллагуудыг төлөөлж хэлэлцүүлэг хийгээд, мөн 2 дахь хэлэлцүүлэг дээр бас гишүүдэд зориулсан бас хэлэлцүүлэг хийж, санал бодлыг нь бас илүү хуулийг боловсронгуй болгох дээр авсан байгаа. Энэ дээр бол олон саналууд бол ирсэн. Тэгээд энэ дээр 1 дүгээрт Хөдөө аж ахуйн түүхий эд үнэгүйдэж байгаа асуудал, ялангуяа малчдын түүхий эдийг илүү яаж үнэ цэнтэй болгох вэ, энэ дээр хууль дээр нарийвчилж тусгах саналыг бол илэрхийлсэн..../минут дуусав/

Б.Бейсен: Ер нь хөтөлбөр аян хугацаа нь дуусчихаараа зогсох биш тухайн юуг тогтворжуулж авч явах тухайн салбарын асуудал гэдгийг салбарынхан бас анхааралдаа авах нь зөв байх. 6 номер нэмж хариулъя гэж байна.

А.Бакей: Энэ төрийн бодлого бол залгамж чанартай явах ёстой л доо уг нь бол. Тэр нь ямар хөтөлбөр байна гэдгээсээ хамаарахгүйгээр урт хугацаа, дунд урт хугацаанд залгамж чанартай хэрэгжих ёстой. Тэр ерөнхий тийм зарчим бол энд тусгагдсан.

Дээр нь төрөөс үзүүлэх дэмжлэг гэдэг дээр бол хөнгөлөлттэй зээл, зээлийн хүүгийн хөнгөлөлт гэсэн тийм хэлбэрийг заасан байна. Газар тариалангийн

үйлдвэрлэлд бол одоогийн байдлаар хуучин Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Хөдөө аж ахуйг дэмжих сан гэсэн нэртэй тэр сан бол хүчингүй болоод Хөдөө аж ахуйн корпорацаар дамжиж газар тариалан үйлдвэрлэлд голдуу дэмжлэг үзүүлж байгаа. Малчны тухай хуулиар бол малчны хөгжлийн сан гээд сумдын түвшинд байгуулахаар заасан байгаа шүү дээ. Энэ бол уг нь чухал санаа. Тэгэхдээ одоохондоо тэр хуулийн яг тэр хэрэгжилт бол .../минут дуусав/

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, хариултаа авч дууслаа. Хууль санаачлагчийн танилцуулгатай холбогдуулан санал хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү. Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Туваан гишүүн үг хэлье.

Ц.Туваан: Тэгээд хууль орж ирж байгаа, тэгээд хэлэлцэх эсэхээ шийдээд ажлын хэсэг байгуулаад, тэгээд цаашаа ингээд хэлэлцүүлгүүд явах байх. Тэгэхээр ер нь бол нэлээн ерөнхий харагдаж байна. Тэгэхээр ер нь хэдүүлээ бас нэгэнт л хууль оруулж байгаа юм чинь салбар салбартаа бодитой, дорвитой ийм тодорхой өөрчлөлтүүдийг хийсэн ийм заалт оруулчихмаар байна гэсэн саналаа дахиж хэлье.

Тэгээд мэдээж хөдөө аж ахуйн малгай хууль учраас голчилж байгаа энэ томоохон салбарууд, мөн энэ дээр тэр судалгаа шинжилгээ, шинжлэх ухаан талынхаа асуудлуудыг бас нэлээн оруулж өгсөн нь зөв байх. Энэ дээр манай зөвлөхүүд бас байгаа юм чинь харсан байх тийм ээ. Одоо манайд бол энэ Хөдөө аж ахуйн салбарын шинжлэх ухааны асуудал бол бас нэлээн орхигдчихоод явж байгаа. Тэгэхээр энэ тал руу баримтлах төрийн бодлого, тодорхой энэ салбар луу орж ирэх санхүүжилтийн асуудлыг ч гэсэн бас энэ дээр ярьсан нь зөв байх гэж ингэж бодож байна.

Тэгээд энэ дээр бас нэг харсан зүйл нь 19 дээр юм уу Хөдөө аж ахуйн салбар дахь төрийн удирдлага зохицуулалт гэдэг дээр 19.2 дээр Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд мал таримал гэхээд биш ээ биш 19.1 дээр юм байна. Салбарын бодлого боловсруулалт төлөвлөх, хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих, дүн шинжилгээ хийх гээд энэ дээр нөгөө бас л нөгөө манайханд яам сайд авахаараа ингээд салбарын ялангуяа нөгөө тогтолцооны асуудал, орон нутагт дунд шатанд байгаа анхан шатанд байгаа тогтолцоонуудын асуудлыг л хөнддөг л дөө. Тэгээд энэ зарим аймгийн удирдлагууд энэ тэр чинь ярьж байна шүү дээ. Бид нар ер нь энд нэг Засаг дарга гээд, аймгийн удирдлага гээд, дүүрэг, нийслэлийн удирдлага гээд суугаад байдаг бүх агентлаг, хэрэгжүүлж байгаа газрууд нь босоо тогтолцоотой болчихсон. Тэгээд тэд нартай ерөөсөө уялдаж ажилладаггүй, үр дүн өгдөггүй. Орон нутгийнхаа Засаг даргын үгэнд орж бодлогоо нэгтгэж ингэж явдаггүй, намайг томилдог газар нь дээрээ гэсэн байдалтай ийм хандлага ер нь түгээмэл болчихсон. Одоо суман дээр, аймаг дээр байгаа сумын Засаг дарга, аймгийн Засаг дарга нар чинь 4, 5 хүнийг томилох эрх нь үлдсэн. Бусдыг нь 1, 2-оор нь Нийгмийн даатгал, халамж юу гэдэг юм, газар гээд бүгдийг нь авсаар байгаад тэр томилгоо дээр нь, хамтарч ажиллах тэр Тамгын газрын баг дээр нь маш том асуудал үүсэж байгаа юм байна лээ шүү дээ. Тэгэхээр энийг энэ дотор миний ойлгож байгаа зөв үү, буруу юу. Аймгийн хөдөө аж ахуйн газар сумд байгаа тэр хөдөө аж ахуйн болон мал эмнэлгийн тасгуудад ажиллах хүний асуудлыг нь яаж оруулж ирж байгаа юм бэ гэдгийг дараа нь надад танилцуулаад хэлчхээрэй. Тэгсэн, тэгээгүй ер нь бол суманд ний нуугүй хэлэхэд мал эмнэлгийн асуудал хариуцсан байцаагч, тэр эпидемиологич энэ тэр бол маш ховор байгаа шүү дээ. Тэгээд 1 хүн нь хавсран гүйцэтгэсэн нэртэй ингээд л явж байдаг. Огт газар тариалан байхгүй, эрхэлдэггүй сумуудад гэхэд газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтний орон тоог хатуу яг заагаад өгчихсөн

байж байх жишээтэй гэх мэт ийм асуудлууд байна лээ шүү. Тэгэхээр энийг бас хэдүүлээ нэлээн ярилцаад, үр дүн нь гаргасан хууль болоосой гэж бодож байна.

Б.Бейсен: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Хөдөө аж ахуйн тухайн анхдагч хуулийн төслийг дэмжиж байгаа. Би бас санаачлагч гишүүдийн хамт явж байгаа. Энэ хуулийн төслийг бид нар бас зайлшгүй дэмжих шаардлагатай байгаа. Өнөөдөр тогтвортой хөдөө аж ахуйтай холбоотой асуудлуудыг бид нар хөндөхөөс өөр аргагүй ийм цаг хугацаанд оччихсон. Хөдөө аж ахуйн бодлого яагаад тогтворгүй болов. Тогтворгүй нөхцөл байдалтай улбаатай ямар хор хохирлууд үүсэж байна. Бодлогын тогтворгүй байдалтайгаас улбаатайгаар ирээдүйд үүсэж байгаа эрсдэлүүд юу байна гэдгийг бид нар их сайн тооцож байх ёстой юм байна лээ. Тэгээд өнөөдөр энэ тогтвортой хөдөө аж ахуйг ялангуяа хөгжүүлэх зорилготой улсын хэмжээнд дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөртэй байхаар хуульчилж өгч байгаа нь бол энэ хууль дээр бас маш том давуу талыг бий болгож байгаа болов уу гэж харж байгаа.

Дээрээс нь өртгийн сүлжээний асуудал, ялангуяа бүртгэл мэдээллийн асуудлыг бид нар зайлшгүй нэг цогц болгож авах шаардлагатай байгаа. Энэ асуудлууд энэ хуульд бол орж өгч байгаа.

Дээрээс нь түүхий эд, бүтээгдэхүүний өртгийн сүлжээ, түүхий эд, бүтээгдэхүүний чанарын үнэлгээ, баталгаажуулалтын асуудлуудыг бас бид нар хуульд оруулж өгч байгаа. Тэгээд энэ бол бас нэлээн томоохон давуу талуудыг оруулж, ойлгомжтой болж өгч байгаа болов уу гэж харж байгаа.

Бас 1 нэр томьёо орж ирсэн. Хөдөө аж ахуйн аялал жуулчлал гэдэг нэр томьёог бас оруулж өгсөн нь маш сайшаалтай байгаа. Хөдөө аж ахуйн аялал жуулчлалыг бид нар цааш хөгжүүлснээрээ зөвхөн хөдөө аж ахуйн бараа, түүхий эд, бүтээгдэхүүн, мал аж ахуйгаас орлого олохоосоо гадна дагнасан аялал жуулчлалын салбарыг бий болгож бид нар тодорхой хэмжээнд эндээс бол гаднаас доллар оруулж ирэх томоохон процессууд бол хөндөгдөнө гэдгийг хэлье.

Хүний нөөцтэй холбоотой асуудлыг бол маш сайн шийдвэрлэхээр түвшинд бас хуульчилж голлон анхаарч байгаад сайшаалтай байгаа. Яах вэ, цаашдаа бид нар хэлэлцэхийг нь дэмжээд яваад ингэхээрээ 1 зүйлийг л анхаарах ёстой юм шиг санагдаад байгаа юм. Тэгээд сая бас Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд манай Энхгэрэл бас орсон байх шиг байна. Байгал орчин, аялал жуулчлалын яаманд бас ажиллаж байсан. Бид нар энэ бэлчээртэй холбоотой асуудлуудыг их сайн бодох хэрэгтэй байгаад байгаа юм.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам маань байгаль орчны төлөв байдлын тайлан буюу байгаль орчны төлөв байдлаа хариуцдаг. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам бэлчээрээ хариуцдаг. Ингээд бие биеийнхээ ажил руу ордоггүй байхгүй юу. Тэдний ажил, тэдний ажил гээд шахчихдаг. Гэтэл байгаль орчин нь нэг асуудал байгаад байдаг. Уур амьсгалын өөрчлөлт нь нэг асуудал байгаад байдаг. Үүнээс улбаатай орхигдсон хэлбэр бол өнөөдөр ний нуугүй хэлэхэд бэлчээр болчихоод байгаа юм. Тийм учраас хуульд энэ хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн газар буюу 13 дугаар зүйл дээр бэлчээртэй холбоотой асуудлуудыг тусгаж өгөөд, дагалдахаар Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ийм өөрчлөлтүүд орж байгаа. Энэ дээр зүгээр 1 зүйлийг бид нар цаашдаа их ялгаж салгаж ойлгохгүй бол бас болохоо больчихоод байгаа юм. Яаж оруулахаа бид нар

ярих ёстой юм байна лээ. Тусгай хамгаалалттай газар нутаг Монгол Улсын нийт газар нутгийн 21% буюу өнөөгийн Польш улсын газар нутаг тэр чигтээ байгаа. 2030 он гэхэд өнөөгийн Тайландын газар нутаг тэр чигтээ Монгол Улсын тусгай хамгаалалтад орох хэмжээний ийм том газар нутгийг Монгол Улс тусгай хамгаалалтад авах гэж байгаа юм. Энэ Тусгай хамгаалалттай газар нутаг дээр бэлчээр байгаа. Нөгөө малчид байгаа. Өвөлжөө, хаваржаа байгаа. Энийг бид нарыа энэ хуульдаа цэгцэлж оруулж өгөх вэ гэдгийг л ажлын хэсэг дээрээ хэдүүлээ бас давхар ярьж байгаад, ялангуяа энэ бэлчээрийн болон мал услах уст цэг, худгийг, худаг хоорондын зай байршлыг усны нөөц, ус цэгийн хайгуул судалгааны дүнд үндэслээд, аймаг, нийслэл, сум дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгана гээд оруулчихсан учраас энэ асуудлуудыг бид нар их сайн харах ёстой. Тусгай хамгаалалттай газар нутаг сум, дүүрэг, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусаж чадахгүй л дээ. Тусдаа хуультай учраас. Байгаль орчны яам тусдаа тусгадаг. Тэгэхээр энэ асуудлыг бол бид нар ялангуяа цаашдаа их сайн ажлын хэсэг байгуулагдаад ажиллаад явахаар анхаараад явна. Хамтраад ажиллацгаая гэж хэлэх гэж байгаа юм. Дэмжиж байна.

Б.Бейсен: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн үг хэлье.

С.Ганбаатар: Энэ хуулийг хэлэлцээд явахыг дэмжилгүй яах вэ. Огт хоосноос хамаагүй дээр шүү дээ. Ямар нэгэн юмтай байх нь. Харин энэ хууль нэг мөрөөдлийн шинж чанартай, бэлгэ тэмдгийн ч шинж чанартай болчихгүйн тулд ярьж байгаа. Одоо энэ хуулийн төлөө энэ зөвлөхүүддээ их баярлаж байна. Амьдралаа зориулж энэ салбарын төлөө бүх судалгаа шинжилгээг хийсэн хүмүүсийн дуу хоолой их хүчтэй байгаасай.

Түрүүн тэр маш чухал юм ярьсан. Тэр Батсуурь дарга ярьсан. Баялгийн сантай холбох гэдэг бол хамгийн чухал. Яагаад баялгийн сан бий болсон бэ гэвэл энэ хэдэн бэлчээр, мал аж ахуйн салбарыг, тариаланчдын ч байна уу салбарыг л дээрэлхэж байж бий болгосон баялаг. Энийг бол шулуухан оруулах ёстой. Нэлээн тодорхой.

2 дугаарт энэ салбар чинь хөдөө аж ахуйн салбар чинь ерөөсөө тэр чигээрээ хоорондын үл ойлголцол шүү дээ. Малчид нь хоорондоо үл ойлголцоно. Бэлчээрээсээ булаацалдана. Тэгээд л дараа нь тариаланчид. Тэгээд хүнсний ногоо тариаланчид. Тэгээд энэ салбарын хоорондын интеграци гэж яриад байгаа, хоорондын ойлгоцыг сайжруулахын тулд тэр салбарын хэлэлцээр гэдгийг шинэ шатанд гаргах нь олон улсад байдаг ганц тэргүүн туршлага нь шүү. Тэгэхгүй зүгээр яриад, нэг юм хэлэлцээд, гарын үсэг зураад тэрийг нь хэн ч тоодоггүй бол өнөөдрийн Монгол шиг. Тийм бол тэгээд л будаа. Тэгээд сайд, яамдынхан ойлгоосой. Одоо би энийг чадна гээд л ханцуй шамлаад л дайраад байхын оронд энийг надаас илүү хэн чадах вэ гэдгийг байнга асуугаарай. Эрдэмтэн, салбарын эрдэмтэн судлаачид, хамгийн гол нь салбарын оролцогчид тэр мал аж ахуй, хөдөө аж ахуй, ноолуур ноос юу ч байдаг юм. Эдний оролцоог хангаж шийдвэр гаргах түвшинд оролцуулах, тэгэхдээ судлаачдынхаа дүгнэлтийг тойрч ярьдаг механизмд орж байж энэ хууль хэрэгжих үндсэн санаа гэдгээ л би хэлж байгаа юм.

Тэгээд 2-т нь ганц юм хэлээд, нэлээн их ярих байлгүй дээ чуулган дээр. Хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбар бол ажлын байр бий болгодог, хүмүүсийг орлоготой болгодог. Монгол оронд өнөөдөр мөнгө дутаагүй шүү дээ. Харин ажлын байр орлого л дутаж байгаа. Хөдөө аж ахуйн салбараа додомдож урдаа барихгүй л бол Засгийн газар, Улсын Их Хурлын 1 номерын зорилго бол ажлын байр. Энийг нь ганц шийдэх юм нь хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбар. Тэгэхээр үндэсний аюулгүй байдал нэг

их тийм мөнгө бодохгүйгээр үр дүн бодож зүтгэдэг салбарын хууль ярьж байгаа учраас энэ дээр хэдүүлээ нэлээн даацтайнхан орно. Тэгээд хууль батлах гэж байгаа хүмүүсээсээ бэргээд, арай ч даварчих болов уу гэж бодохгүйгээр санаануудаа хэрэгжихүйц механизмуудаа оруулаад үзвэл яадаг бол гэсэн эр зоригийг би энд бас хэлмээр байна. Баярлалаа та бүхэнд.

Б.Бейсен: Гишүүд санал хэлж дууслаа.

Хөдөө аж ахуйн хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалт. Би дэмжсэн, Замира гишүүн дэмжсэнээр. 65 хувиар дэмжигдлээ. Жаргалсайхан гишүүнийг дэмжсэнээр үү.

Хөдөө аж ахуйн хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг дэмжих эсэхээр санал хураалт явуулъя.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдээрэй. Санал хураалт. Гомбын Ганбаатар, Сайнхүүгийн Ганбаатар гишүүн дэмжсэнээр аваарай. 70 хувиар санал дэмжигдлээ. Мөнхбаясгалан гишүүн дэмжсэнээр аваарай.

Дараагийн санал. Малчдын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 76,2 хувиар санал дэмжигдлээ. Мөнхбаясгалан гишүүн дэмжсэнээр аваарай. Гишүүд анхааралтай байгаарай.

Тариалангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 76,2 хувиар дэмжигдлээ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 81 хувиар санал дэмжигдлээ.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 76,2 хувиар дэмжигдлээ.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 81 хувиар дэмжигдлээ.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Би дэмжсэн юм. Буруу ороод байх юм. 81,8 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Цэвэгдоржийн Туваан гишүүн танилцуулна.

Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа.

15.39 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд хэлэлцэж эхэлье.

Хууль санаачлагчийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Хөдөө аж ахуйн дэд хорооны дарга Мандхай танилцуулна. Мандхай гишүүний микрофон.

М.Мандхай: Баярлалаа. Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулгыг та бүхэнд танилцуулъя.

Монгол Улс нэгдэн орсон буюу соёрхон баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын фактад хүн бүр хоол хүнс оролцуулаад өрхийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрх, нэн тэргүүнд өлсгөлөн тэжээлийн доройтлоос ангид байх эрхийг онцлон заасан.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4.2.1-д “хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, физиологийн зохистой нормд нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж, Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 2.5-д “амьдралын хэрэгцээг хангасан эрүүл, ая тухтай, таатай орчныг бүрдүүлж, баталгаат хүнсээр хангана.” гэж. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамжийн 54%-ийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, 46% нь импортын хамааралтай байгаа нь хүнсний хангамж тогтворгүй эрсдэлтэй түвшинд байна. Хүнсний хүртээмж нь газар зүйн байршлаас хамаарч харилцан адилгүй байгаа бөгөөд хөдөө мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, ургамлын тосыг улсын дунджаас давж, хотод гурилан бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, өндөг, цөцгийн тос, сахар, чихэрлэг хүнсийг улсын дунджаас давж хэрэглэж байна.

Статистикийн мэдээгээр ядуурлын хамааралтын түвшин 2016 онд 29,6%, 2018 онд 28,4%, 2020 онд 27,8%-тай байсан бол 2022 оны байдлаар 27,1% болж буурсан байна. Хэдийгээр ядуурлын түвшин буурсан ч ядууралд ойрхон байгаа хүмүүсийн аливаа сөрөг хямрал, ялангуяа эдийн засаг, үнэ, уур амьсгал, эрүүл мэнд гэх мэт эдгээр асуудал үүсэхэд эргээд ядууралд өртөх эрсдэлтэй эдгээр хүмүүсийн хувьд хүнс хүртэх боломж маш хангалтгүй байна.

2017, 2023 онд хийсэн хүн амын тэжээлийн байдал үндэсний 5, 6 дугаар судалгааны дүнг харьцуулахад хүн амын дундах хоол тэжээлийн дутал буураагүй байгаа нь зохистой хооллох мэдлэг, дадал дутмаг, хоол хүнсний хяналтгүй, хэрэглээтэй холбоотой, шим тэжээлгүй хоол хүнсийг хэрэглэснээс таргалах өвчлөх зэрэг сөрөг үр дагаврууд илэрч байна. Хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь хүнсний аюулгүй байдлыг хангах болон түүнд хяналт тавих тогтолцоо гажуудалд орсонтой холбоотой. Мөн дотоодын үйлдвэрлэл, хүнсний шимт байдал, хүнсний зохистой хэрэглээтэй холбоотой харилцааг дутуу зохицуулсантай холбоотой байна.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ба дараах харилцааг зохицуулахаар тусгасан болно. Үүнд:

Олон улсын жишигт нийцүүлэн хүнсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо, түүнтэй холбогдох зохицуулалтыг иж бүрэн тусгасан. Хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогын чиглэлийг тодорхойлж, тэдгээрийн боловсруулах үндэслэл болон тандалт судалгааг хөгжүүлэх, мөн хоол хүнснээс гаралтай халдварт бус өвчлөл бууруулах зорилгоор хүн, мал, амьтан, ургамал, байгаль орчны эрүүл, аюулгүй байдлын харилцан шүтэлцээг хангах талаар 1 эрүүл мэндийн зарчмыг тусгана.

Хүнсний сүлжээ гэж хүнсний анхан шатны үйлдвэрлэл эрхлэгч, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, баяжуулах, дахин боловсруулах, савлах, тээвэрлэх, хадгалах, нөөцлөх, экспортлох, импортлох, хоол үйлдвэрлэх, хүнсний бүтээгдэхүүний тусламжаар авах, өгөх үйл ажиллагаа байдаг. Гэтэл хүнсний тээвэрлэлт, хадгалалт, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хүнсний худалдаа, түгээлт, хүнс, импортоор авахтай холбоотой харилцаа Хүнсний хуулиар зохицуулалтгүй орхигджээ. Хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх шаардлагын үүднээс нэр томьёог ойлгомжтой томьёолж, олон улсын жишигт нийцүүлэх, хүнсний салбарын хяналтыг төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж байгааг өөрчилж, хүнсний хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэхээр заана. Үүнтэй холбоотой хүнсний үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, хоол үйлдвэрлэл, хүнсний био аюулгүй байдлын хяналтын хүрээнд шошго, зохистой дадлын хэрэгжилт, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналт, хүнсний буцаан таталт, устгал, ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хяналт тавих үйл ажиллагаа сайжирна. Монгол Улсын хүнсний импортын хамаарлын түвшин буурах, салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, тогтвортой ажиллуулах зорилгоор мэргэжлийн сургалт, мэргэжлийн зэрэг олгохтой холбоотой харилцааг тусгах.

Ач холбогдлын хувьд энэ хууль батлагдсанаар хүнсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо иж бүрэн, цогц байдлаар хэрэгжиж, хүнсний баталгаат байдал сайжрах төдийгүй хүнсний экспортын чанар сайжирч олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдэнэ. Төр, хувийн хэвшлийн хамтын хүчин чармайлтаар салбарын хүний нөөцийг чадавхжуулснаар хүнсний сүлжээний бүхий л үйл ажиллагаа мэргэжлийн удирдлагаар хангагдах нөхцөл бүрдэнэ.

Б.Бейсен: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хүрэлцэн ирсэн ажлын хэсгийг танилцуулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Довчинсүрэн Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Есөн-Эрдэнэ Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Батшагай Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүрэг түр орлон гүйцэтгэгч, Д.Энхмаа Хүнсний аюулгүй байдлын шинжээч, доктор, Ж.Туяацэцэг зөвлөх инженер, доктор, дэд профессор, Б.Алтанцэцэг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын хууль бодлогын мэргэжилтэн.

Хууль санаачлагчийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Ундраа гишүүнээр тасалъя. Мэндсайхан гишүүнийг нэмье. Батчимэг гишүүний асуулт асууя.

П.Батчимэг: Мандхай гишүүний өргөн мэдүүлсэн Хүнсний тухай хуулийг үндсэндээ бол үнэхээр дэмжиж байгаа. Монгол Улсын хэмжээнд хүнсний аюулгүй байдлын баталгаат байдал алдагдсан гэдэг нь бол бүр үнэхээр дээд хэмжээндээ тулчихсан ийм тулгамдсан асуудал болоод байгаа. Тэгэхээр энэ хууль

санаачлагчийн зүгээс хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан гээд бид нарт ирсэн байгаа юм. Энэ тайлангаас үзэхээр хуулийн хэрэгжилтийг анхны суурь Хүнсний тухай энэ хууль бол 2012 онд батлагдсан байгаа. Энэ 12, 13 жилийн түүхтэй Хүнсний тухай хууль батлагдсанаас хойш хэрэгжилтийг ер нь бараг анх удаа л тайлагнаж байна л гэж харж байна л даа. Тэгэхээр энэ тайланд тусгаснаар 32,5%-тай хуулийн хэрэгжилт явж иржээ. Энэ чинь ер нь ямар тоо юм бэ. Тэгэхээр ер нь Монгол Улсад иргэд маань ер нь бид хоол идээд байгаа юм уу, хор идээд байгаа юм уу гэдгээ одоо бодох цаг болсон. Өнгөрсөн чуулган дээр би бас хаврын чуулган дээр ярьж л байсан. Хүнсний тусгай лабораторитой больё. Шинжилгээ хийдэг. Одоо ингээд хуулийн төсөл ороод ирлээ. Тэгэхээр бид энэ асуудлыг маш нухацтай ярьж, энэ удаагийн энэ хэлэлцүүлэг дээр гишүүд маш нухацтай хандаасай гэж би хүсэж байна.

Тэгэхээр өнөөдрийн хуулийн зохицуулалт үндсэндээ 70% байгаа энэ анхаарал татаж байгаа тоо цаашдаа одоо ер нь яах юм. Хууль батлагдсанаар ер нь хэдэд хүрэх юм. Энэ хүнсний аюулгүй байдал бодит байдалд 30%-тай хангагдаж байна гэсэн чинь ер нь энийг юу гэж ойлгож авах юм бэ. Тэгэхээр Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийж байгаа энэ үнэлгээ холбогдох төрийн захиргааны төв байгууллага энэ Хүнс, хөдөө аж ахуйн яам өнөөдөр хүмүүс нь ирсэн үү. Ер нь бол 5 жил тутамдаа хийж байх ёстой. Тэгэхээр ер нь хийж явсан юм уу. Одоо энэ 13 жилийн хугацаанд өнөө хүртэл энэ хуулийнхаа хэрэгжилтийг үнэлэхгүй яваад байсан гэж үзэж болох уу.

Бас энэ тайланд Монгол Улсад хүнсний аюулгүй байдал хангагдахгүй байх нөхцөл шалтгааныг хүнсний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа өнөөдөр 200 мянган аж ахуйн нэгж гэж байгаа юм. Энэ зохистой дадлын стандартыг нэвтрүүлээгүй, зохистой дадал нэвтрүүлснийг баталгаажуулдаг итгэмжлэгдсэн ийм баталгаажуулалтын байгууллагын тоо улсын хэмжээнд 2 байгаа. Үүнтэй холбоотой гээд дүгнэчихсэн байгаа юм. Хуулийн төсөлд аж ахуйн нэгжүүдийн зохистой дадлыг нэвтрүүлснээр заавал баталгаажуулахыг үүрэг болгох ийм зохицуулалт ороод ирлээ л дээ.

Б.Бейсен: Батчимэг гишүүнд 1 минут.

П.Батчимэг: Тэгэхээр энэ тайланд тусгагдсан энэ эрх бүхий байгууллагаас хяналт удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байдлыг үнэлж гэрчилгээ олгосон нийт 33 аж ахуйн нэгж байгаагаас одоо 17 аж ахуйн нэгж нь Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO22000 стандарт, 16 аж ахуйн нэгж нь аюулгүй байдлыг хянан шинжлэх тогтолцоог нэвтрүүлсэн байна гээд тайлагначихсан байна. Тэгэхээр энэ аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаандаа өнөөдрийг хүртэл зохистой дадлын нэвтрүүлээгүй гэж дүгнэж байна уу.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн нэрийг Хүнсний баталгаат байдлыг хангах тухай гэж ингэж өөрчлөлт оруулж ирснээрээ ямар бодитой үр дүнд хүрэх вэ. Хүнсний аюулгүй байдал хэрхэн хангагдах юм бэ. Бас эрдэм шинжилгээний байгууллагын чиг үүрэг гээд ороод ирлээ. Энэ чинь ер нь нөгөө л .../минут дуусав/

Б.Бейсен: Хууль санаачлагч Мандхай гишүүн хариулъя.

М.Мандхай: Бид нар Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээг хийхдээ бол шаардагдах мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн

үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яам, Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, нийслэл, аймаг, салбарын хяналтын газруудаас гадна хоёрдогч мэдээлэл үндэсний статистикийн газар, дээрээс нь бид нар D-Parliament-д хуулийнхаа саналыг байршуулаад нийтдээ үндсэндээ 200 гаруй санал авсан. 3 удаагийн бас хүнсний салбарын иргэд, мэргэжлийн байгууллага, яам, агентлаг болон үйлдвэрлэгч гээд бүх хүнсний сүлжээнд хамаарах нийтийн хоол үйлдвэрлэл хүртэл ингээд төлөөлөл төлөөллөөс бид бас оролцуулсан 3 удаагийн хэлэлцүүлгийг нэлээн нарийвчилж хийсэн байгаа. Яах вэ ер нь бол хүнсний салбар өөрөө жил ирэх тусам технологи, тоног төхөөрөмж, хүнсний хангамжийн асуудал жил ирэх тусам хөгжиж явж байгаа. Үүнтэй холбоотойгоор манай улсын хувьд ч гэсэн энэ хүнсний бас яг эрэлт хэрэгцээ, нийлүүлэлт, хүнсний технологи, инновацтайгаа зэрэгцэж бас хууль, эрх зүйн орчин өөрөө сайжрах шаардлага их байсан. Гэтэл энэ хууль өөрөө харамсалтай нь 13 дахь жилдээ үр дагаврын үнэлгээ хийгдээд, энэ хууль нэмэлт, өөрчлөлт оруулах ийм шаардлага гарч байгаа юм. Тэгээд үндсэндээ бол энэ хуулийн хэрэгжилтийг 4 бүлэг, 14 зүйл, 96 заалтын хүрээнд гаргаад, нэгтгэж дүгнэхэд өнөөгийн хүнсний аюулгүй байдлыг хангах удирдлагын тогтолцооны бас яг гажуудлаас үүдээд, энэ хуулийн хэрэгжилт, хуулийн үзэл баримтлал анх дэвшүүлсэн зорилгодоо бол хүрч чадахгүй байгаа нь тодорхойлогдож яг энэ дээр гарсан байгаа. Тэгээд юу хэлж байна гэхээр энийг бол шууд яамны буруу гэж хэлэхгүй. Ерөөсөө л энэ тогтолцоо, хүнсний хяналтын яг энэ тогтолцоо өөрөө алдаатай явж ирсэнтэй холбоотойгоор өнөөдөр хүнсний баталгаат байдал алдагдах, хүнсний аюулгүй байдлын хяналт орхигдох ийм асуудлууд бол үүсэж бол гарсан.

2 дугаарт одоо нөгөө 13 жил шинэчлэгдээгүй байгаа бас нэг суурь асуудал юу байсан бэ гэхээр хүнсний аюулгүй байдлын бүрэлдэхүүний хэсгээс хүнсний хангамж, хүнсний баталгаат байдал буюу хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалтай холбоотой эрх зүйн харилцааг зохицуулсан байдаг. Гэтэл харин хүнсний хүртээмж хүнсний хэрэглээ ба шимт байдал, хүнсний аюулгүй байдлыг тогтвортой хангахтай холбоотой зохицуулалтыг тусгаж өгч чадаагүй. Тэгэхээр үндсэндээ хүнсний аюулгүй байдал гэдэг дотроо хүнсний баталгаат хэрэгцээ шимт гээд маш олон элементүүдийг бүтэн бүрэлдэхүүнээр агуулж өгч чадаагүйгээс болоод хяналтын тогтолцоо дээр бас дахиад дутуу орхигдох асуудлууд үүссэн байгааг бас хэлэх нь зүйтэй. Тэгээд нарийвчилсан мэдээллүүдийг манай экспертүүд хариулна.

Б.Бейсен: Ажлын хэсэг нэмж хариулах уу. 3 номерын микрофон.

Д.Энхмаа: Энэ өдрийн мэндийг хүргэе. Батчимэг гишүүний асуултад хариулъя. Хэрэгжилттэй холбоотой Мандхай гишүүн хариулсан. Баталгаажуулалттай холбоотой асуултад нь хариулъя. Таны хэлдгээр бол тэр 16 аж ахуй хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид үйл ажиллагаандаа ISO, HACCP-ыг нэвтрүүлсэн байгаа. Үүнийг бол бол ISO, HACCP болон өөрөө зохистой дадлын стандартын дээд түвшний ангилалд ордог учраас энэ өөрөө тэр дүгнэлтэд хамаарагдахгүй зүйл. 200 мянга гаруй аж ахуйн нэгж байгаагаас 16 нь бол зохистой дадал биш ISO, HACCP-ын стандартыг нэвтрүүлсэн бусад хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид нь хамгийн наад захын шаардлага тавигддаг зохистой дадлын бол үйл ажиллагаандаа хэрэгжүүлээгүй байна гэсэн ийм дүгнэлт гарсан байгаа.

2-т нь болохоор Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг хүнсний .../минут дуусав/

Б.Бейсен: 3 номер гүйцээж хариулъя.

Д.Энхмаа: Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг Хүнсний баталгаат байдлыг хангах тухай хууль болгож өөрчилснөөрөө ерөнхийдөө хууль, эрх зүйн хүрээнд бол 1 үг 1 утгыг илэрхийлнэ гэсэн ийм зарчмыг агуулж, нэр томъёоллын ойлголтын зөрүүг арилгах ач холбогдолтой. Яагаад гэвэл энэ 2 хууль маань хоёулаа нийт иргэдэд, хэрэглэгчдэд хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой ийм асуудал учраас нэгийг нь хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой зохицуулалт, нөгөөдөх нь хүнсний баталгаат байдлыг хангахтай холбоотой зохицуулалт гэж оруулсан байгаа.

Хуульд заасан Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн бол одоогийн байгаа тэр /ХАБҮЛЛ/ Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторитой үйл ажиллагаа нь давхцахгүй. Энэ бол эрдэм цэвэр эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага байгаа. Хуульд бол нэлээн дэлгэрэнгүй үйл ажиллагааны чиглэл нь тусгагдсан байгаа.

Б.Бейсен: Батчимэг гишүүн тодруулъя.

П.Батчимэг: Хүнсний тухай хуульд нэгэнт нэмэлт, өөрчлөлт оруулах гээд ороод ирлээ. Би хэлээд байна л даа. Тэгэхээр энэ хууль өөрөө сая өнгөрсөн хугацаанд суурь судалгаа нэлээн муутай орж ирлээ гэж би шүүмжилж хэлэх гээд байгаа юм л даа. Аж ахуйн нэгжүүд өнөөдөр Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний чиглэлээр их, бага, дунд, том хэмжээний аж ахуйн нэгжүүд гэхэд 200 мянга гэж байгаа шүү дээ. Энэ чинь асар их том тоо. Тэнд үйл ажиллагаа явуулж байгаа энэ хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг өнөөдөр бид нар төрөөс боомилох, давхар давхардал үүсгэж, улам дарамт учруулж, ямар нэгэн баталгааны бичиг баримт шаардах гээд байгаа юм уу. Гаргуулж заавал авах гээд байгаа юм уу. Ийм юу гаргах гээд байна уу. Эсвэл тэр хувийн орон зайг нь бүр хумих гээд байна уу. Эсвэл бүүр тэлж өгөх гээд байна уу. Төвөггүй болгох гээд байгаа юм уу. Энэ хуулиараа зохицуулалтаараа эндээс харагдахгүй байна шүү. Энэ эрдэм шинжилгээний байгууллага .../минут дуусав/

Б.Бейсен: Мэндсайхан гишүүн асуулт асууя. Батчимэг гишүүн тодруулъя гэж байна.

П.Батчимэг: Миний сонирхоод лавшруулаад асуугаад байгаа зүйл Энхмаа доктор. Яагаад гэвэл энэ төрийн хэвшил, энэ аж ахуйн нэгж хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа энэ олон мянган аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг энэ хууль батлагдсанаараа яаж чөлөөлж өгөх гээд байгаа юм бэ. Одоо өөрсдөө арга ядан үйл ажиллагаа явуулж байгаа. Дэлхийн стандарт ISO хэрэгжүүлж чадахгүй өчнөөн олон байгууллага байна. Хүч хүрэхгүй, зардал байхгүй. Өөрсдийнхөө хүчээр явж байгаа. Тэд нарт өнөөдөр энэ хууль батлагдсанаараа ямар дэмжлэг төрөөс үзүүлэх гээд байгаа юм. Өнөөдөр ... логистик, бүх юмнууд нь өнөөдөр өөрсдөө л арга ядаж явж байгаа шүү дээ. Бүр хүнсний бүтээгдэхүүн шинжилдэг энэ дэлхийн стандартад нийцсэн тэр лаборатори байгуулаач. Дүүрэг болгонд байх ёстой. Эрдэм шинжилгээний байгууллага гэж яриад байх юм. Бид нар судалгаа шинжилгээ хийж өнөөдөр яах гээд байгаа юм бэ. Илүү цаашаагаа харж, том утгаар нь энэ хуульдаа зохицуулалт хийж өгч энэ хүнсний лабораторитой болох хэрэгтэй шүү дээ. Дүүрэг болгонд ядаж .../минут дуусав/

Б.Бейсен: 3 номер нэмж хариулъя.

Д.Энхмаа: Батчимэг гишүүний асуултад хариулъя. Энэ нөгөө олон улсынхаа жишгээр ерөнхийдөө улс орны хүнсний аюулгүй байдлыг хангахад хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид маань ер нь НАССР-ыг нэвтрүүлэх ёстой байдаг. Харин манайх одоо энэ хуулиар хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж л байгаа юм чинь хамгийн доод захын шаардлагыг хангахуйц үйлдвэрлэлийн байртай байна. Хүний нөөцтэй байна. Ингээд хүн арддаа зориулсан хүнсийг үйлдвэрлэж, түгээнэ гэсэн ийм утга агуулгатай орсон байгаа.

Лабораторийн хувьд бол лабораторийн чиг үүрэг угаасаа хуучин мөрдөгдөж байгаа Хүнсний тухай хууль дээр байгаа учраас бид нар бол Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори байгаа учраас энэ дээр бол нэмэлтээр лаборатори гэж нэмж оруулж тусгаагүй. Харин Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь Хүнсний тухай хуулиараа нөгөө орон нутагтаа лаборатори.../минут дуусав/

Б.Бейсен: Загджавын Мэндсайхан гишүүн асуулт асууя.

3.Мэндсайхан: Хууль санаачлагчдын оруулж ирсэн энэ хуулийн өөрчлөлтийн төслийг бол дэмжиж байна. Тэгэхдээ сая Батчимэг гишүүний хэлээд байгаа яг үнэн байгаа юм. Зүгээр яах вэ, энэ Хүнсний хууль болон Хүнсний аюулгүй байдлын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага ямар байна вэ гэхээр жишээ нь бид нар хүнс үйлдвэрлэл гээд ярих юм бол Улаанбаатар хотод нийлүүлэгдэж байгаа мах байна. Тийм ээ. Яг малчны гар дээрээс дундын зуучлагчийн гараар ороод, зах худалдааны төвүүдээр зар борлуулагдаж байна. Энэ хүнс үйлдвэрлэл рүү шууд орж байна. Хүн ам маань шууд хүнсэндээ хэрэглэж байна. Тэгэхээр энэ дээр энэ хуулийн зохицуулалт бол би тэр чанарын удирдлагын тогтолцоог бий болгох гээд байна. Улаанбаатар хот руу техник үйлдвэрлэлийн аргаар боловсруулагдсан мах борлуулагдана. Хүн амд нийлүүлэгдэнэ ч гэдэг юм уу энэ асуудлыг би зохицуулагдах гээд байгаа гэж харж байгаа зөв үү. 1 дүгээрт.

2 дугаарт яг энэ тогтолцоо чинь хэрэгжсэнээр бид нар баахан чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж байна гээд нөгөө зөвшөөрлийн чинь тоо хэмжээ нэмэгдээд, жирийн иргэн энэ хоол, хүнс үйлдвэрлэл рүү орж ирэхэд нэвтрэх тэр саадыг нь өндөр болгоод өгчих вий. Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч ээ. Зүгээр ер нь энэ хүнсний аюулгүй байдал, хүнсний тухай нөгөө хүнс эрүүл байвал хүн эрүүл байна гэдэг шүү дээ. Тийм ээ. Энэ асуудлаа бид нар шим тэжээл талаасаа ойлгох нь нэг өөр асуудал. Яг өнөөдөр хүнс үйлдвэрлэгч талаасаа та нар яаж харж байгаа юм бэ. Тэд нарынхаа нөгөө саад бэрхшээлийг улам их нэмэгдүүлээд, зөвшөөрөл лиценз болоод явчих вий. Энэ дээрээ хариулт өгөөч ээ л гэж хүсэж байна.

Б.Бейсен: Хууль санаачлагч Мандхай гишүүн хариулъя.

М.Мандхай: Энэ хуулийн үндсэн гол концепц бол бид нар нөгөө хүнсний баталгаат хууль дээр сүүлийн 13 жилийн хугацаанд цогц бодлогын түвшинд орхигдсон байгаа чиглэлийг бид нар түлхүү тусгаж оруулж өгч байгаа. Үндсэндээ бол хүнсний хангамж, хүртээмж, жигд тогтвортой байдлыг хангах, хүнсний сүлжээний бүх үе шатад хүнсний баталгаат байдлыг хангах, дээрээс нь бас нэг чухал асуудал бол өөрөө шим тэжээллэг чанартай хоол хүнсийг сонгон хэрэглэх боломжийг зөв зохистой хэрэглэх, төлөвшүүлэх ийм чадварыг оруулж өгч байгаа. Хүнсний салбарын үндэсний нөгөө сөрөн тэсвэрлэх чадавх гэсэн үндсэн 4 энэ гол цогц бодлогын чиглэлийг оруулж өгөөд, үүнийгээ бодлогынх нь хэрэгжилтийн механизмыг тусгаж өгч байгаа. Яг энэ хууль дээр юу гэдэг юм нөгөө Хүнсний

бүтээгдэхүүн аюулгүй байдлын тухай хуультай холбоотойгоор нөгөө хяналтын механизм энэ тэр бол орж өгөөгүй. Яагаад гэхлээр энэ Хүнсний тухай хууль бол өөрөө гол малгай хууль байгаад байгаа юм. Тэгээд түрүүн хэлсэн ерөөсөө л хүнс үйлдвэрлэх юм бол хамгийн наад захын зохистой дадал гэж жишээлбэл, өнөөдөр нийтийн хоол үйлдвэрлэл энэ хуулиас гадуур зохицуулагдаагүй ирсэн байсан хүнсний сүлжээний гол тээвэрлэлт, хадгалалт, нийтийн хоол үйлдвэрлэлийн сүлжээг хүнсний сүлжээн дотор багтааж оруулж өгснөөрөө нэгд хууль дээр ингээд зохицуулагддаг, хамгаалагддаг ийм орчныг бий болгож байгаагаараа давуу талтай.

2 дугаарт наад захын одоо үйлдвэрлэл эрхэлж байгаа бол зохистой дадлыг л нэвтрүүлэх ийм шаардлага тавьж байгаа. Хүнсний томоохон бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжүүд бол угаасаа нөгөө яг шалгуур үзүүлэлтээрээ ISO стандартуудыг болон HACCP-ын стандартуудыг угаасаа хэрэгжүүлээд явж байгаа. Түүн дээр угаасаа томоохон үйлдвэрлэгчид өөрсдийнхөө тээвэрлэлтийг, хадгалалт, нөөцлөх бүх асуудлуудыг стандартын дагуу үйлдвэрлээд явж байгаа. Тэр дээр бол бид нар нарийвчилсан ийм байх ёстой гэдгийг Хүнсний тухай хуульд бол ерөөсөө оруулж ирэхгүй. Энэ өөрөө Хүнсний бүтээгдэхүүн аюулгүй байдлын тухай хууль дээр нарийвчлан заасан заалт байгаа учраас энэ дээр бас залруулга хийе гэж бодож байна.

Б.Бейсен: Мэндсайхан гишүүн тодруулъя.

3.Мэндсайхан: Тэр хүнсний аюулгүй байдал, цаад хүнсний шимт тэжээл найрлага талаасаа бол би ойлгож байна. Гол асуудал байгаа нь том үйлдвэрлэгч нар бол мэдээж чанарын удирдлагын тогтолцоог шат шатандаа хангаад явж байгаа. Энэ чинь цаана нь хүний эрүүл мэнд, аюулгүй байдал. Гол асуугаад байгаа юм нь юу вэ гэхээр зэрэг жишээлбэл гудамд хоол зараад зогсож байдаг өчнөөн иргэд маань байгаа шүү дээ. Наадмаар бид нар энэ цэнгэлдэх тойроод л зогсдог хүмүүсээ бид нар энэ жил гэдэг юм тогооч нь мэргэжлийн байх ёстой ч гэдэг юм уу ингээд шаардлага тавиад л эхэлж байсан шүү дээ. Энэ хууль чинь явж явж байгаад тийм юмнуудыг бүгдийг нь боомилоод тавих гэж байгаа юм биш үү. Яг тэр хөрсөн дээр амьдралаа залгуулах гээд цайны газар ажиллуулж байгаа, гудмын хоол ундаа эрхэлж байгаа энэ хүмүүс дээр энэ хууль чинь яаж буух гээд байгаа юм бэ. Тэгээд бас л ингээд энэ стандартыг нэвтрүүлнэ гээд явах юм уу. Нөгөө зохицуулалтуудаа та бүхэн маань яг яаж хараад байгаа юм бэ.

Б.Бейсен: Мандхай гишүүн хариулъя. 3 номер хариулъя. Албан тушаал, нэрээ хэлээрэй.

Д.Энхмаа: Энхмаа байна. Энэ нөгөө зохистой дадлын стандарт гэхээр аягүй том сонсогдоод байж магадгүй. Ерөнхийдөө зохистой дадал гэдэг бол яг хүнсний үйлдвэрлэл явахад гараа угаасан байх, гампанзаа цэвэрхэн байлгах асуудал, шалаа цэвэрхэн байлгах асуудал хамгийн наад захын эрүүл ахуйн шаардлага хангасан байх ёстой гэдэг л ийм шаардлага. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа явуулж байвал 00-той байх, агааржуулалттай байх, 00-д орох бүрдээ хүрч ирээд хүнсээ үйлдвэрлэх юм бол гараа угаасан байх асуудал л зохистой дадлаар зохистой дадлын стандартад тусгагдсан байгаа. Тэгэхээр энэ бол яг үйлдвэрлэл эрхэлж байгаа хүмүүст ачаалал өгнө гэж би бол бодохгүй байна.

Б.Бейсен: 2 номер нэмж хариулъя.

Б.Алтанцэцэг: Батчимэг гишүүний саяын асуултад хариулъя. Ер нь бол Хөдөө аж ахуйн зохистой дадлын нэвтрүүлэх асуудал 2012 онд батлагдсан Хүнсний тухай хууль дээр заавал нэвтрүүлэхээр орсон байсан. Угаасаа байгаа. Гол нь олон улсад итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагаар баталгаажуулж болно гэснийг үндэсний итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагаар баталгаажуулна гэдэг ийм өөрчлөлтийг л оруулсан байгаа. Өөрөөр хэлэх юм бол олон улсад итгэмжлэгдсэн биш Монгол Улсдаа итгэмжлэгдсэн үндэсний итгэмжлэлийн байгууллагаар.

2-т гэх юм бол ISO нэвтрүүлсэн тэр хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа том үйлдвэрүүд бол зохистой дадлыг нэвтрүүлэх энэ шаардлага бол тавигдахгүй гэдгийг бас бид нар хуулийн төсөлдөө тусгасан байгаа. Баярлалаа.

Б.Бейсен: Болдын Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Хүнсний тухай хууль дээр бол нэлээн олон асуулт байгаа. Гэхдээ хэлэлцэх хэсгийн хүрээнд бол дэмжиж байгаа. Тэгээд гол сонирхож байгаа 2 асуултаа асууя.

Үзэл баримтлалын практик шаардлага хэсэгт байгаа юм. Хүнсний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах практик шаардлагад ингээд биччихсэн мэдээллүүд байгаа юм л даа. Цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэлд хамгийн үнэтэй, хамгийн үнэтэй мөртөө хамгийн чанаргүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэгдээд байна гээд. Тэгэхээр чинь бид нар өглөө гарахдаа хүүхдээ цэцэрлэг, сургуульд хүүхдүүдээ явуулчихаад л энд ирээд, тэгээд одоо бодоод суухаар чанаргүй хүнс идээд байж байгаа юм байна л даа. Тэгэхээр мэдээж ингээд бичигдчихсэн байгаа юм чинь ул үндэстэй л байх. Тэгээд яагаад юм бол гээд цаашаа уншихаар яагаад вэ гэвэл хариуцаж байгаа төрийн захиргааны төв байгууллага буюу яам нь 2 байгаад байгаа. Тэгээд зохицуулалт нь 2 яамны дунд шидэгдээд байна гэж бичсэн байна. Нэг яам нь болохоороо Боловсролын яам, нөгөөдөх нь болохоороо Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хооронд ингээд байгаа юм байна. Тэгээд яг энэ хуулийн төсөл дээр энэ асуудлаа яаж шийдэж байгаа юм бол гээд харангуут сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний асуудлыг нь болохоороо Боловсролын яаманд нь. Хүнсийг нь, түүхий эд, бүтээгдэхүүнийг нь ханган нийлүүлж байгаа асуудлыг нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам руу нь тэгээд эсвэл Засаг дарга руу нь хариуцуулахаар төсөлд тусгасан тусгасан байгаа. Ийм мэдээллийг бол авч байгаа юм л даа. Тэгэхээр яг энэ дээр болохоороо хэрвээ л хоол хүнстэй холбоотой, түүхий эдтэй холбоотой, үүний яг чанарыг ярьж байгаа бол энийг бүгдийг нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хариуцах ёстой шүү. Боловсролын яам дээр тэгээд танайхтай нэлээн төстэй нэгж гараад явах юм шиг санагдаад байх юм. Тэгэхээр нөгөө төрийн байгууллагын уялдаа холбоо эд нар дээр танай яг энэ ажлын хэсэг юу гэж үзсэн юм бол. Энэ дээр хариулт авмаар байна.

Бас энэ үзэл баримтлал дээр ингэж бичсэн байгаа юм. Хүнсний чиглэлээр бол эрдэм шинжилгээний байгууллага байх ёстой гэж бол боддог. Үгүй ээ, байгаа ч байх гэж бас бодож л байлаа. Гэхдээ энэ үзэл баримтлал дээр бичсэнээр бол тандалт судалгаа нэг их хийгддэггүй, үр дүн нь төрийн бодлогод тусахгүй байгаа учраас яг энийг нь ийм болгох үүднээс чиг үүргийг нь бас хуулийнхаа төсөлдөө тусгалаа гэсэн байна. Тэгээд хуулийн төслийн 13¹.2 дугаар зүйлд болохоор эрдэм шинжилгээний байгууллага гээд холбогдох зохицуулалтыг оруулж өгсөн нь бол сайшаалтай юм. Гэхдээ яг ийм төрийн эрдэм шинжилгээний байгууллага нь академидаа байдаг юм уу. Яг энэ чиглэлээр нэг тийм мэдээлэл өгөөч. Яагаад ер нь бо төрийн бодлогод

судалгаа нь тусдаггүй байсан юм бол. Тэгээд магадгүй ийм учраас тэр хүнсний аюулгүй байдал, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал гэсэн нэр томьёонд нь зааг ялгаа нь ойлгомжгүй байгаа юм болов уу. Тэгээд энэ хэдэн асуултууд дээр хариулт авъя.

Б.Бейсен: Хууль санаачлагч Мандхай гишүүн хариулъя.

М.Мандхай: Энэ яалт ч үгүй бид нар нөгөө Хүнсний тухай хууль ярьж байгаа учраас хүүхдийн ялангуяа ерөнхий боловсролын сургууль бараг 400 орчим мянган суралцагчдын үдийн хоолны асуудал бол хөндөгдөж байгаа. Тэгээд манай бас Туяацэцэг доктор бас энэ дээр ялангуяа яг энэ хууль дээр сууж байгаа хүний хувьд бас нэлээн нарийвчилсан мэдээллүүдийг өгөх нь зүйтэй байх гэж бодож байна. Үр дагаврын судалгааны үеэр бол үндсэндээ сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг стандартын шаардлага хангасан. 1 дүгээрт сургууль өөрөө стандартад баригдаж байна уу гэдэг асуудал хөндөгдөж байгаа.

2 дугаарт хэрэв хоол үйлдвэрлэл яригдаж байгаа бол зориулалтын байр, гал тогоо, тоног төхөөрөмж ашиглан мэргэжлийн хүний нөөцтэйгөөр явуулна гэж угаасаа хуульд бол тусгасан байдаг. Тэгээд үүний дагуу үнэлгээний явцад цуглуулсан мэдээллээс ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, хүртээмжийн түвшин, анх хууль батлагдсанаас хойш үндсэндээ жил бүр дээшилж байгаа ч гэсэн энэ заалт хэрэгжилтийн хувьд бол яг үнэлгээний явцад бол 50%-тай гарч байсан. Ялангуяа зөвхөн хоолны тоног төхөөрөмж байхаас гадна мэргэжлийн бас яг тогооч, туслах боловсон хүчний асуудал дээр мэргэжлийн тогооч, угаагч, хүнсний технологич, мэргэжлийн хоол зүйчээс эхлүүлээд том баг ажиллах ёстой. Энэ баг нэгд тогтвортой үйл ажиллагаа ажиллаж явуулдаггүй. Үргэлж байнгын хүний нөөцийн дутагдалтай явж ирсэн. Тэгээд эргээд энэ нь өөрөө байгаа боловсон хүчин дээрээ үндсэндээ үйл ажиллагаагаа явуулдаг ийм асуудал бэрхшээлүүд байгаа.

3 дугаар асуудал яагаад энэ хүнстэй холбоотой вэ гэхээр үндсэндээ бол одоогоор хоногт 1-5 дугаар ангийн хүүхэд сургуулийн хоолноос өдөрт авч байгаа илчлэгийн хэмжээ 30%-тай, шим тэжээлийн асуудал 50 хүрэхгүй хуу хувьтай бид нар ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд хоол өгч байгаа. Тэгэхээр үндсэндээ Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж өгч байгаа гол шалтгаан бол бид нар шим тэжээлийн асуудлыг үндсэндээ энэ хуульд тусгаж оруулдаг байж энэ дээрээ хяналт тавьдаг, энэ асуудлыг хөгжүүлэхгүй бол нийт идэж байгаа хүүхэд ч биш ерөнхийдөө энэ насанд хүрсэн хүмүүс ч гэсэн хоолны шим тэжээллэг байдал, илчлэг байдал үндсэндээ орхигдож байгаа. Энэ нь өөрөө хөгжихгүй байгаа бас ийм сул талууд бол ажиглагдаж байгаа. Тэгээд ялангуяа ерөнхий боловсролын сургууль дээр гал тогоог ашиглах юм бол нөгөө түрүүний хэлсэн хамгийн наад захын ядаж зохистой дадлын зайлшгүй нэвтрүүлэх ёстой гэдгийг олон улсын яг энэ гэрээ конвенцод хүртэл хэрэгжүүлэх ийм шаардлагыг бол тавьсан. Тэгээд өнөөдөр энд 2012 онд батлагдсан хууль үндсэндээ зохистой дадал бас хэрэгжигдэхгүй явж ирж байгааг илүү хүчитгэж бас энд оруулж өгч байгаагаараа ач холбогдолтой. Тэгээд Туяацэцэг доктор бас яг Уянга гишүүний асуултад нарийвчлаад хариулаад өгөөрэй.

Б.Бейсен: 4 номерын микрофон хариулъя. Албан тушаалаа хэлж танилцуулж байгаарай. Протоколд орох учраас.

Ж.Туяацэцэг: Сайн байна уу. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Туяацэцэг байна. Хүнсний тухай хуульд яагаад энэ хүүхдийн тухай асуудлыг их

ярьж байна вэ гэвэл ер нь бол үндэсний хэмжээнд хийгддэг хүнсний бүтээгдэхүүний хэрэглээний талаарх нийгмийн эрүүл мэндийн байгууллагын хийсэн судалгаанууд байдаг. Энэ бол 5 жил тутамд хийгддэг судалгаа. Энэ судалгаануудын дүнгээс харахад 5, 6 дугаар судалгаа дээр адилхан юу гэдэг юм. Бичил тэжээл, эрдсийн дутагдалтай, микро элементийн дутагдалтай гэж судалгаа болгон дээр гардаг. Үүний нэг хэрэгжилт нь бол эрүүл мэндийн салбар болон хүнсний салбарын бодлогын бичиг баримтад тусгагдахгүй, цаасан дээр үлддэг ийм тайлан болж үлдээд байгаа. Тийм учраас энийг бид нар хүн ардыг эрүүлжүүлэх, нийгмийг тэр чигт нь эрүүлжүүлэх бодлого бол хүнстэй зайлшгүй холбоотой юм гэж үзээд энэ Хүнсний тухай хууль болон үүнийг дагалдан гарч байгаа Хүнсний аюулгүй байдлын тухай хууль .../минут дуусав/

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариулъя.

Ж.Туяацэцэг: Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний хууль энэ тэрд бүгдэд нь тусгалаа олоод явж байгаа юм. Ялангуяа ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн хоолны талаар асуусан учраас бас манай энэ хууль дээр ажилласан баг бас Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хуулийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийсэн. Энэ дүн шинжилгээгээр бол мөн л хуулийн хэрэгжилт 33,2%-тай гэсэн ийм үзүүлэлттэй гарсан байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар бодлогын хувьд буюу энэ хуулиар дамжуулж бас энэ хэрэгжихгүй байгаа асуудлуудыг хэрэгжүүлэх, ялангуяа энэ хүнстэй холбоотой, хүнсний хангамжтай холбоотой асуудлуудыг оруулах нь зайлшгүй зүйтэй юм гэж үзсэн байгаа.

Б.Бейсен: Агваанлувсангийн Ундраа гишүүний асуулт асууя. Хэдэн номерын нэмж хариулах уу. 4 номер нэмж хариулах юм байна.

Ж.Туяацэцэг: Эрдэм шинжилгээний байгууллагыг яагаад энэ дээр онцолж яриад байна вэ гэхээр аливаа улс орон бол өөрсдийн хүн ардын хэрэглэж байгаа хүнсний түүхий эд бүтээгдэхүүний найрлагыг бид нар тухайн улс өөрсдөө өөрсдийн хөрсөнд тариалж байгаа, өсгөж байгаа малын гаралтай хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг бүгдийг нь тогтоогоод, ямар найрлагатай юм, ямар ач холбогдолтой юм гэдгийг гаргаж тавьж, жирийн хэрэглэгчээс өгсүүлээд энэ бодлого тодорхойлдог шатны хүмүүс хүртэл энэ тухай ойлголт мэдээллийг авч байх ёстой. Тэгээд олон улсын байгууллагад бол Монгол Улс энэ талаар ямар мэдээлэлтэй байдаг юм гэдгээ бид нар тайлагнаж байх ёстой байдаг. Гэтэл манайд яах вэ, өмнөх нийгмийн үед бол Хүнсний эрдэм шинжилгээний хүрээлэн гэж байж байгаад энэ хүрээлэн маань зах зээлийн эдийн засагт шилжих үед хувьд шилжээд, яг өөрсдийнхөө хийдэг энэ бодит үйл ажиллагаа, судалгаа шинжилгээний ажлыг хийгдэхгүй болж ирсэн гэсэн..../минут дуусав/

Б.Бейсен: Ундраа гишүүн асуулт асууя.

А.Ундраа: Та бүгдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Тэгээд энэ дээр бас бусад хуулиудтай уялдуулах, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиудтай уялдуулахаас гадна тэр уялдаа холбоо сул байгаа асуудлыг сайжруулах явдал маш их чухал гэж харж байгаа. Тэгэхээр энэ орж байгаа нэмэлт, өөрчлөлт маань тэр уялдаа холбоог бүрэн дүүрэн хангаж чадах эсэх дээр бас жаахан санаа зовж байна.

Тэгээд 1 дүгээрт бол одоо энэ НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын хүн амын хүнсний нөхцөл байдлын талаар ингээд 5 жил тутам судалгаа хийдэг. Энэ бол яах вэ ОУБ-аас дэмжээд хийж байгаа маш сайн чанартай судалгаа. Гэхдээ энэ судалгааны давтамжийг бас ойртуулах шаардлага байна гэж харж байгаа 1 дүгээрт.

2 дугаарт гэвэл энийг улсын төсөвт тусгаад ОУБ дээр дандаа тулгуурлаад байхгүйгээр бид өөрсдөө хаана яваагаа мэддэг болох явдал бол маш их чухал байгаад байгаа. Тэгэхээр ажлын хэсгээс тодруулж асуумаар байгаа зүйл гэвэл бид энэ судалгааны маань давтамж бас хол байгаагаас шалтгаалаад энэ шийдвэр гарахад бас судалгаа байгаа нь сайн хэрэг. Тэгээд байгаад байгаа судалгаагаа бас шийдвэр гаргагч тэр болгон ашигладаггүй. Тэгээд Баяжуулсан хүнсний тухай хууль батлагдаад 8 жил болж байна. 9 жил шахам. Сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэлийн асуудлын талаар хууль батлагдаад 8 жил болж байна. Тэгэхээр энэ хугацаанд бол энэ хуулиудын хэрэгжилт бол сул явж ирсэн. Тэгэхээр энэ хэрвээ судалгаа илүү ойрхон хийгддэг байсан бол магадгүй шийдвэр гаргагчид шийдвэрээ арай дорвитойхон шиг гаргачих байсан юм болов уу. Тэгэхдээ энэ асуудлын гол бол хамгийн гол нь шийдвэр гаргах процесс нь өөрөө маш удаан, тэгээд шийдэмгий бус, тэгээд төсвөө хуваарилахдаа юу чухлаа мэдэхгүйгээр гэх юм уу чухлын эрэмбээ алдаж хуваарилдагтай бол шууд холбоотой л доо. Тэгэхээр өнөөдөр бид бага ангийн хүүхдүүдийн хоол үйлдвэрлэлийг төрөөс хариуцаж байгаа боловч цаашдаа дунд ангийн тэгээд ахлах ангийн хүүхдүүдийг төрөөс халуун хоолоор өдөрт хүүхдүүддээ өгдөг байх, тэр нь шим тэжээлтэй байх, хүүхдийн эрдэс бодисын дутагдлыг нөхдөг байх, өсөлтийг дэмждэг байх. Тэгээд зөвхөн биеийн өсөлтөөс гадна энэ чинь хүүхдийн оюуны чадамжийг дэмжихэд бол хоол үйлдвэрлэлийн асуудал бол маш чухал байгаа. Тэгэхээр энэ дээр тодруулж асуумаар байгаа нь энэ асуудлыг ингээд төсвийг шийдлээ гэж үзэхэд төсвөө шийдэж чадах эсэх нь эргэлзээтэй. Шийдлээ гэж үзэхэд хүний нөөцийн асуудал хэр зэрэг байна вэ. Манай хамгийн гол боловсролын асуудлыг хариуцаж байгаа профессорууд ирсэн байна. Тэгэхээр бидэнд хангалттай тооны мэргэжилтнүүд байна уу. Хоол үйлдвэрлэлээ хариуцаад, хянаад явах хүмүүс байна уу. Энэ асуудлыг төсөв дээр суулгаж байна уу. Зөвхөн хоолныхоо өртгийг л тооцоод байхаас биш энийг чинь хянаад хүргэхэд бол хүний нөөцийн асуудал бол маш чухал байгаа гэж харж байгаа.

Б.Бейсен: 3 номерын микрофон хариулъя.

Д.Энхмаа: Энхмаа. Ундраа гишүүний асуултад хариулъя. Төсөвтэй холбоотой энэ судалгаа, шинжилгээний төсвийг хэрхэн яаж тусгасан бэ гээд. Хуулийн нэмэлт, өөрчлөлтүүд 13².3.9-д заасан тандалт судалгааг 5 жил тутамд явуулж, үр дүнг Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөл тайлагнах, холбогдох байгууллагад болон олон нийтэд мэдээлэх 13².3.10 дээр нь бол үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төсөл, улсын, нутгийн захиргааны байгууллагын болон иргэн хуулийн этгээдийн захиалгаар судалгаа хөгжүүлэлтийг бусад ажил гүйцэтгэх гээд ерөнхийдөө бол бас тусгаж өгчихсөн байгаа.

Б.Бейсен: 4 номерын микрофон нэмж хариулъя.

Ж.Туяацэцэг: Хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр 13.1.5 дээр хүнсний хангамж, бодит хэрэглээ, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний найрлагын судалгааг хийдэг байна гэж оруулсан байгаа. 13.1.6 дээр хүнсний баталгаат байдал, шим тэжээл, молекул биологи, хүнсний нэмэлт баяжуулах, зохицуулах үйлчилгээ, хүнсний тандалт судалгааг хийж байна гэсэн ийм заалтуудыг бас судалгаа шинжилгээний

хэсэгт оруулсан байгаа. Түрүүн бас Батчимэг гишүүн асууж байсан. Энэ судалгаа шинжилгээ ер нь ямар ач холбогдолтой юм бэ, ямар хэрэгтэй юм бэ гээд. Тэгэхээр энэ бүхнийг бид нар бодит хэрэглээ болон хүнсний түүхий эд бүтээгдэхүүний найрлагын судалгаануудыг гаргана гэдэг маань миний түрүүний хэлснээр жирийн иргэдээс өгсүүлээд бодлого тодорхойлогч хүртэл ашиглах ийм бодит судалгааны үр дүнгүүд харагдаж байх ёстой. Эндээ хараад хүн би нэгж бүтээгдэхүүн хэрэглэх юм бол надад ямар ач холбогдолтой юм, би юу идэж, ууж байна гэдгээ шинжлэх ухааны үндэстэйгээр .../минут дуусав/

Б.Бейсен: 4 номер нэмж хариулъя.

Ж.Туяацэцэг: Бодит хэрэглээний судалгаа гэдэг бол юу гэсэн үг вэ гэхээр улсын хэмжээнд байгаа нийт ард иргэд маань өдөр тутамд хүнсэндээ юу хэрэглэж байгаа юм. Би шаардлагатай зүйлээ идэж чадаж байна уу гэдгийгээ тодорхойлох энэ гол ач холбогдол нь энд байгаа. Манай хүмүүс тэгдэг. Би өдөрт гурилаа, талхаа идэж байна, лавшаагаа идэж байна. Би өлсөөгүй байгаа учраас миний шим тэжээлийн байдал хэвийн байна гэж үздэг. Гэтэл бол энэ бодит хэрэглээний судалгааг хийснээр, ер нь энэ шим тэжээлийн асуудлыг тооцож үзсэнээр Монголчуудын ихэнх хувь нь бол далд өлсгөлөн буюу энэ шим тэжээлийн дутагдалд орсон байна гэдэг дүн шинжилгээ гарсан байдаг. Тэгэхээр далд өлсгөлөн гэж юуг харуулж байна вэ гэхээр микро элементийн дутагдал өдөр бүр хүн олон нэр төрлийн хүнс хэрэглэж байх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байгаа. Бодит хэрэглээний судалгааг бид нар улсын хэмжээнд ганцхан удаа явуулж үзсэн. 2016 онд хөрөнгө санхүүгийн хувьд бол хязгаарлагдмал байсан учраас эндээс харахад .../минут дуусав/

Б.Бейсен: Ундраа гишүүн тодруулъя.

А.Ундраа: Тэгэхээр судалгааны ач холбогдол маш өндөр байгаа юм л даа. Энэ бодит хэрэглээний судалгааг бид өөрсдөө төсвөөс гаргаад хийх шаардлага байна гэдэг нь ингээд харагдаад байгаа юм. Илүү давтамжтайгаар ганцхан удаа биш ингээд 3 жил тутамд юм уу арай илүү ойрхон хийгдэж байх ёстой байх. 1 дүгээрт.

2-т гэвэл хүний нөөцийн асуудал дээр яг энэ сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэлтэй холбоотойгоор түрүүн асуусан хариулж амжихгүй байх шиг байна.

Б.Бейсен: Мандхай гишүүн хариулъя.

М.Мандхай: Бас нэг чухал судалгааны юуг бас орхигдуулсан байна. Хавдар судлалын үндэсний төвөөс гаргасан хавдар үүсгэж байгаа хүчин зүйлүүд дээр үндсэндээ нөгөө нийт хавдар үүсгэгчийн 35% нь зохисгүй хоол хэрэглээнээс үүсэж байгаа гэдэг нь бол гарсан. Дэлхийн 118 орон байсан уу даа, 118 улс дотроос судалгаа хийхэд Монгол Улс хорт хавдраар элгээр 1-д байсан, ходоодны хорт хавдраар бол 2-т бичигддэг байж байгаад саяын судалгаагаар бол 1-д бичигддэг болсон. Энэ нь өөрөө дахиад ер нь бол энэ хавдар үүсгэж байгаа гол зохистой юм нь 35% буюу энэ чинь одоо 3-ны 1-ээс илүү хувь нь өөрөө зохисгүй хоол хэрэглээ, зохисгүй хоол хэрэглээ дотор идэж байгаа хоол хүнснээс гадна шим тэжээллэг байдал, нөгөө хүнсний баталгаат хүнсийг хэрэглэхгүй байгаа. Энэ нь өөрөө эргээд хэрэглэгч/минут дуусав/

Б.Бейсен: Мандхай гишүүн нэмж хариулъя.

М.Мандхай: Лангуун дээр очсон хүнс өөрөө баталгаатай байгааг хяналтын тогтолцоо өөрөө хангалттай хангаж өгч чадахгүй байгаатай бас хамааралтай байгаа юм. Тийм учраас бид нар энд эрдэм шинжилгээний мэргэжлийн байгууллагуудын яг чиг үүргийг хууль дээр бүр нарийн зохицуулалттай оруулж өгсөн. 2 дугаарт таны хэлж байгаа судалгаа шинжилгээ энэ хүний нөөцийн асуудлыг орхигдож байгаа учраас бид нар ганцхан хүнсний биш хөдөө аж ахуйн чиглэлээр ч гэсэн энэ элсэгчдийн, сурагчдын тоо буурч байгаа асуудал байгаа учраас бид нар Хүнсний тухай хууль, дээрээс нь Хөдөө аж ахуйн хуулиуд дээр өөрөө энэ боловсон хүчнийг бэлтгэх, мэргэшүүлэх, хөгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг бүр нарийвчилж энэ хуулиуд дээр бас оруулж өгсөн байгааг хэлэх гэсэн юм.

Б.Бейсен: 4 номер нэмж хариулъя.

Ж.Туяацэцэг: Энэ салбарын хүний нөөцийн асуудал мэдээж бас бусад салбартай адилхан чухлаар тавигддаг. Ялангуяа хүнсний салбар, би өөрөө боловсролын байгууллагад ажилладаг учраас бид нар бас жил болгон байнгын судалгаа хийдэг. Энэ судалгаан дээрээс харахад ер нь төгсөгчид, ялангуяа ажлын байран дээр очоод яагаад тогтвор суурьшилтай ажиллахгүй байна, яагаад ийм байдал үүсэж байна. Энэ судалгаа шинжилгээний ажил энэ тэрд гаргаж үзэхээр цалингийн асуудалтай дандаа холбож ярьдаг. Одоо жишээлбэл их, дээд сургуульд инженерийн боловсрол эзэмшиж байгаа улсууд 4,5 жил ижилхэн төлбөр төлөөд бусад мэргэжлүүдтэй ижилхэн суралцаад, зарцуулалт нь адилхан хэр нь төгсөж гараад очиж байгаа цалингийн хэмжээ нь ялангуяа хүнсний салбар, хөдөө аж ахуйн салбарт бол цалингийн үнэлгээ маш бага байгаа учраас энэ салбарт ажиллах залуучуудын сонирхол их дутмаг муу байна гэж үздэг. Судалгаа шинжилгээний байгууллага ч гэсэн энэ эрдэм шинжилгээний байгууллагуудын цалин бол бусад төрийн/минут дуусав/

Б.Бейсен: Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ оройн амар амгаланг айлтгая. Энэ нэлээн гол хууль байгаа юм. Тэгээд үзэл баримтлалынх нь хувьд би хэлэлцэхийг нь дэмжчих нь зөв юм болов уу гэж бодоод байна. Тэгэхдээ нэмэлт, өөрчлөлт хөндөх ёстой юмнуудыг хөндөлгүй оруулаад ирчихсэн бол хэлэлцүүлгийн түвшинд хөндөх боломжгүй. Тэгэхээр би та хэдийг энэ Хүнсний тухай хууль батлагдаад, мэдээж хэрэгжих явцдаа тодорхой нэмэлтүүд орж явсан байх. Тэгэхдээ энэ эдийн засаг, нийгмийн өөрийнх нь чадамжаас хамаараад төрийн бодлого тухайн цаг үеийнхээ эрэлттэй нийцэж гарч явдаг. Тэгэхээр энэ өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд бидэнд юу нь болоод, юу нь болоогүй юм гэдэг юмаа хууль боловсруулах явцдаа нэлээн том судалгаа хийсэн байх. Түүн дээрээ тулгуурлаж би энд их тодорхой зүйл орсон болов уу гэж ингэж бодоод байна.

Тэгэхээр 1 хүний зохистой нормын тухай ойлголтыг шинэчлэх тухай асуудал байгаа юм биш үү гэдэг юм байгаад байгаа юм. Одоо бидний үед гурилын хүний өдрийн хэрэгцээ хэд байсан юм. Одоо хэд болчихоод бусад бүтээгдэхүүнээр орлогддог болчихоод байгаа юм гэдэг юмыг их тодорхой гаргаж ирмээр санагдаад байгаа. Энэ талын асуудлыг тэр Хүнсний аюулгүй байдлын зөвлөл дээр тухайн жилд хэрэглэгдэх хүнсний тэр тусмаа стратегийн гол бүтээгдэхүүнүүдийн тоо хэмжээ, хангалт нийлүүлэлтийн асуудлыг зохицуулж шийдвэр гаргуулах гээд байна шүү дээ. Тэгэхээр үүн дээр суурь юм чинь тэр асуудал байх гээд байгаа юм. Үүнийг ер нь юу гэж харж байна вэ гэдэг нэг ийм зүйл.

2 дахь зүйл. Энэ хүнсний бүтээгдэхүүнээс хамааралтай өвчлөлийн тухай их сүрхий яриад байгаа юм. Би заримыг нь ч нарийндаа ойлгохгүй байгаа. Өнгөрсөн цаг хугацааны үйл явц энд ирж шингээд байгаа юм биш биз дээ гэдэг л юм байгаад байгаа шүү дээ. 1990-ээд оны хүнсний хомсдолын гэдэг юм уу, хангалтын дутуугийн, хяналтын сулын үр дагавар өнөөдөр гэдэг юм уу нэлээн их өндөр мэдрэгдэж байгаа энэ цаг үед өнөөдөр байгаа юм шиг бид бодоод байгаа юм биш биз дээ. Энэ дээр хийсэн дүн шинжилгээ гэж ер нь юмнууд ямархуу байдаг юм бэ гэдэг асуудал байгаад байгаа.

Би яагаад тэгж хэлж байна вэ гэхээр зэрэг нэг талдаа бид хүнсний хангамж аюулгүй байдлын тухай яриад байдаг. Нөгөө талдаа нэг хэсэг эрдэмтэд маань, судлаачид маань хүнснээс хамааралтай өвчлөл нэмэгдчихлээ, хавдар залуужчихлаа гэдэг юм яриад болж өгөхгүй байгаад байгаа. Энэ яг өнөөдрийн хүнс дээр байна уу, эсвэл өнгөрсөн цаг хугацааны үр дагавар өнөөдөр тодорч гарч ирээд байна уу гэдэг юмаа шинжлэх ухааны үндэслэлдээ хэдүүлээ нэг нотолгоонд суурилж гаргах юм сан гэдэг нэг ийм санаа байгаа. Энэ ер нь ямархуу байдлаар та хэдийн судалгаа юманд орж гарч ирдэг юм гэдэг асуудал..../минут дуусав/

Б.Бейсен: Батжаргал гишүүн гүйцээж асууя.

Ж.Батжаргал: Бид хэд чинь хэдэн голыгоо дотоодоосоо үйлдвэрлэдэг, дийлэнхийг нь гаднаас импортлоод байгаа. Ер нь хэрэглээ их өргөн болчихсон. Үгүй ээ, тэгвэл тэр импорт дээр тавьдаг хяналтын асуудал, гарал үүсэл, мөшгөлт, баталгаажуулалтын асуудал энэ хуульд ер нь яаж чанарын өөрчлөлт авахаар орж ирэв гэдэг асуудал байгаад байна л даа. Тэгээд энэ чинь бол зөвхөн нэг үйлдвэрлэлийн гэдэг юм уу, бэлтгэлтийн үеийн биш ээ. Хадгалалт, тээвэрлэлт, түгээлт энэ бүх үе дамжлагууд дээр байгаад байгаа. Аль нэг дээр нь доголдол үүсэхэд тэр хүнс тэр чигтээ сөрөг үзүүлэлттэй л гарч ирэх ёстой. Одоо энэ улсуудыг чинь яриад, том тэрэгний жолооч нарыг чинь яриад байгаа бол энэ урд эрээн дээр гэдэг юм уу, Замын-Үүд дээр 3, 4 хоног том тэрэг зогсож байгаад бараагаа гүйцэж ачаад, наашаа хөдлөөд, ирсэн бүтээгдэхүүнээ энд хөргөлттэй систем рүү нь оруулаад тэгээд бараг үндсэндээ чанарын шаардлагыг нь хангавал/минут дуусав/

Б.Бейсен: Хууль санаачлагч Мандхай гишүүн хариулъя.

М.Мандхай: Батжаргал гишүүнийг бас яг маш чухал асуудлыг хөндөж ярьж байгаад бас баяртай хүлээж авч байна. Ер нь бол судалгааны хувьд бид нар түрүүн хэлсэн. Хүн амын хоол тэжээлийн байдал үндэсний 5, 6 дугаар судалгаа хийгдээд дууссан. Ингээд 5 жил тутамд хийгдэж байгаа. 2017 онд 1 хийгдсэн. Сая 2023 онд. Ер нь тэгээд энэ судалгаан дээр бол үндсэндээ бид нар хоол тэжээлийн ерөөсөө бүхий л үзүүлэлтийг бүс нутаг, хүн амын байршил, нас хүйсээр нь харьцуулж үнэлээд, хооллолтын чанарт анх удаагаа үнэлгээ өгсөн байдаг юм. Тэгээд Туяацэцэг доктор бол бас энэ дээр нэлээн нарийн мэдээлэл өгнө биз. Би зүгээр сүүлийн статистик хэлэхэд 1 хүнд ноогдох илчлэг бүтээгдэхүүн калори нь аваад үзэх юм бол маш харамсалтай тоо байгаа. Үндсэндээ нийт манай идэж байгаа хүнсийг ингээд бүтэцлээд Pie chart харах юм бол ерөөсөө мах 27% үр тарианы бүтээгдэхүүн буюу улаан буудай гурил 34%. Ингээд нийлээд бол үндсэндээ 50% нь манай бид нарын идэж байгаа 1 хоногт идэх илчлэг бүтээгдэхүүн калори нь явчхаж байгаа юм. Тэгээд сүү бол 5 хувь, өндөг бол бүтээгдэхүүн бол 1 хувь байгаа. Гэтэл энэ дээр онцлоод хэлэхэд чихэрлэг хүнс бол 10% байгаа. Бид нар үндсэндээ нөгөө зохисгүй хоол хэрэглээ иддэг. Гэтэл хүнсний ногоо өөрөө бүтээгдэхүүн, нөгөө жимс жимсгэнэ

чинь хүнсний ногоо 3 хувь, жимс жимсгэнэ 1 хувьтай байгаа. Ингээд бид нарын үндсэндээ хоолны хэрэглээний асуудлыг бид нар яалт ч үгүй зохист хоол хэрэглээний асуудлыг дахиж нэг харж шинэчлэх нь бол зайлшгүй зүйтэй. Гэхдээ үүнтэй холбоотой хоол хүнсний авах ёстой одоо илчлэг, шимт бодисын зөвлөмж хэмжээ бол бид нар хангалттай жагсаалтууд гарсан байдаг.

Энэ хоол энэ амин дэмийг хэн батлаад байна гэхээр бас энэ тогтолцооны алдаа байгаа. Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын тушаал 2017 оны 2 сарын 23-ны өдөр А74 тушаалаар хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, амин дэм, эрдэс бодисын зөвлөмжийн хэмжээг Нийгмийн эрүүл мэндийн төв гаргаж өгдөг. Тэгээд Эрүүл мэндийн яаманд харьяалагдаж байгаа юм. Сайд нь гаргаж өгснийг нь Хүнс, хөдөө аж ахуйн яам нь ингээд ерөнхийдөө нөгөө мэргэжлийн хүрээлэнгүүд нь судлаач, яг энэ хоол зүйч мэргэжилтэн докторууд нь өөрсдөө байгаад хүрээлэн нь өөрөө гаргадаг биш, Эрүүл мэндийн яамнаас ингээд гаргаж өгдөг. Гаргаж өгч байгаа тэнд баг бүрэлдэхүүн өөрөө бас хүний нөөцийн учир дутагдалтай ийм одоо ийм тогтолцооны бас алдаа дутагдал байгаад байгаа юм. Тэгээд би энэ дээр бас нарийн нөгөө зохистой хоол хэрэглээтэй холбоотой асуудлыг Туяацэцэг доктор бас энэ дээр нэмэлтээр хариулаад өгөхгүй юу гэж хэлмээр байна.

Б.Бейсен: 4 микрофон нэмж хариулъя.

Ж.Туяацэцэг: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Урьд нь ийм байсан юм уу, тэр мэдээллийг одоо ашиглаад байна уу та нар гэсэн асуулт тавьж байна л даа. Тэгэхээр ер нь бол аливаа хүмүүсийн хооллолтын байдлыг өөрчилнө гэдэг бол маш урт хугацааны асуудал байдаг. Ер нь судлаачийн хувьд, энэ салбарын хүний хувьд хэлэхэд бол Монголчуудын хооллолт бол амьдралын хэв маяг суурин амьдралд бид нар шилжээд бас тодорхой 100-аад жил болж байна шүү дээ. Ингэхэд бол уламжлалт хоолны хэрэглээ бол нэг их өөрчлөгдөөгүй манайд. Энийг юугаар харуулж байна гэвэл нөгөө хооллолтын хоол тэжээлийн байдлын судалгаануудаас харахад бол манай бид нарын хэрэглээ ер нь дутагдаад байгаа зүйл эрүүл мэндийн байгууллагаас гаргасан хоногт хэрэглэх уураг, нүүрс ус, өөх тосны хэмжээ, ямар хүнсний бүтээгдэхүүнийг хэчнээн хэмжээгээр хэрэглэх вэ гээд гаргачихсан энэ заалтыг ерөөсөө биелүүлдэг хүн бараг байдаггүй гэсэн үг. Бодит хэрэглээний судалгааны жишээг аваад .../минут дуусав/

Б.Бейсен: 4 номер нэмж хариулъя. Миний хэлснээр уураг, нүүрс ус, өөх тосны хэрэглээг ерөөсөө бодит хэрэглээний судалгаанаас харахад бол хоногт авах илчлэгийнхээ 63%-ийг зөвхөн буудайн гурилаар авч байна гэсэн ийм судалгаа гарч байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар яаж байна вэ гэхээр гурил хэрэглэхдээ дандаа цагаан гурил хэрэглэдэг. Нүүрс усны хэрэглээ бид нарт хэт өндөр байдаг. Тэгээд уламжлалт тэр мал аж ахуй эрхэлж байсан үеийнх шиг хөдөлгөөн энерги зарцуулалтын хэмжээ бол өнөөдөр шал өөр болсон байгаа. Тийм учраас унаагаар ажилдаа очдог. Явган явах нь цөөрсөн. Биеийн хүчний ажил маш цөөрсөн учраас бид нарын хооллолт хэвээрээ байгаад байгаа учраас яаж энэ амьдралын хэв маягийн өөрчлөлт бол маш их нөлөөлж байна гэж энд үздэг. Түүнээс бол зах зээлээс өмнөх үед идэж байсан зүйлээ тэр үеийн хэрэглээгээр одоо дүгнээд байна уу гэвэл үгүй байгаа. Тэгэхээр энэ хэрэглээ дээр бас харахад бол хүнсний ногоо, жимс жимсгэнийг түлхүү хэрэглэх ёстой. Гэтэл монголчуудын хэрэглээ бол маш бага байдаг.

Б.Бейсен: Жигжидийн Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Тэгэхээр бидэнд энэ хүнсний бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт гэдэг юм уу, анхдагч бүтээгдэхүүн гэдэг юм уу энэ асуудал дээрээ тавих асуудал нь нэлээн чухал байгаад байх шиг байгаа юм. Мал аж ахуйн салбараас гарч ирж байгаа газар тариалангийн салбараас гарч ирж байгаа бүтээгдэхүүнүүд дээр дан дамаа ургамал хамгааллын бодисын үлдэгдэл гэдэг юм уу, эрүүлжүүлэлтийн бодисын үлдэгдэл юмнуудыг хэдүүлээ яаж баталгаажуулж, ёстой өнөө зөв дадлын тухай юмаа ярих юм. Энэ дотор ямар үг, өгүүлбэр явах юм гэдэг асуудал байгаад байгаа юм.

2 дугаарт нэгэнт бид өөрсдөө үйлдвэрлэж чадахгүй байгаа зүйлүүдээ импортын тухай ойлголт байгаа. Түүнийгээ яаж хэдүүлээ баталгаажуулж явах юм гэдэг асуудал байгаад байгаа.

3 дахь миний хэлмээр байгаа зүйл баялаг бүтээгчдээ дэмжих ёстой, тэрийг ер нь хараа хяналтгүй юу хийж чадаж байгаа юмаа хий гэдэг юм яриад болохгүй байгаа. Гэтэл хүнс юм бол эргээд сөрөг юм гарна. Яаж/минут дуусав/

Б.Бейсен: Мандхай гишүүн хариулъя.

М.Мандхай: Яах вэ, Хүнсний тухай хууль бол өөрөө малгай хууль. Суурь хууль гэж хэлж болно. Тэгэхээр нөгөө хүнсний сүлжээ гэдгийг хэнийг хамруулах вэ гэдэг гол агуулга хүрээнд бүх анхан шатнаасаа эцсийн хэрэглэгч хүртэлх энэ сүлжээг бол энэ дээрээ тусгаж өгсөн. Түрүүн таны хэлдэг нөгөө үйлдвэрлэл, үйлчилгээ, хоол бүр анхан шатын түвшинд хүнсний анхан шатын болон боловсруулах үйлдвэрлэл, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хадгалалт, тээвэрлэлт, түгээлт, тэгээд нөгөө худалдаанд холбогдох стандарт техникийн зохицуулалтыг бол оруулах, мөрдөгдөх шаардлагатай талаар бол хуульд оруулсан. Хүнсний бүтээгдэхүүн өөрөө баталгаатай байна уу, импортоор орж ирж байгаа хүнс нь өөрөө хяналттай, баталгаатай байна уу гэдэг нь өөрөө Хүнсний бүтээгдэхүүн аюулгүй байдлын тухай хуульд дараагийн хэлэлцэх хууль дээр бол бас нэлээн нарийвчилж оруулж өгсөн байгаа. Энийг яаж хяналттай байлгах вэ гэдгийг одоо байгаа хяналтын тогтолцоо .../минут дуусав/

Б.Бейсен: Мандхай гишүүн гүйцээж хариулъя.

М.Мандхай: Тэгээд сая Хөдөө аж ахуйн тухай хууль маань хэлэлцэх эсэх маань дэмжигдээд явчихлаа. Ингээд энэ хууль батлагдаад ирэх юм бол илүү нарийвчлаад анхан шатын малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг өөрөө бүр малчны хотноос эхлээд бэлтгэгдэж байгаа түвшинд нь төвлөрүүлэх цэг маань өөрөө тодорхой хэмжээний зохистой дадал, стандарт техникийн зохицуулалтын шаардлагыг хангасан. Үүнээс тээвэрлэгдээд дараагийн хагас боловсруулах үйлдвэр дээр очих хүртэл стандарттай явахыгаа бол хуульд бас заагаад өгсөн. Хүнсний нөгөө үйлдвэрлэл нь бол ялгаа байхгүй бас нөгөө малын гаралтай бус хүнсний бүтээгдэхүүн ч гэсэн яг энэ одоо стандарт техникийн зохицуулалтыг дагаж мөрдөнө гэдэг энэ 2 хууль дээр бол нарийвчилж бас оруулсан. Бүр бүтээгдэхүүний нарийн байдал бол Хүнсний бүтээгдэхүүн аюулгүй байдлын тухай хууль дээр дараагийн нөгөө хэлэлцэх асуудал дээр нэлээн нарийвчилж тусгасан байгаагаа бас хэлэлцэх болно.

Б.Бейсен: Надад 1 асуулт байна. Энэ хуулийн төслийг баталснаар улсын төсвийн орлогын хэмжээ буурах, зарлагын хэмжээ нэмэгдэхээр байвал яах вэ. Мандхай гишүүн хариулъя.

М.Мандхай: Энэ хуулийн зардлын тооцоо хийсэн байгаа. Зардлын тооцоо дээр бол ямар ч нөгөө нэг нэмэлт зардал төсөвт ачаалал өгөхгүйгээр хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийсэн байгаа.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хууль санаачлагчийн танилцуулгатай холбогдуулан санал хэлэх гишүүн байвал нэрс өгнө үү. Санал хэлэх гишүүн байхгүй байна. Ганбаатар гишүүн, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн, Замира гишүүн 3 үг хэлэх юм байна. Замира гишүүн санал хэлье.

С.Замира: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Хүнсний аюулгүй байдлын асуудал маш их асуудал үүсгэж байгаа нь ойлгомжтой. Тэгэхдээ ер нь манай үндэсний мал аж ахуй, газар тариалан, ер нь энэ чиглэлийн үйл ажиллагаа нь яг юуны дагуу болж байна уу, үгүй юу. Тэр газрыг засаж байгаад бордоо ч гэх юм уу, тэгээд малд тарьж байгаа тэр тариа энэ бүхэн ер нь яг манай юунд тарж байна уу. Шинжлэх ухааны үндэслэлтэй вакцин хийгдээд байна уу гэдэг асуудал манай гол асуудал шүү дээ. Агаарын бохирдол энэ бүхнээс болоод манай Монголд хорт хавдар ихэссэн. Газрын хөрс бохирдсон, малын махан чанар алдагдсан тийм байдалтай байгаад байгаа юм. Тэгэхдээ бол би энэ хуулийг дэмжиж байна. Дэмжлээ гэхэд нэг асуудал үүсгэхгүй байхыг бас хууль санаачлагчдаа анхааруулмаар байна. Одоогийн байдлаар Монголд бол ер нь жижиг дунд бизнес эрхлэгчид өрхийн орлого маш их буурсан байгаа. Хэрвээ энэ хууль батлагдсанаар бол тэр гэр бүлээрээ нийлээд хуушуур хийгээд гээд гишүүд ярьж байна л даа. Наадмаар ч гэсэн хаана бол хаана гээд хэдэн бор цаасаа болж байгаа айл өрхөд ачаалал болохгүй байх талаас нь энийг бас харж үзэх нь зүйтэй болов уу гээд бодож байна. Том компаниуд энийг дааж чадна. Том бизнес эрхлэгчд энийг бол яах вэ даван туулж магадгүй. Тэгэхдээ энэ чинь эцсийн эцэст өрхийн орлого дээр жижиг, дунд бизнес хөгжүүлнэ гээд ЖДҮ-ийн ажлын хэсэг нь ажиллаад яваад байгаа. Энэ бүхэнд ачаалалтай ачаалал үүсгэхгүй байхыг бас анхааруулъя.

Тэгээд уг нь манайд бол хуулиас л болоод ер нь хууль дутуугаас болоод манайд хорт хавдар ихсээд байна уу, эсвэл бидний хийх ёстой газрын хөрс мал махны м чанар алдагдсанаас болоод, хэрэглэж байгаа эд хэрэглэлээс л болоод хүнсний биш жишээлбэл бидний хөдөөгийн малчдын хэрэглэж байгаа тэр пивор сав гэдэг нь тэр чигээрээ хорт хавдар үүсгэх хэмжээний юм байхгүй юу. Хүнсээ бид нар шинжлээд яваад байдаг. Тэгсэн чинь хэрэглэж байгаа сав, баглаа боодол нь бас аюултай түвшинд яваад байгаа шүү дээ. Тийм учраас энэ бүх юман дээр ер нь манай төр засаг нь ч бай, хууль санаачлагч ч бай бүгд анхааралдаа ингээд иж бүрэн юм хийвэл аштай юу даа гээд бодож байна. Хуулийн төслийг дэмжиж байна. Баярлалаа.

Б.Бейсен: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн санал хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Хуулийн төслийг дэмжиж байгаа. Яах вэ, нэг харамсалтай юмнууд байгаа юм л даа. Яалт ч байхгүй энэ хуульд өөрчлөлт оруулах ёстой юм уу, эсвэл энэ төрийн захиргааны төв байгууллагуудын хариуцлагагүй үйлдэлтэй холбоотойгоор өнөөдрийг хүртэл явчихсан асуудлууд юм уу. Бид нар энэ асуудлыг бодох л ёстой. 0-18, 0 ч арай орохгүй байх. 18 хүртэлх насны хүүхдүүд 100 мянга хүртэлх хүүхдүүд хоол боловсруулах тогтолцооны өвчлөлөөр жил болгон өвдөж байгаа гэдэг ийм мэдээлэл байгаа. Тэгээд энэ өөрөө маш харамсалтай тоо. Өнөөдөр бид нар дэлхийд хорт хавдраар 1 номерт орчихсон гээд л ярьж байна. Хүнсний аюулгүй байдал болон хүнсний баталгаат байдалтай холбоотой асуудлуудыг хөндөж байгаа. Тэгтэл өнөөдөр энэ хийсэн үнэлгээгээр цэцэрлэг,

сургуулийн хоол үйлдвэрлэлд хамгийн үнэтэй, хамгийн чанаргүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэгдэж бай байгаа нь хүнсний хангамжийн 1 хэсэг болсон хүүхдийн хүнсний хангамж, ханган нийлүүлэлтийн асуудал нь хүнсний болон боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дунд зохицуулалтгүй орхигдсонтой холбогдолтой гэж байгаа юм. Хаана байна тэр Боловсролын яам. Нөгөө мундаг мундаг юм яриад байдаг. Өнөөдөр улсын төсөв орж ирж байгаа. Барилга байшин барих тухай л яриад байгаа. Чанарыг ерөөсөө хөндөхгүй байгаа. Багш нарын чанарыг хөндөхгүй байна. Хоол хүнс, хүүхдүүдийн өдрийн хоолны мөнгийг нэмсэн тухай л яриад байгаа юм. Тэжээлийн хомсдол, энэ чанарын шаардлага хангахгүй байгаа асуудлуудыг бас л хөндөхгүй байгаа юм. Энэ бол асуудал.

Нөгөөдөх нь энд бас нэг харамсалтай юм байна л даа. 7 дээр хүнсний сүлжээнд тээвэрлэлт, хадгалалт, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбогдсон харилцаа зохицуулалтгүй үлдсэн гэж байгаа юм. Хөдөө аж ахуйн яам хийж байсан юм. Албан тушаалтнууд юу хийж байсан юм жишээлбэл. Энэ зохицуулалтгүй харилцаа яагаад өнөөдрийг хүртэл явсан байгаа юм. Энэ дан Улсын Их Хурлын гишүүдийн хийх ёстой ажил биш шүү. Тухайн салбар, тухайн бодлогыг зангидаж ажиллаж байгаа төрийн захиргааны байгууллага, бүр төв байгууллага энэ алдааг олж хараад, засаж сайжруулахтай холбоотой асуудлуудыг шийдвэрлүүлэхийн төлөө явж байх ёстой. Энэ шийдэгдэхгүй байна.

Өнөөдөр бид нар хоол хүнсний маань дийлэнх нь ус, махнаас бүрдэж байгаа юм. 2022 оны 1 сарын 18-ны өдөр би Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болж байсан юм. Тодорхой асуудлуудыг хөндөж байсан. Засгийн газрын хуралдаан дээр. Мал маань амьд байхдаа эрүүл байна. Мах болоод хүн амын хэрэгцээнд нийлүүлэгдэхдээ стандартын бус нядалгаанаас улбаатайгаар өвчин тусчхаад байна. Тээвэрлэлтээс өвчин тусчхаад байна. Хадгалалтаас болоод өвчин тусчхаад байна. Тэгээд өвчтэй мах бид нар идээд байна. Энийг хөндөж байсан. Энэ асуудал өнөөдөр ямар түвшинд явж байгаа вэ. Энийг бид нар хөндөх л ёстой асуудал.

Нийт суурин газрын 51% нь ундны усны шаардлага хангахгүй байгаа. Бид нар бүх хоолоо усаар хийж байгаа шүү дээ. Өнөөдөр гарч ирж байгаа бүтээгдэхүүнтэй холбоотой асуудлаа хөндөөд байдаг боловч түүнтэй холбоотой түүхий эдийг нь ерөөсөө ярихгүй байгаа. Махныхаа эрүүл аюулгүй байдалтай холбоотой асуудал, усныхаа эрүүл аюулгүй байдалтай холбоотой асуудал. Энэ чинь өөрөө хүнсний аюулгүй байдалтай холбоотой асуудал болчихоод байгаа юм л даа. Тэгээд энийгээ л бид нар төрийн захиргааны төв байгууллагууд маань энийгээ их сайн анхаарч ажиллаасай гэж хүсэж байгаа юм.

Би тэгээд энд бас нэг юм харлаа л даа. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал гэдэг нь хүнсний бүтээгдэхүүн нь хэрэглэгчдэд хор хөнөөл учруулах аливаа бохирдол, өвчин үүсгэгчээс ангид байх нөхцөлийг хангах үйл явц, зохицуулалтыг хэлнэ ээ гэж зааж өгсөн байгаа. Хүнсний баталгаат байдал гэдэг нь хүн амын бүхий л хэсэг нь орлогын түвшин, нийгмийн байдлаас үл хамааран хүссэн үедээ хэрэгцээт хэмжээний шим тэжээлтэй, аюулгүй хоол хүнсээ авч чадах боломж, хэрэгцээтэй байдлыг илэрхийлдэг ойлголт юм гэж байгаа юм. Тэгээд хэдүүлээ энэ хуулиар энийг засацгаая.

Б.Бейсен: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн санал хэлье.

С.Ганбаатар: Би 3 санал хэлье. Төрийн үндсэн үүрэг бол иргэдийн аюулгүй байдал. Уул уурхай ухна ч гэдэг юм уу, эсвэл мөнгөтэй болно гэсэн юм ярьсангүй шүү дээ. Иргэдийн аюулгүй байдал. Тэр дотор эдийн засгийн аюулгүй байдал, тусгаар тогтнолын аюулгүй байдал гээд зөндөө олон явж байгаа. Тэр дотор иргэд ам руугаа хийж байгаа энэ хүнс, хоол хүнс аюулгүй байх баталгааг төр өгдөг бас энэ ажлыг хийх гэж энэ хууль орж ирж байна гэж би ойлгож байна. Тэгэхээр хүнсний аюулгүй байдал гэдэг бол ямар ч хувийн компани том байгаад хажуудаа эрдэм шинжилгээний институт ажиллуулахгүй, дүгнэлт гаргахгүй, энийг судлахгүй аль болохоор ашгаа нэмэхийг л бодно. Тэдний буруу биш. Тэдний зовлон зүтгүүрийг бол сонсох ёстой. Тэгээд хуульд юу хэлэх гээд би хэлж байна гэвэл түрүүний гишүүдийн санал болох ЖДҮ-лэгч, хүнс үйлдвэрлэгчдийн санаа бодлыг энэ хууль дээр тусгаж, яг нарийн яривал тэр гадаад орнуудын туршлагуудаас харж байхад хүнс үйлдвэрлэгчид яг төрөөс эрдэм шинжилгээний болон энэ дээр ийм судалгааны ажлууд хийхийг өөрсдөө маш их хүсдэг. Энийг тээг садаа гэж ерөөсөө хардаггүй. Энэ салбарыг бүхлээр нь урагшлуулах гэж байна гэж хардаг. Тэгээд харин энэ дээр тусад нь зөвлөх үйлчилгээ үзүүлэх тэр тал дээр нь бол хуулийн зүйл заалтууд дээр бас харах юм байна. Тэгэхгүй жижгүүдээ ширвэнэ гэсэн үг, үсэг энэ дээр алга байна.

2 дугаарт би энэ хүнс үйлдвэрлэлийн тал дээр том мэдлэгтэй хүн л дээ. Миний ээж тогооч байсан. Одоо тухайн үеийн социализмын хэллэгээр бол нийтийн хоолны ажилтан гэж нэрлэдэг байсан. Нийтийн хоол гэдэг бол шинжлэх ухаан. Тэгээд бууз чимхэхээр нэг ийм цэцгэн, 4 хуруугаар шууд чимхчихдэг. Одоо ч би цагаан сараар тэгж чимхдэг. Тэгээд ээж ээ, яагаад ингэдэг юм бэ гэсэн энэ манай стандарт байгаа юм. Нийтийн хоолны стандарт, түүхийрдэггүй юм гэсэн. Тэгэхээр бууз чимхэхэд хүртэл ийм стандарт байсан юм байна. Одоо энэ асуудлуудаа бас шинэ шатанд гаргах цаг болчихсон байна. Одоо бол энэ сургуулийн хүүхдүүдийн идэж байгаа тэр олон чанасан пирожки гэдэг бол хор юм шиг л надад санагдаад айдас төрдөг л дөө. Тэгэхээр миний хэлэх гээд байгаа 2 дахь санаа бол эрдэм шинжилгээний судалгааны энэ ажлууд дээр бол төр хариуцах ёстой. Энийг заавал хуульчилж оруулахаас өөр арга байхгүй. Харин энэ зүйл, тэр хүнс үйлдвэрлэгчид, хүнсний нийтийн хоолны энэ асуудал дээр яаж хууль хэрэгжих вэ, баталгаа нь хаана вэ гэдгийг л онцгой анхаармаар байгаа юм. Миний их бас дэмжиж байгаа чухал хууль орж ирсэн байна. Энэ хуулийг бол дэмжиж байна.

Б.Бейсен: Миний хувьд энэ хуулийн төслийг дэмжиж байгаа юм. Гэхдээ анхаарах хэд хэдэн асуудал байгаа. Монгол Улсад хүнсний аюулгүй байдал алдагдаад хавдрын өвчлөл бараг дэлхийд тэргүүлэх байранд орчихсон. Та бүгд мэдэж байгаа. Гений үрэвсэлтэй, кимикат ихтэй, пестицид, гербицид ихтэй тийм хүнсний ногоог энэ 330 сумын сургуулийн дотор байр, ясли, цэцэрлэгүүд их хэрэглэж байна. Ер нь хамгийн хямдыг хэрэглэж байна. Эх орны хөрсөнд ургасан тийм хүнсний ногоог авч хэрэглэхгүй байна. 9-ийн тос, төмс, байцай, лууван наад зах нь сонгино. Хамгийн чанаргүй хямд юмыг энэ сургуулиудаар хэрэглэж байгаа. Сумуудаар яваад дотуур байрны гал тогоогоор ороод үзээрэй. Тийм учраас үүнтэй асуудлыг бас анхаараад, хуулийн төсөлдөө тусгаад, хяналтын асуудал дээр нэлээн анхаарахгүй бол болохгүй байх гэсэн саналыг хэлье.

Гишүүд санал хэлж дууслаа.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдье. Гишүүд ирцэд орж ирээрэй. Санал

хураалт явах гэж байна. Дамдинням гишүүн албан ёсны чөлөө авсан учраас ирцээс хасъя. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 56,5 хувиар дэмжигдлээ.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар санал дэмжигдлээ.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар санал дэмжигдлээ.

Баяжуулсан хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 14 гишүүн дэмжиж, 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Би дэмжсэн юм. Энэ ороогүй байна. 14 гишүүн дэмжиж, 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 54,5 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 14 гишүүн дэмжиж, 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар санал дэмжигдлээ.

Органик бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Би дэмжиж байгаа шүү. Яагаад эсрэг гараад байна. Дараад байхад эсрэг гараад байх юм. 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар санал дэмжигдлээ.

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 14 гишүүн дэмжиж, 63,6 хувиар дэмжигдлээ. Би буруу дараад байсан байна шүү.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье

гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 15 гишүүн дэмжиж, 68,2 хувиар санал дэмжигдлээ.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын өрөөнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 14 гишүүн дэмжиж, 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 14 гишүүн дэмжиж, 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Болдын Уянга гишүүн танилцуулна.

17.00 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэж эхэлье.

Хууль санаачлагчийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Лүндэг танилцуулна. Лүндэг гишүүний микрофон өгье.

С.Лүндэг: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахад дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлагатай байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, мөн улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд хүнсний сав, баглаа боодол, бордоо, ургамал хамгааллын бодис ашиглах, хяналтыг сайжруулах, эрсдэлийн үнэлгээ хийх замаар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн баталгаат байдлыг хангахтай холбогдсон стратегийг тодорхойлжээ.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2022 оны хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.4-д Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан. Дээр дурдсан хууль тогтоомжид заасан зорилго, зорилтын хүрээнд баталгаат хүнсээр хэрэглэгчийг хангахтай холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэр томъёог ойлгомжтой болгох, хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх зорилгоор Монгол хэлний бодлогын үндэсний зөвлөлийн хэлэлцэн баталсан Хүнсний нэр томъёоны толийг баримтлан “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн нэр томъёог хүнсний баталгаат байдал гэж өөрчилж тусгасантай холбоотойгоор Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн нэрийг зайлшгүй өөрчилж,

холбогдох зүйл заалтад байгаа хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал гэсэн үг хэллэг, бичвэрийг өөрчлөх шаардлага гарсан.

Иймд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, дараах харилцааг зохицуулахаар тусгав. Үүнд:

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн нэр томъёог “хүнсний баталгаат байдал” болгон өөрчилсөнтэй уялдуулан хууль хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн нэрийг Хүнсний баталгаат байдлыг хангах тухай гэж өөрчилж, холбогдох зүйл заалтад өөрчлөлт оруулах.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор баталгаат байдалд хяналт тавих тогтолцоог оновчтой болгох, мэргэжлийн удирдлагаар хангах, хүнсний хяналтын бодлого болон хүнсний баталгаат байдлыг хангах тогтолцоотой холбогдсон зохицуулалтыг нэмж тусгана.

Хүнсний хяналт зохицуулалтын байгууллага болон лабораториудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, чадавхыг дээшлүүлэх зорилгоор үндэсний лавлагаа лабораторийн харьяаллын өөрчлөх, Төрийн, орон нутгийн болон хувийн хэвшлийн хүнсний сорилын лабораторитой урт хугацааны хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллах, Лабораторийн санхүүжилттэй холбоотой харилцааг зохицуулахаар тусгана.

Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн хариуцлагыг өндөржүүлэх, хүнсний сүлжээний бүх үе шатын үйл ажиллагааг бүрэн зохицуулах зорилгоор хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч бүр өөрт хамаарах үйл ажиллагааны үе шат бүрд зохистой дадлын мөрдөхөөр тусгана.

Үйлдвэрлэл эрхлэхдээ бүртгэгдээгүй хугацаа хэтэрсэн хүнсний нэмэлт хэрэглэх, эсхүл хэтрүүлэн хэрэглэх, дур мэдэн хэрэглэх, зориулалтын бусаар хэрэглэх, ургамал хамгааллын бодис, бордоо зэргийг технологийн бус аргаар хэрэглэхийг хориглож, зөрчсөн нь лабораторийн шинжилгээгээр тогтоогдвол холбогдох этгээдэд хариуцлага хүлээлгэхээр заана.

Эрүүл хооллолтыг дэмжих, эрүүл бус хооллолтыг хязгаарлах, хориглох замаар хэрэглэгчийн хоол хүнсээ зөв зохистой хэрэглэх, эрүүл мэндээ хамгаалах, соёлыг төлөвшүүлэх зорилгоор нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хоолны цэсийн шошго, зар сурталчилгаа, нийтийн хоол үйлдвэрлэл үйлчилгээ, тухайлбал нийтийн бусад орчинд үйлчилдэг гуанз, хоолны газар, хоол, хөнгөн зууш, түргэн хоолны газар, хуушуурын цэгт хоол үйлдвэрлэл үйлчилгээний холбогдох стандартыг мөрдүүлэхээр заана.

Мөн хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хүнсний бүтээгдэхүүнийг татварын бодлогоор дамжуулан хязгаарлах, хүний бие махбодын хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөх агууламжтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг зээлийн бодлогоор дэмжихээр тусгана.

Мөн хэвлэл мэдээллийн байгууллагад хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц хүнсний бүтээгдэхүүнийг дэмжин сурталчлахгүй байх, энэ талаар сэрэмжлүүлэг анхааруулга өгч байхыг үүрэг болгоно.

Стандарт, техникийн зохицуулалтаар зохицуулах боломжтой харилцааг журам, аргачлал, зөвлөмжөөр зохицуулахаар заасныг өөрчилж, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч өөрт хамаарах үе шатад тохирох зохистой дадлын стандартыг мөрдүүлэхээр тусгана.

Хууль хэрэгжсэнээр хүнсний хяналтын бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах, төлөвлөх, төсөвлөх, түүнийг хэрэгжүүлэх хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнгээр хүнсний хяналтын бодлогыг засаж залруулж, эргэх холбоо хангагдана. Ингэснээр хүний баталгаат байдал хангагдаж, хэрэглэгч эрүүл хүнс сонгох, хэрэглэх боломж нэмэгдэнэ.

Зах зээл дээр худалдаалагдаж байгаа дотоодын, импортын болон экспортын хүнсний хяналт тогтмолжиж хүнсний баталгаат байдал сайжирч, хүн амын хүнснээс шалтгаалсан халдварт болон халдварт бус өвчлөл буурч эрүүл мэндийн салбарын болон хувь хүний зардал багасна.

Хэрэглэгч нь эрүүл мэнддээ сөрөг нөлөө үзүүлэх орц найруулгын агууламжтай бүтээгдэхүүн сонгон авахаас татгалзан өөрийн эрүүл мэндийг хамгаалж хүнсний баталгаат байдлыг хангахад өөрийн хувь нэмрийг оруулна.

Хүнсний үйлдвэрлэлд хугацаа хэтэрсэн хүнсний нэмэлт хэрэглэх, хүнсний нэмэлт хэтрүүлэн хэрэглэх, дур мэдэн хэрэглэх, зориудын бусаар хэрэглэх пестицидийн болон антибиотикийн үлдэгдэл агуулсан түүхий эд хэрэглэх зөрчил арилна.

Дээр дурдсан холбогдох хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой уялдуулан боловсрууллаа.

Хууль хоорондын уялдаа холбоог хангах үүднээс дараах хуульд нэмэлт, өөрчлөлтийг оруулна. Энэ хууль батлагдсантай холбогдуулан Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан хууль хоорондын зөрчил, давхардлыг арилгах, үг хэллэгийг жигдлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Малчны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Таримал ургамлын үр сортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Дээр дурдсан холбогдох хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Хүнсний тухай хууль болон бусад хууль тогтоомжтой уялдуулан боловсрууллаа.

Иймд дээрх асуудлыг хэлэлцүүлэхээр дэмжиж өгнө үү. Баярлалаа.

Б.Бейсен: Лүндэг гишүүнд баярлалаа. Илтгэлтэй холбоотой ирсэн ажлын хэсгийг танилцуулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Довчинсүрэн Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Д.Есөн-Эрдэнэ Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Б.Батшагай Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Д.Энхмаа Хүнсний аюулгүй байдлын шинжээч, доктор, Ж.Туяацэцэг Зөвлөх инженер, доктор, дэд профессор, С.Өнөрсайхан Анагаах ухааны доктор, профессор.

Хууль санаачлагчийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Батжаргал гишүүнээр тасалъя. Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууя.

Ц.Туваан: Энэ хуулийн Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах гээд энэ дээр нэр томъёоны өөрчлөлт орж байгаа юм байна. Нэр томъёо ч яах вэ ингээд бас нөгөө олон улсад хэрэглэдэг нэршил нь манайд бас зохицохгүй байна энэ тэр гээд л ярьдаг. Тэгэхээр тэр байдлаар хандаж байгаа юм шиг байна. Энэ дээр хамгийн гол нь энэ сая тэр хууль санаачлагчийн илтгэлд ороод байна. Нөгөө food supply chain гээд энэ хүнсний гинжин хэлхээ гээд яриад байгаа. Энэ дээр чинь нөгөө хүнсний аюулгүй байдалтай, энэ баталгаат байдалтай холбоотой асуудлууд яригддаг л даа. Тэгэхээр энэ дээр ямар ч хяналтгүй явж байгаа 1 зүйл байна. Ялангуяа энэ хөдөө малчдын дунд энэ евомикийн хэрэглээ, энэ цагаан тариа гээд нэрлэчихсэн. Бүхий л өвчинд хийж байна. Ерөөсөө мал жоохон өвдлөө л гэхэд цагаан тариа, ямар нэгэн асуудал болоход л нөгөө евомик тарьдаг. Тэгээд эд нар чинь бүгдээрээ хор шүү дээ. Тэгээд мал тарьснаас хойш 14-21 хоног гээд, тарьсны дараагаар хүнсэнд хэрэглэж болно энэ тэр гээд. Тэгээд энэ байдал бол бүр замаа алдсан. Тэгэхээр энэ асуудлыг ядаж нэлээн онцгой анхаараад тусгаад ингээд энэ дээрээ ахиц гаргамаар байна. Тэр бүртгэл энэ тэртэй холбоотой, эмийнхээ борлуулалт хяналттай холбоотой асуудал дээр.

Ургамал дээр бол энэ гербицид, пестицидийн хэрэглээ бол бүр бас замаа алдсан. Дуртай нь оруулж ирдэг. Хаа хамаагүй зах дээгүүр хүртэл зардаг. Нэг нэгнээсээ дамжуулаад явдаг. Тэгээд цацаад хэрэглэдэг. Мөн л технологийн горим, нөгөө саармагжих, хор саармагжих хугацаа бол бүр өнгөрсөн. Үүний үр дүн юу болж байна гэхээр үр дүн нь улс орон даяараа түрүүн Бейсен Байнгын хорооны дарга хэлж байна лээ. Хавдрын өвчлөл гэдэг зүйл бол замаа алдсан. Тэгээд л тэр нөгөө өсөлтгүй жирэмсэн, амьгүй ураг гээд юмнууд чинь энд бас замаа алдсан. Элэгний өвчлөл бас замаа алдсан. Тэгэхээр хэдүүлээ нэгэнт энэ хууль дээрээ гар хүрч байгаа юм бол ганцхан нэр томъёо өөрчлөөд энэ асуудлуудаа ярихаас гадна бодитой үр дүн гаргах асуудлууд дээрээ жоохон анхаарчихвал яасан юм бэ гэдэг саналыг хэлэх гээд байгаа юм. Тэгээд одоо яг тэр гинжин хэлхээ дээрээ малаа бүртгэлжүүлэх, ээмэгжүүлэх, тэр таримлуудынхаа нөгөө хор пестицид, гербицидийнхээ хэрэглээг хянах гээд одоо нөгөө хянадаг байсан Мэргэжлийн хяналт байхгүй болсон. Одоо чухам хаана яваа юм бүү мэд. Ингээд бид хэд ухраад байна. Тэгэхээр энэ талын асуудлууд тодорхой ахиц өөрчлөлт гарахаар хуульд тусгагдаж чадаж байгаа юу гэдэг зүйлийг асууя.

Б.Бейсен: Лүндэг гишүүн хариулъя.

С.Лүндэг: Туваан гишүүн маш зөв зүйтэй асуулт тавьж байна. Тэгээд ер нь бол аль алиныг нь анхаараад, оруулж явж байгаа. Мэргэжлийн хяналтын асуудал бас их чухал байгаа. Тэгээд бас яг өнөөдрийн нөхцөл байдалд болохгүй байгаа учраас

бид нар харин тэр судалгаа шинжилгээний байгууллага гэж байгаа. Тэгэхдээ энэ дээр ерөөсөө юу байхгүй нэмэлтээр орон тоо нэмж байгаа юм биш. Одоо Хөдөө аж ахуйн яам дээр ч хариуцсан хүмүүс байгаа. Энэ хариуцаж байгаа хүмүүс байгаа. Энийгээ нэгдсэн тогтолцоонд оруулаад, лабораторитой ядаж болж авахгүй бол бид нар болохгүй болчхоод байгаа юм өнөөгийн нөхцөл байдал. Тэгэхээр эхний ээлжид лабораторийнхоо хүчин чадлыг сайжруулах хэрэг байгаад байгаа. Тэгээд энэ асуудал явж байгаа учраас гишүүд маань бас энийг дэмжиж өгөөч ээ гэж 1 дүгээрт хүсэж байна.

2-т яалт ч байхгүй манай уламжлалт мал аж ахуйтай холбоотой буюу малчдаас бид нарын авч байгаа, хэрэглэж байгаа хүнсний бүтээгдэхүүн дээр бас үнэхээр шууд хянаад ч юм уу, лаборатори ч гэдэг юм уу тийм юм байх боломжгүй байгаад байгаа юм. Тэгэхдээ хуучин хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа. Хуучин хууль дээрээ ч энэ асуудал бол орчихсон байдаг. Тэгээд бид нар энийгээ л аль аль шатдаа л цаашаа ингээд явуулах л хэрэгтэй. Ялангуяа тэр ургамлын гаралтай ч юм уу тэр тариа энэ тэрийг бол бид нар хянаж тавих ёстой. Энэ дээр бас бид нар тодорхой хэмжээнд тусгаад явсан байгаа. Яг нарийвчилсан мэдээллийг манай Энхмаа доктор хариулна.

Б.Бейсен: 3 номер нэмж хариулъя.

Д.Энхмаа: Туваан гишүүний асуултад хариулъя. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль буюу Хүнсний баталгаат байдлыг хангах тухай хуульд шинээр хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд хориглох зүйл гэж оруулсан байгаа. Энэ шинэ зүйлд бол ялангуяа ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдэл, малын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх антибиотикийн үлдэгдэл зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн агууламжтай хүнс үйлдвэрлэхийг хориглоно гэж. Мөн хүнс үйлдвэрлэхдээ бүртгэгдээгүй, хугацаа хэтэрсэн хүнсний нэмэлт хэрэглэх эсвэл хүнсний нэмэлтээ нэмэлтийн хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэсэн, зориулалтыг нь өөрчилж хэрэглэсэн, хориглосон ийм заалтууд орсон байгаа. Ялангуяа сүүлийн үед болбол жимс их түүдэг. Жимсийг түүхтэй холбоотой баталгаат байдлын зохицуулалт бол өнөөг хүртэл хуульд зохицуулагдаагүй байсныг бид нар бас оруулсан. Ингэхдээ түүсэн ойн дагалдах баялгийн өнгө зүс, амт чанарыг урт хугацаанд .../минут дуусав/

Б.Бейсен: 3 номер нэмж хариулъя.

Д.Энхмаа: Тэгээд жимсний өнгө зүс, амт чанарыг урт хугацаанд хадгалах зорилгоор хүнсний нэмэлт дур мэдэн хольж хэрэглэх, зах зээлд нийлүүлэхийг хориглосон ийм яг хүнсний баталгаат байдлыг хангахтай холбоотой нэлээн нарийн зохицуулалтыг хариуцлагатай нь холбож ингэж оруулсан байгаа.

Б.Бейсен: Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: Тийм ээ, тийм. Хууль дээр бол байгаа байгаа. Ер нь манайх чинь яаж ийгээд л бүгдийг нь тусгаад л ингээд л явдаг. Миний хэлэх гээд байгаа санаа нь бол нөгөө яг бодитой ажил болгох, хяналтаа тавьж чадах, яг иргэдийн ам руу торонд ширээн дээр аюулгүй юм очих юмаа л хэдүүлээ яаж хангах вэ л гэж. Тэр нөгөө гинжин хэлхээ нь дотроосоо л яг шат шатанд нь яаж барьж авах вэ л гэдэг асуудал яриад байхгүй юу. Лангуун дээр байгаа махыг, лангуун дээр ирчихсэн байгаа төмсийг шууд шинжлээд хаанаас, хэний хотноос, хэний талбайгаас ирсэн гээд бид нар ярьдаг л даа. Мэдээж хэцүү. Гэхдээ одоо энийгээ хэрэгжүүлэхгүй бол энэ чинь

улсаараа яг эрүүл мэндийн хувьд хор идээд, өнөөдөр евомик тариулчхаад л маргааш нь зах дээр зарагдаж байгаа мах зөндөө л байна шүү дээ. Энийг л яриад байгаа юм. Тэгэхээр энэ дээр бодитой, хэлэлцүүлгийн шатад нь анхаараад явъя хэдүүлээ гэж л санал хэлье.

Б.Бейсен: 2 номер нэмж хариулъя.

Б.Алтанцэцэг: Алтанцэцэг. Туваан гишүүний асуултад хариулъя. Саяын яриад байгаа тэр ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнд пестицидийн үлдэгдэл, малын гаралтай бүтээгдэхүүн, мах, сүүнд антибиотикийн үлдэгдлийг бол хянах асуудал маш чухал. Тэгэхээр энийг бол түрүүн бид нар яриад байсан зохистой дадлыг нэвтрүүлэх, тэгээд тэрийгээ баталгаажуулснаар энэ асуудал бас нэг талдаа шийдэгдэнэ. Нөгөө талдаа болохоороо бид нар бас энэ хуулийнхаа төсөл дээр тэсвэржсэн бичил биетний тандан судалгааг 3 жил тутам хийхээр оруулсан байгаа. Энэ үлдэгдлүүдийг бол ер нь тэсвэржсэн бичил биетэн буюу бичил биетэн гэж нэрлэдэг байгаа. Тэгэхээр зэрэг антибиотикийн үлдэгдэл, пестицидийн үлдэгдэл бол малын мах, сүүгээр дамжаад, ургамлын гаралтай бүтээгдэхүүнээр дамжаад, хүний биед орж тэсвэрждэг байгаа. Тэгэхээр энэ нь нөгөө дэлхий дээр 2050 он гэхэд 10 сая .../минут дуусав/

Б.Бейсен: 2 номер гүйцээж хариулъя.

Б.Алтанцэцэг: Антибиотикийн тэсвэржилтээр нас барах гэсэн ийм олон улсын судалгаа энэ тэр байдаг. Тэгэхээр энэ бол ерөөсөө манай улсын төдийгүй олон улсад ч гэсэн маш чухал асуудал байгаа учраас энэ тэсвэржсэн бичил биетний судалгааны асуудлыг бол бас энэ хуулийн төсөл дээр 3 жил тутам хийхээр оруулж өгсөн байгаа. Эдгээр дээр үндэслээд төрийн бодлого явах, тэгээд хууль хэрэгжүүлэх асуудлууд бол бас тавигдах юм.

Б.Бейсен: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: 4 асуулт байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам дээр их яригдах юм. Хүнсний аюулгүй байдалтай холбоотой асуудал дээр, салбарын хяналттай холбоотой асуудал. Мэргэжлийн хяналтын байгууллагыг татан буулгаж, салбарын хяналтыг холбогдох яамнууд руу шилжүүлсэн. Би өөрөө Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд даргаар ажиллаж байсан хүнс. Чиг үүргийг нь сайн мэднэ. Байгаль орчны салбарын хяналт Байгаль орчны яаманд ирснээр илүү сайжирсан шүү дээ. Илүү сайжирсан. Гэтэл Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналт хаана явна вэ. Хайсан хүмүүс талаар нэг байна. Яг энэ тухай л дандаа яриад байна. Нэг салбар яаманд шилжсэн салбарын хяналт сайн ажиллаж чадахгүйгээс улбаатай Мэргэжлийн хяналтын байгууллагыг буцаж нэхэх процессууд үргэлжилж байна шүү дээ. Тэгээд энэ үнэлгээнүүд яагаад ингээд гараад байгааг би нэг асуумаар байгаа юм. Энэ дээр ахиад л орж ирчихсэн байна. Энэ нь хүнсний сүлжээний бүх үе шатад хүнсний баталгааг хангахтай холбоотой үйл ажиллагааг бүрэн зохицуулаагүй. Бүтэц, зохион байгуулалтын тогтолцоо оновчгүй болж, мэргэжлийн удирдлага болон хяналт шалгалтын бодлого алдагдаж, хүнсний сорил шинжилгээний лаборатори чадавхгүй болсон. Стандарт техникийн зохицуулалтаар зохицуулах зарим харилцааг аргачлал зөвлөмжөөр зохицуулах гэж оролдсон, хэрэглэгчийн шошготой танилцаж эрүүл хүнсээ сонгон авах чадвар сул, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь өөрт хамаарах үйл ажиллагаанд тохирох зохистой дадлын нэвтрүүлээгүйтэй холбоотой болох нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн

хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр тогтоогдсон болно гэж байгаа байхгүй юу. Тэр цэцэрлэг, сургуулийн хүүхдүүдийн хүнсний өдрийн хоолтой холбоотой асуудал бас яг энэ үнэлгээгээр ахиад тогтоогдчихсон байсан. Хүн амын хэрэглэж байгаа хүнсний аюулгүй байдал бас яг энэ үнэлгээгээр ингээд тогтоогдчихсон байсан. Тэгээд ингээд яваад байвал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хэрэг гэж байдаг юм уу. Тэгээд би энийг та нараас 1 дүгээрт өөрсдөөс чинь асуумаар байна.

1 дүгээр асуулт нь Мэргэжлийн хяналт чинь, мэргэжлийн салбарын хяналт чинь хаана байгаа юм бэ.

2 дугаар асуулт нь яагаад ингээд энэ үнэлгээгээр дахин дахин танай асуудлууд бүгд унаад байна гэдгийг би асуумаар байна. Өөрсдөөс чинь. Үнэлгээ худлаа хийгдээд байна уу. Эсвэл үнэхээр та нарын бодит байгаа нөхцөл байдал чинь ийм байгаа юм уу.

3 дугаар асуулт. Хүн амын хэрэгцээнд нийлүүлэх махтай холбоотой асуудал. Би түрүүн ярьсан. Хүн амын нийтийн хэрэгцээнд нийлүүлэх махыг стандартын шаардлага хангасан мах нядалгааны төвөөр технологийн аргаар нийлүүлэх ёстой. Гар нядалгаа одоо явж байгаа юм уу. Нөгөө Эмээлтийн махны захууд, мах нядалгааны газрууд одоо хүртэл ажилласаар байгаа юм биш биз дээ. 3 дугаар асуулт би энийг асуух гэж байна.

4 дүгээр асуулт Туваан гишүүнтэй санал нэг байна. Бид нарыг нөгөө багад халуурсан ч ээжийнхээ усыг өгч уучих, ханиад хүрсэн ч ээжийнхээ усыг уучих гээд нэг ээжийн шээсийг бид нар зөндөө уудаг байсан шүү дээ. Одоо яг тэрэнтэй адилхан болчихсон байхгүй юу наад тарианы асуудал чинь. Ямар ч өвчин байсан тэр тариаг тарьдаг, хор үр дагавар маш өндөртэй. Тэгээд энд ярьж байгаа нь болохоороо ер нь бол хийх гэж байгаа л гээд байгаа. Хэдэн жил энэ асуудал явж байгаа юм бэ. Би энийг асуух гэж байгаа юм.

Сүүлийн асуулт нь 12.11 дээр импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод агуулагдах гадаад хэл дээрх мэдээлэл Монгол хэл дээрх орчуулга агуулгын хувьд нийцсэн байна гэж орсон байгаа. Энэ хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт, ялангуяа энэ хуулийн 12.6 дээр өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаагаар импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод агуулагдах мэдээлэл Монгол эсвэл англи, орос хэлний аль нэгээр бичигдсэн байна л гэж байгаа. Тэгээд энэ хуулиараа та хэд бүх хэлийг зөвшөөрөх гэж байгаа юм уу.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах уу. Хэдэн номерын микрофон байна. 1 номерт суучих. 1 номерын микрофон.

Б.Батшагай: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батшагай. Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Хүнс, хөдөө аж ахуйн яаманд салбарын хяналт 2023 оны 1 сарын 1-ээс шилжин ирж ажилласан. Үндсэндээ үйл ажиллагаа нь бол 6 сарын 1-ээс эхэлсэн. Яагаад гэхээр бас тухайн үеийн хяналт шалгалтын төлөвлөгөө, хяналт үнэлгээний хороогоор батлагдаагүй байсантай холбоотойгоор бол үйл ажиллагаа нь 2023 оны 6 сарын 1-ээс эхлээд үйл ажиллагаа нь яг жигдрээд эхэлсэн. Өнөөдрийн байдлаар

Монгол Улсад 628 хүнс, хөдөө аж ахуйн салбарын улсын байцаагч нар байна. Энэ дотроо мал эмнэлгийн хяналтын чиглэлийн 350, хүнсний худалдаа үйлдвэрийн чиглэлийн 150, ургамал хамгааллын 30, мал үржлийн 152 гэсэн ингээд нийтдээ 620 байцаагч ажиллаж байна. Дээрх 620 байцаагч маань улсын хэмжээнд салбарын хяналтад эрсдэлийн ангиллаар үнэлэгдсэн 38,403 объектод бол хяналт шалгалтыг гүйцэтгэж ажиллаж байгаа.

Өнөөдөр хүнсний хяналтын чиглэлийн 3 чиглэл буюу хоол үйлдвэрийн үйлчилгээ, худалдаа, хүнсний үйлдвэрийн чиглэлээр бол Хүнс, хөдөө аж ахуйн яам бас холбогдох хяналт шалгалтыг хийж байгаа. 2025 оны байдлаар 2040 объектод энэ 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд бол батлагдан ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар Хүнсний болон хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг бол Монгол Улсын хэмжээнд үндсэндээ 14 салбар байгууллагууд бол хамтран хэрэгжүүлж ажилладаг. Жишээ нь, түрүүн бас гишүүдийн асуултад дурдагдаж байсан Боловсролын яаман дээр гэхэд сургууль, цэцэрлэгийн хоол хүнсний үйлдвэрлэлийн асуудал, Эрүүл мэндийн яам дээр хүнсний шим тэжээлийн байдалтай холбоотой асуудал, манай яам дээр бол хүнсний хангамж, хүртээмж гэсэн чиглэлээр, Онцгой байдлын ерөнхий газар хүнсний нөөц гэдэг ч юм уу ингээд 14 байгууллагуудын холбоотойгоор энэ хүнсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа өнөөдөр Монгол Улсын хэмжээнд явагдаж байна.

Бат-Эрдэнэ гишүүн асууж байна. Яагаад энэ байдал алдагдаад, эрсдэлийн үнэлгээгээр ийм гарсан бэ гэдэг асуултад хариулахад энэ бол өмнөх түрүүн бас Бат-Эрдэнэ дарга хэллээ. Мэргэжлийн хяналтын байгууллага байсан үеийн хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж байсан өнгөрсөн 2012 онд батлагдсан энэ хуулийн 13 жилийн хугацаанд хийсэн юугаар нь бол энэ үнэлгээ хийгдсэн болов уу гэж бодож байна. Энийг бас Энхмаа доктор үнэлгээ хийсэн ажлын хэсгийн гишүүний хувьд бас дэлгэрэнгүй хариулах байх.

Өнөөдрийн байдлаар бол хүнсний импортын асуудал бол гаалийн байгууллагад харьяалагдаж байгаа. ХАБҮЛЛ буюу Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори өнөөдөр Стандарт хэмжилзүйн газарт харьяалагдаж байгаа. Тэгэхээр энэ бусад дотоод хяналт болон хүнсний үйлдвэрүүд нь бол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд харьяалагдаж байна. Тэгэхээр энэ 3 байгууллагад ингэж бас өнөөдрийн байдлаар бүтцээр үйл ажиллагаа явуулж байгаа нь бас хүнсний аюулгүй байдлыг нэг мөр бүрэн хангуулахад нэлээд хүндрэл учирч байгаа гэдгийг бас энд цохон тэмдэглэж хэлье.

Түрүүн бас шошготой холбоотой өнөөдөр яг мөрдөгдөж байгаа хуулиар бол яг 3 хэлээр буюу Монгол, Англи, Орос хэлээр импортын хүнсний бараа бүтээгдэхүүнд хаяг шошгыг бол шаардаж, энэ стандарт бол мөрдөгдөөд явж байгаа.../минут дуусав/

Б.Бейсен: 4 асуулт асуусан байгаа. Тэр нэмж хариулаарай. Бат-Эрдэнэ гишүүний асуултад хэдэн номер хариулах вэ. 1 номерт нэмж хариулъя.

Б.Батшагай: Эмээлтийн махны үйлдвэртэй холбоотой асуултад бас нэмж хариулъя. Мах, махан бүтээгдэхүүний техникийн зохицуулалт бол 2022 онд батлагдсан. Энэ техникийн зохицуулалтын дагуу яамны харьяа байгууллага болох Мал, эмнэлгийн ерөнхий газрын Мал, эмнэлгийн хяналтын улсын байцаагчид бол Монгол Улсын хэмжээнд бол зөвхөн үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах, махан

бүтээгдэхүүнийг бол иргэдийн хэрэгцээнд нийлүүлэх тал дээр бол хяналт шалгалтын ажлыг бол жил бүр төлөвлөгөө гаргаад, зохион байгуулаад ажиллаж байгаа. Одоо ингээд махны үйлдвэрүүдийн үйл ажиллагаа сэргээд, энэ жилийн мах бэлтгэл бол нэлээдгүй эрчимтэй явагдаж байна. Үүнтэй холбоотойгоор улсын хэмжээнд 350 байцаагч яг энэ техникийн зохицуулалтын хяналтад үйл ажиллагаа тавиад явж байгаа.

Б.Бейсен: 3 номер нэмж хариулъя.

Д.Энхмаа: Салбарын хяналттай холбоотой бас нэмэлт тодруулга хийе гэж бодож байна. Монгол Улсад хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогыг бол төрийн захиргааны төв байгууллага буюу яам боловсруулж байгаа. Яам өөрөө боловсруулсан бодлогынхоо хэрэгжилтийг хангаад явж байгаа. Мөн хэрэгжүүлсэн хэрэгжилт дээрээ өөрөө хяналтаа тавиад явж байгаа. Тэгэхээр 2023 онд мэргэжлийн хяналт татан байгуулагдсантай холбоотой салбарын хяналтыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам бол нийт 19 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй шилжүүлсэн боловч 2 жилийн дотор яг энэ улсын байцаагчийн тоо 19-өөс 14 болж доошилсон гэдэг чинь бас яам улсын байцаагчийг бусад үйл ажиллагааны чиглэлд томилон ажиллуулсан ийм үр дагаврын үнэлгээгээр гарсан ер нь .../минут дуусав/

Б.Бейсен: Хариулт хангалттай юу: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя гэж байна.

Б.Бат-Эрдэнэ: Хариулт хангалтгүй байна. Асуудлаа ойлгохгүй байна. Эсвэл хариулгаас цааргалаад байна. Эсвэл цаад талд нь хувийн сонирхлууд байна. Би бол яг та нарын хариултаас ингэж л харж байна. Ний нуугүй хэлэхэд.

Гол асуултдаа хариулт авъя. Одоо тэгээд өөр илүү дутуу юм юу ярих вэ дээ. Энэ хуулийн 12.11 дээр импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод агуулагдах гадаад хэл дээрх мэдээлэл гээд биччихсэн байгаа байхгүй юу. Өнөөдрийн Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн 12.6 дээр маш тодорхой заасан байгаа юм. Тэгэхээр энэ чинь өөрөө Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг бид нар хэлэлцэж байна шүү дээ. Энийгээ өөрчлөх гээд байгаа юм уу л гэж би асуугаад байгаа юм. Нэг чухал асуудал нь хууль дээр бичигдсэн үг, үсгээр.../минут дуусав/

Б.Бейсен: Хэдэн номер хариулах уу. 5 номер хариулъя.

С.Өнөрсайхан: Өнөрсайхан Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэргэдэх Эрдэмтдийн зөвлөлийн гишүүн байна. Энэ дээр бид нар энэ шошгын асуудал сүүлийн үед олон орноос манайд хүнсний бүтээгдэхүүнүүд импортлогдож орж ирж байгаа. Тэрний үндсэн орчуулга нь бол зөрүүтэй байна гэдэг маш их олон асуудлууд гарч ирсэн. Одоогийн байдлаар бол хүүхдийн сүү, сүүн бүтээгдэхүүн, хоол тэжээлийн асуудал дээр л Үндэсний зөвлөл шошгын үндэсний зөвлөл бол Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв дээр ажилладаг. Бусад ийм зүйл дээр бол үйлдвэрлэгч импортлогчид өөр өөрсдийн дур дураар хийдэг. Тэгээд шошгын стандартаар явдаг. Тэгэхээр энэ хууль дээр бол нэмэлтээр бид нар энэ хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан нэмэлт бүтээгдэхүүн тайлбарууд байх ёстой. Мөн тэр орчуулга бол заавал үндсэн юутайгаа таарч байх ёстой гэдэг ийм юмыг бол хуульчилж оруулж өгье гэсэн ийм асуудалтай нэмэлтээр 12.11, 12.12, 12.13 дээр бол нэмэлт оруулж ирж байгаа.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүнд тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Харин тийм, хайран сайхан цагийг маань үрээд байна л даа. Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн 12.6 дээр импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод агуулагдах мэдээлэл Монгол эсхүл Англи, Орос хэлний аль нэгээр бичигдсэн байна гэдэг үг, үсэг байна. Та бүхний оруулж ирж байгаа хуулийн өөрчлөлт дээр 12.11 дээр импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгод агуулагдах гадаад хэл дээрх мэдээлэл монгол хэл дээрх орчуулга агуулгын хувьд нийцсэн байна гэж байгаа юм. Гадаад хэл дээрх мэдээлэл гэдэг маань Англиар ч байж болно, Арабаар ч байж болно, Хятадаар ч байж болно, Түвдээр ч байж болно. 12.6 чинь хүчингүй болох юм уу. Эсвэл энийгээ үгүйсгэж байгаа юм уу. Энэ чинь хууль дээр хоёрдмол утга орж ирчхээд байна шүү дээ. Энийгээ хариулаад өгөөч ээ л гэж байгаа юм.

Б.Бейсен: Лүндэг гишүүн хариулъя.

С.Лүндэг: Бат-Эрдэнэ гишүүн ээ, тийм байна. Та өөрөө ч буруу ойлгоод бид нарын энэ асуудлыг буруу ойлгоод байна. Тэр 12.6 чинь бол манайд орж ирж байгаа барааны шошго дээрх тайлбар одоо Англи юм уу, Орос юм уу, Монгол байна л гэж байгаа байхгүй юу. Гэтэл өнөөдөр Япон хэл дээр ч юм уу, Хятад хэл дээр тайлбартай бүтээгдэхүүн орж ирээд, тэрийг нь бид нар өөрсдөө Монгол хэлээр орчуулга хийгээд, шошгыг нь өөрчлөөд явж байгаа шүү дээ. Үгүй ээ, тэгэхээр харин энийг хууль дээр оруулж ирээд, Одоо тэгэхдээ өнөөдөр бид нар тийм юм хэрэглэж л байгаа шүү дээ. Захын хүнсний дэлгүүрт байж байгаа шүү дээ. Хуулиа мөрдүүлье л дээ. Тэгэхдээ бид нар хэрвээ орчуулж байгаа бол та нар энэ орчуулгаа л гэдэг үг болохоос биш

Б.Бейсен: Энэ дээр Лүндэг гишүүн анхаарах шаардлагатай юм байна шүү. Болдоо Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Хуулийн төсөл дээр хариуцлагын асуудал нэлээн сайн суусан юм билээ. Бүх л оролцогч талуудад тавьж байгаа хариуцлага, шаардлагуудыг оруулж ирж тусгаж байгаа гээд. Тэгээд энэ дээр яг хуулийн төслийн зохицуулах харилцаа 1.3 дээрээс зүгээр онцлоод хэдэн зүйлийг хэрэгжилт талаас нь хэлээд өгөөч ээ гэсэн асуулт юм байгаа юм шүү. Яг яаж хэрэгжүүлэх юм.

6 дээр нь болохоороо ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн байжээ. Тэрийг нь лабораториор шинжилгээний дүн нь эсвэл пестицид нь өндөр, эсвэл антибиотикийн үлдэгдэл нь зөвшөөрөх дээд хэмжээнээс хэтэрсэн байна гэх юм бол хариуцлага хүлээлгэх юм байна шүү дээ. Хэнээр хүлээлгэх вэ гэвэл малчдаар, тариаланчдаар, үйлдвэрлэгчдээр. Нөгөө бүтээгдэхүүн болчихсон хойно нь байхгүй юу. Тэгэхээр яг яаж тэр бүтээгдэхүүнд орсон түүхий эдийнх нь эх үүсвэрийг нь гаргаж ирсэн малчныг, тариаланчийг хариуцлага үүрүүлэх дээр нь яг яаж ажиллах вэ.

7 дээр нь бас байгалийн жимс жимсгэнэ, самар, мөөг, цайны ургамал гээд ийм ургамал байлаа. Бас лабораториор шинжлээд хамгааллын бодис нь эсвэл хүнсний нэмэлт хэрэглэсэн нь зөвшөөрөгдөх хэмжээнээс бас хэтэрснийг нь тогтоох юм байна л даа. Тэгээд тогтоонгуутаа түүсэн хүнд нь хариуцлага хүлээлгэнэ. Худалдаалсан иргэнд нь, хуулийн этгээдэд нь хариуцлага хүлээлгэнэ гэхихсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр яг яаж амьдрал дээр хэрэгжих вэ. Яг энэ хуулийн төсөл дээрээ батлагдвал. Тэгээд ер нь энэ лабораторийн асуудлуудыг бас хэд хэдэн газар

тусгаж өгсөн байгаа юм. Тэгээд лабораторийн чадамж хангалтгүй байна гэсэн тайлбарууд бас хэд хэд давтагдаж гарсан. Тэгэхээр энэ хүнсний аюулгүй байдалтай холбоотой лабораториуд яг ер нь хэний нуруун дээр байдаг юм. Төсвийн төсвөөр ерөнхийдөө бүх үндэсний энэ лавлагаа лабораториуд үйл ажиллагаа явуулдаг уу. Эсвэл бас хувийн олон улсын стандартад нийцсэн тийм лабораториуд бас байдаг юм уу. Ер нь цаашдаа яг ямар байдлаар энэ хуульд явах нь зөв бэ гэдгээр заалт зүйлүүд туссан байгаа вэ.

Б.Бейсен: Мандхай гишүүн хариулах гэж байгаа юм уу. 3 номер хариулъя.

Д.Энхмаа: Уянга гишүүний асуултад хариулъя. Хариуцлагатай холбоотой зохицуулалт буюу хүнсний сүлжээнд ялангуяа Эрүүл мэндийн сайдын баталсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх аюулгүйн үзүүлэлт гэж байдаг. Тэр аюулгүйн үзүүлэлтийг бол угаасаа яг одоо байгаа, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиараа бас Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори шинжлээд, шинжилгээ нь улсын байцаагч бас дүгнэлт гаргаж байх ёстой. Угаасаа одоо процесс нь тэгж явдаг. Тэгэхээр харьцангуйгаар нөгөө одоо байгаа хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль дээр энэ зохицуулалт нарийн тусгагдаагүй учраас ерөнхийдөө яг ямар тохиолдолд ямар шинжилгээ хариу аваад, яг ямар улсын байцаагчийн л нэг ёсондоо энэ хориглосон заалт дээр хяналт тавина гэсэн үг шүү дээ. Одоогийн байдлаар та яаж хяналт тавих вэ гэхээр өнөөдөр хяналтын бодлого хяналтын тогтолцоо өнөөдөр жоохон гажуудалд орсон үед бол яг өнөөдөр эргэлзээтэй харагдана. Энэ хууль батлагдсанаар Хүнсний хяналт зохицуулалтын агентлаг гээд байгуулагдаад, яг ном ёсоороо, олон улсынхаа жишгээрээ яг хяналт, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд анхан шатны үйлдвэрлэлээсээ хэрэглэгч хүртэл хяналт тавиад ирэхээрээ энэ өөрөө яг энэ улсын байцаагч нарын үндэсний хэмжээнд мөн нийслэлийн хэмжээнд, орон нутгийн хэмжээнд улсын байцаагч нар ажиллах ажлын яг чиг үүрэгт нь ороод явчих юм байгаа юм. Энэ бол хяналт тавих бүрэн боломжтой. Одоо бол хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори бол Стандарт хэмжил зүйн газрын харьяа байдаг. Энэ хуулиар бол бид нар тус лабораторийн харьяаллыг шилжүүлж, энэ шинээр байгуулагдах буюу шинээр биш зохион байгуулалтад шинээр орж нэгтгэгдэх Хүнсний хяналт зохицуулалтын агентлагийн харьяа хүнсний аюулгүй байдлын лавлагаа лабораторио харьяалуулах ийм саналтай орж ирсэн.

Б.Бейсен: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Үзэл баримтлалынх нь хүрээнд дэмжье. Хэлэлцүүлгийн түвшиндээ нэлээн юмнуудаа анхаарах байх. Зүгээр уншаад үзлээ. Аюулгүй байдал гэдэг үгээ бид баталгаат байдлын тухай яриад, тэгээд тэр цаад салбаруудын үндсэн дагаж одоо орж ирсэн хуулиудын зохицуулалт дээр сүйдтэй тийм шийдлүүд их багатай юм. Тэгээд түүгээрээ нөгөө болж өгөхгүй байгаа юмнууд чинь шийдэгдэж чадах юм уу, үгүй юм уу гэдэг л асуудал байгаад байгаа л даа. Үүнийгээ нэлээн сайн харах ёстой болов уу гэсэн ийм юм байна.

2 дугаарт гарал үүсэл, мөшгөлт, баталгаажуулалтын тогтолцоо чинь яаж явах вэ л гэдэг асуудал. Үүнийгээ хэдүүлээ ямархуу байдлаар шийдэх юм бэ. Яг нарийндаа тийм лоозонгийн хэлбэртэй юмнууд хийчхээд. Тэгээд дахиад 10 жилийн дараа энэ асуудлыг ярихад ахицгүй юм байж таарамгүй л болчихоод байгаа л даа. Тэгэхээр бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын чинь асуудал өөрөө ерөнхий 1 урсгал гэдэг юм уу зөв системд орж байж л энэ зөв явах тухай л ойлголт байх юм болов уу гэж би бодоод байгаа юм. Бүх аж ахуйн байгууллага, бүх төсвийн байгууллагууд

дээр хүйтэн хэлхээний систем гэхэд бүгд хүнсний бүтээгдэхүүнүүд өөр өөр хадгалалтын горимтой. Тэрийгээ хангаж чадахгүй. Тэгэхээр үүнийг яаж хэдүүлээ үндэснийхээ хэмжээнд зөв хангаж байж энэ явах уу гэдэг асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр ийм суурь юмнуудаа барьж авч ноцолдвол их зөв юм болох юм биш байгаа даа.

Малчид тариаланчид 2 ч Монголчуудыг нэг их алчихаар юм хийгээд байгаа гэж би бол ойлгохгүй байгаа шүү. Ёстой тэр хил гаалиар чинь л бузрууд чинь орж ирээд байгаа байх. Үүнийгээ л нэлээн сайн чангатгах юмаа энэ дотроо нэлээн зөв оруулмаар миний хувьд бол санагдаад байгаа.

Дараа нь тэр үйлдвэрлэлт, борлуулалт, хадгалалт, тээвэрлэлтийн бүхий л систем дээрээ тэр сайн дадал гэдэг юм уу, техникийн зохицуулалт гэдэг юм уу, стандартуудаа зөв бариулах тухай асуудал, түүндээ яаж үйл явцын контролоо хийх юм гэдэг тухай л ойлголт байгаад байгаа шүү дээ. Одоо нэг ярихаараа бизнесийг дэмжинэ. Хяналтгүй байх тухай ярьцгаагаад, нэг ярихаараа хэдүүлээ бас хяналт юмнуудаа төвлөрүүлээд тийм хүсэмжлэх хэлбэртэй юм ярьцгаагаад л ингээд байгаа. Яг нарийндаа бол мэргэжлийн хяналтын байгууллага татан буулгаснаараа наад хүнсний, байгаль орчны бүх салбарт их дордсон шүү дээ. Байдал тун удахгүй нэлээн хүнд юмтай нүүр тулна. Зарим нь их сайхан болсон юм шиг юм ярьцгаагаад байгаа. Худлаа байхгүй юу. Байдал нэлээн тийм төвөгтэй байгаа. Айлын хатавчинд байж байгаа 2, 3 хүн л байгаад байгаа шүү дээ энэ хяналтын чинь хүмүүс. Тэгээд тэр нь зөв юм уу, үгүй юм уу би мэдэхгүй байгаа.

Б.Бейсен: Лүндэг гишүүн хариулъя.

С.Лүндэг: Манай Батжаргал гишүүн яг л зөв, зүйтэй л ярьж байна. Өөрөө ч мэргэжлийн хүн. Тэгээд бас Их Хурал дээр бас ажлын хэсэг Байнгын хорооноос ажлын хэсэг гарч байгаа. Нөгөө 36 дугаар тогтоолтой холбоотой. Тэгэхээр хэдүүлээ энийгээ яаж цаашаа үр дүнд хүрсэн, зөв зүйтэй болгох вэ гээд нэгэнт яг түрүүний хэлдгээр энэ хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулъя гээд оруулаад ирж байгаа юм чинь ажлын хэсэг дээрээ бөөнөөрөө сайхан ороод, ярилцаад нэлээн үр дүнтэй байх талаас нь ярилцмаар байна.

2-т бол бас таны хэлж байгаа үнэн. Бид нар ингээд хүнсний хувьсгал гэж яриад, хүнс үйлдвэрлэгчдээ нэг талаар дэмжээд байгаа мөртөө одоо ямар ч арга байхгүй энэ хууль бол нөгөө үйлдвэрлэгчдийнхээ эсрэг тэд нарыгаа чангатгасан л юм явна. Ямар ч аргагүй. Тэгэхдээ алийн болгон ингэж амьдрах юм бэ. Бүгдээрээ энэ чинь олон улсын стандартад нийцсэн зөв, эрүүл хүнс хэрэглэж сурмаар байна шүү дээ. Уламжлалт дээр бол ямар нэгэн буруутгах ч зүйл байхгүй. Өчнөөн мянган жил бид нарыг бас ингээд өдий зэрэгтэй аваад ирчихсэн энэ уламжлалт мал аж ахуй энэ тэр лүү бас учиргүй дайрмааргүй байгаа юм. Яг үнэндээ яг л Батжаргал гишүүний хэлж байгаа үнэн л дээ. Арай ч бас бид нарыгаа өдийг хүргээд ирсэн, цаашаа нэг их яахгүй. Хааяа зүгээр тэр янз бүрийн евомик ч гэдэг юм уу, пестицид ч гэдэг юм уу эд нар дээрээ л бид нар хяналтаа тавиад явчихвал бусдаар бол дажгүй л гэж харж байгаа. Тэгэхээр Батжаргал гишүүн ээ, та минь бас ажлын хэсэгт орж ирээд хамт бүгдээрээ энийг сайхан аваад явъя гэсэн ийм санал хэлж байна. Тэгээд бүгд бүх хэлсэн зүйлүүдийг тусгаж ажиллах болно.

Б.Бейсен: Мандхай гишүүний асуулт асууя.

М.Мандхай: Энэ хуулийг хамт өргөн барьсан гишүүний хувьд бол дэмжиж байгаа. Тэгэхдээ 1 бас тодруулж өгөөч гэсэн нэг асуудал байгаа. Энэ нь юу вэ гэхээр түрүүн бас Батжаргал гишүүн ер нь энэ хяналтын тогтолцоотой холбоотой Хүнсний аюулгүй байдлын хяналттай холбоотой асуулт асуусан байгаа. 2022 оны 6 дугаар сарын 15-нд Мэргэжлийн хяналтын ерөнхий газар гэж байгууллага байхдаа Хүнсний аюулгүй байдлын хяналтын газрын нийт 19 улсын байцаагчтайгаар байгуулж байсан. Энэ байх хугацаанд яг энэ газрын үйлдвэрлэл үйлчилгээний хяналтын газар, Хөдөө аж ахуйн хяналтын газартайгаар бүтэц орон тоог бол баталж байсан. Үйлдвэрлэл, үйлчилгээний хяналтын газарт Хүнсний чанар, стандартын хяналтын хэлтэс, энэ дотроо хүнсний үйлдвэрийн хяналт, худалдаа үйлчилгээний хяналт, хоол үйлдвэрлэлийн хяналт, хүнсний био аюулгүй байдлын хяналт гэсэн ийм 4 чиг үүрэг хариуцсан нэлээн ийм өргөн бүтэцтэй. Тэр дотроо Хөдөө аж ахуйн хяналтын газарт бол мал эмнэлгийн хяналт, ургамал хамгааллын хяналт гээд үндсэндээ их том бүтэцтэй, 2 том салбартай, 19 байцаагчтайгаар үйл ажиллагаа явуулсан. Харамсалтай нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг буулгахдаа хамгийн чухал бие даасан байх ёстой хүнсний аюулгүй байдлын энэ чиг үүргийг татан буулгаснаар одоо яг ямар нөхцөл байдалтай явж байгаа вэ гэхээр энэ дээр би бол Хүнс, хөдөө аж ахуйн яамыг би бол буруутгахгүй. Яагаад гэхээр энийг угаасаа Засгийн газрын шийдвэр гаргаад буулгачихсан учраас одоо ингээд хэрэгжиж байгаа. Хөдөө аж ахуйн салбарын хяналт 4 улсын байцаагчийн орон тоог бол хасаад, ингээд 16 бүтэц орон тоотой явж байгаа. Гэхдээ Хүнс, хөнгөн үйлдвэрийн хяналтын хэлтэс болоод хэлтэс дотроо хүнсний чанарын хяналтыг 5 хүн, тэгээд хөнгөн үйлдвэрийн 1 хяналт гээд бусад салбаруудад нь ургамал, мал эмнэлэг, үржил гээд мал аж ахуйн салбар луу ороод, хүнстэй холбоотой үндсэндээ бол хүнсний чанарын хяналт гээд 5. Тэгэхээр юу хэлж байна гэхээр үндсэндээ яам 116 хүнтэй үйл ажиллагаа явуулдагас 7 үндсэн байцаагч л хүнсний хяналтыг бол хийж байгаа. Нуух юм байхгүй. Тэгээд энэ тогтолцоо дээр үндсэндээ захиргааны шинжтэй шийдвэр гаргадаг. Мэргэжлийн яг энэ удирдлага, зохион байгуулалт зохицуулах асуудал бол гээгдсэн явж ирж байгаа. Тийм учраас энэ бас хууль дээр яг энийг хуучин байсан ийм өргөн цар хүрээтэй хүнсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг, бүтэцтэй холбоотой хяналтыг сайжруулах ямар зохицуулалтуудыг оруулж өгсөн юм бэ гэдэг дээр одоо хариулж өгөөч гэж хүсэж байна.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах уу. 3 номер хариулъя. 5 номер.

С.Өнөрсайхан: Өнөрсайхан байна. Хүнсний баталгаат байдлын түвшин гэж манайд байдаг. Мөн хүнсний хоол тэжээлийн дарамтын зүйлүүд гэдэг юман дээр аль аль нь бол 0 байдалд ороод байгаа. Үүний гол шалтгаан нэг бол хоол тэжээлийн дутагдал. Өлсгөлөн, дутуу жинтэй төрөлт, бага жинтэй байх, туранхай байх гэдэг үзүүлэлт давамгайлдаг. Эсвэл таргалалт их байх, тэр хоол тэжээлийн буруу зохисгүй хооллолттой холбоотой өвчлөл гэдэг энэ юм. Эсвэл энэ хоёр хоёулаа 1 өрхөд нийлээд энэ байдал 2-уулаа бий болчихсон. Одоо жишээлэх юм бол ээж нь тарган байхад хүүхэд нь хоол тэжээлийн дутлаас хамааралтай эмгэг өвчинд өртсөн ийм 3 дарамт бол харамсалтай нь Монгол Улсын хэмжээнд маш өндөр хувьтай яваад байгаа. Тэгээд хүнсний баталгаат байдал бол алдагдсан гэдэг ийм дүгнэлтүүд бол сүүлийн 10 жилийн хоол тэжээлийн хүнсний 5, 5 жилийн интервалтай гэсэн судалгаануудын дүнгүүд бол харагдаад байгаа. Тэгэхээр бид нар хүнсний баталгаат байдлынхаа тухай хуульдаа бол энэ дээр бид нар аль болохоор энэ борлуулалт, энэ яах аргагүй эрүүл мэнд, хяналт, стандарт, хөдөө аж ахуй, боловсрол, худалдаа, үйлчилгээ, байгаль орчин, бүх салбаруудын нийтийн дундын асуудал. Энэ бол нийгмийн эрүүл мэндийн асуудал өөрөө салбар дундын асуудал болоод байгаа. Үр дүн нь байгаа байдал маань ийм байгаа учраас энэ олон

салбарын асуудлыг цэгцэлж нэг доор нь оруулж ирж, хүнсний хяналтын байгууллагыг шинээр байгуулж өгөхгүй бол асуудал болохгүй нь, хүнд байна гэдгийг хуулийн үндэслэл дээр бол гаргаж өгсөн байгаа.

2 дугаар зүйл өнөөдөр гишүүдийн энэ асуугаад байгаа малын эрүүл мэндийн асуудал, энэ евомикийн асуудал, ариутгал халдваргүйтгэл, шавж устгалын бодисын бүртгэл нь Эрүүл мэндийн яам дээр явж байдаг. Пестицидийн бүртгэл нь Хөдөө аж ахуйн яам дээр явж байдаг. Ингээд 3 сайдын хамтарсан тушаалаар жилдээ батлагдаж байдаг. Ингээд хяналтгүй орхигдчихсон ийм тогтолцооноос үүдэлтэй өнөөдөр хууль бол орж ирж байгаа. Түрүүний тэр Хүнсний тухай хууль бол өөрөө тогтолцооны тухай хууль. Энэ Хүнсний аюулгүй байдлын тухай хууль маань өөрөө үйл ажиллагааны хяналтын гол хууль учраас бүтцэдээ оруулж ирэхээр ийм заалтууд бол хуульдаа нэлээн орж ирж байгаа.

3 дугаар гол үндэслэл бол эрүүл мэндийн боловсролын асуудал гарч ирж байгаа учраас энэ бүх юмыг нийлүүлээд хүн амын энэ чигээрээ яваад байвал бид нар тэр халдварт бус өвчин буюу хавдар, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөлөөсөө ойрын 5, 10 жилдээ бол салахааргүй ийм прогностой үндэслэлтэй явагдаж байгаа. Ингээд энийг бол хууль дээрээ заасан байгаа. Жишээлэх юм бол хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зохистой дадал, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт, тэгээд мал эмнэлгийн үйлчилгээний зохистой дадал, мал, амьтны эрүүл өсгөх тэжээх бүх үе шатдаа бол энэ хуулийн заалтуудыг бол шигтгэж оруулж өгсөн ийм байгаа. Хэрвээ сайн судлаад хараад үзвэл.

Б.Бейсен: 3 номер нэмж хариулъя.

Д.Энхмаа: Мандхай гишүүний асуултад хариулъя. Хүнсний баталгаат байдлыг хангах тухай хуулийн 14^{1.3} дээр бол хүнсний хяналт зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага цаашид хяналт зохицуулалтын байгууллага гэж тодорхойлсон. Энэ байгууллага нь болохоор хяналтын бодлогыг тодорхойлоод, үйл ажиллагаа явуулж байгаа аймаг, орон нутаг дээр байгаа гааль дээр байгаа улсын байцаагч нар бол хяналтын бодлогыг хэрэгжүүлэхээр хуульд тусгагдсан. Үүнийг болбол 14.4 дээр бол аймаг, нийслэл дэх хүнсний хяналтын байгууллага нь энэ хуулийн түрүүний ярьсан хяналтын тодорхойлсон бодлогыг хэрэгжүүлж, үр дүнг тогтмол тайлагнана. Буцааж тайлагнах. Хүнсний хяналтын бодлогын хэрэгжилт, үр дүнг мөн энэ төрийн захиргааны төв байгууллага буюу салбарын яамнуудад бол тайлагнах талаар .../минут дуусав/

Б.Бейсен: 1 номерт нэмж хариулъя.

Б.Батшагай: Мандхай гишүүний асуултад хариулъя. Хүнс, хөдөө аж ахуйн яамны Салбарын хяналтын газар бол хуучин тогтолцоо буюу Мэргэжлийн хяналтын байгууллагаас салж ирсэн хүнсний салбарын хяналтыг бол өнөөдөр хуучин хэвээс нь унагалгүй, зохион байгуулж авч явж байгаа гэдгийг бас энд цохон тэмдэглэж хэлье. Сая яах вэ бүтэцтэй холбоотой тоонууд дурдагдаж байгаа ч гэсэн яамны Салбарын хяналтын газрынхан дотоод зохион байгуулалтаараа дээрх чиглэлийн нэр томъёонуудыг холбогдох байцаагч нартаа улсын ахлах байцаагч нартаа хуваарилаад, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа улсын байцаагчдын мэргэжил, арга зүйн зөвлөгөө болон хяналтын салбарын бодлогоор бол удирдан зохион байгуулаад явж байгаа. Тэгэхээр өмнөх тогтолцооноос яг яаманд ирсэн чиг үүрэг буюу дотоод хяналт шалгалт, хүнсний үйлдвэрлэл, мал эмнэлэг, газар,

тариалалт гэх мэт яг өөрт хамаарах чиг үүргүүдээ бол зохион байгуулаад явж байгаа. Хяналт шалгалтын дүн мэдээгээ хуучин .../минут дуусав/

Б.Бейсен: Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Тэгэхээр 1 ийм байгаа юм. Хүнсний аюулгүй байдлын форум болсон. Энэ форум дээр Мал эмнэлгийн газрын дарга ХАБҮЛЛ лабораторийн захирал бүгд сууж байхдаа нэг ийм асуудал яг бодитой заалнаас асуулт ирэхэд хариулж байсан. Тэгээд энэ бол их эмзэглэмээр санагдсан. Тэр нь юу гэхээр нийт импортоор орж ирж байгаа малын гаралтай, ялангуяа антибиотикийн үлдэгдэлтэй бүтээгдэхүүн, дээрээс нь пестицидийн үлдэгдэлтэй энэ орж ирж байгаа бүтээгдэхүүнийг хорио цээр дээр хянах гэхээр хорио цээр бол малын гаралтай бүтээгдэхүүнийг хянах лаборатори хэрэгсэл бол байхгүй. Мал эмнэлэг бүрэн 100% орж ирж байгаа бүтээгдэхүүн болгон дээр хяналт тавих хүчин чадал байхгүй.

2 дугаарт пестицид дээр нийт орж ирж байгаа 116 орчим пестицидийн үлдэгдэл шалгадгийг одоогийн байдлаар/минут дуусав/

Б.Бейсен: Мандхай гишүүн гүйцээж асууя.

М.Мандхай: Тэгэхээр үндсэндээ импортоор орж ирж байгаа дунд буюу бага эрсдэлтэй бүтээгдэхүүн аль хэдийн хэрэглэгчийн гарт лангуун дээр оччихсон байдаг асуудал дандаа бид нар лангуун дээр очсоны дараа хяналт тавихад үлдэгдэлтэй гардаг, антибиотикийн үлдэгдэлтэй ийм эрсдэл үүссэн асуудал өнөөдрийг хүртэл давтагдсаар байгаа. Тэгэхээр би бол Хүнс, хөдөө аж ахуйн яам хүнсний аюулгүй байдал дээр хяналтын тогтолцоо хангалттай хүртээмжтэй байж чадахгүй байгаа гэдгийг судалгаа шинжилгээнүүд харуулчихсан байгаа. Тийм болохоор асуугаад байгаа нь Лүндэг гишүүнээс бас асууя. Тэгвэл энэ асуудал Хүнсний бүтээгдэхүүн аюулгүй байдлын тухай хуулиар яг бүрэн зохицуулагдаж, хянагдаж чадах юм уу гэдэг асуултад хариулж өгөөч.

Б.Бейсен: Лүндэг гишүүн хариулъя.

С.Лүндэг: Харин тийм ээ, түрүүнээс хойш би лаборатори яриад байгаа нь тийм учиртай. Үнэндээ одоо нөхцөл байдал, манай улсын нөхцөл байдал маань ийм байна. Тэгэхээр бид нар ядаж одоо тэр байгаа Стандарт хэмжил зүйн харьяанд оочсон ХАБҮЛЛ буюу хуучин бол Мэргэжлийн хяналтын л лаборатори шүү дээ. Хүнсний лаборатори. Тэнд тэгээд манай энэ Хүнс, хөдөө аж ахуйн яам дээр байгаа хуучин Мэргэжлийн хяналтын тэр хүнсний чиглэлийн байцаагч нар ингээд бас байж байгаа. Тэгээд энэ хэдийгээ нийлүүлээд ядаж эхний ээлжид нэг лабораториор ороод, лабораторийнхоо хүчин чадлыг орчин үеийн техник тоног төхөөрөмжөөр сайжруулаад авъя. Тэгээд мэдээж хувийн бас бизнесийн гэдэг юм уу лабораторийн ийм улсууд байгаа, олон улсын байгууллагууд ч байгаа. Тэд нартайгаа бас арга зүйн зөвлөгөө аваад хамтарч ажилладаг байлгая гэдэг энэ 2 гол асуудлыг л энэ хууль дээрээ оруулж ирээд байгаа юм. Одоо бид нарын хамгийн гол юм. Мэдээж төсөв санхүү нэмлээ, шинэ агентлаг барилаа гэдэг асуудал бас ярих гээд байх шиг байгаа юм. Тэгэхдээ засгаас санал авсан. Энэ дээр бол зохицуулалт хийгээд, дотроо засаг энийг зохицуулаад хийж болох байна л гэдэг санал ирсэн байгаа юм.

Б.Бейсен: 1 номер нэмж хариулъя гэж байна.

Б.Батшагай: Мандхай гишүүний асуултад нэмж хариулъя. Түрүүн би бас Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулахдаа хэлж байсан. Хүнс, хөдөө аж ахуйн яамны Салбарын хяналтад хил дээрх буюу импортын хүнсний хяналт хамаардаггүй гэдгийг бас дахиж хэлье. Тэгэхээр энэ чиглэлийн хяналтыг яамнаас явуулдаггүй. Тийм учраас дотоод хяналт буюу дотоод хүнсний хяналт буюу хилээр импортоор орж ирсэн хүнсний бүтээгдэхүүний хяналтыг энд тавихад маш хүндрэлтэй байгаа. Яагаад гэхээр тэндээс бол Монгол Улсын 20 хэдэн боомтоор орж ирж байгаа хүнсний бүтээгдэхүүнийг хянахад чиг үүрэг буюу зохион байгуулалт нь тусдаа. Дээрээс нь тэнд тавьж байгаа хяналт нь гаалийн хяналт маань өөрөө яг бүрэн гүйцэд хуучин мэргэжлийн хяналтын байгууллагад хийж байсан хяналтыг бол яг тэр хэмжээнд дүйцэхгүйгээр хийж чадахгүй байгаа гэдэг нь бол сүүлийн үед орж ирж байгаа түрүүний Хятад шошготой бараа бүтээгдэхүүн, Солонгос улсаас орж ирж хил гаалиар түүвэр ачаанд орж ирж байгаа хүнсний бүтээгдэхүүнээс дотоод орж ирсний дараа л бид нар мэдэж байгаа. Хуучин бол .../минут дуусав/

Б.Бейсен: 3 номер нэмж хариулъя.

Д.Энхмаа: Тодруулга хийчихье. Тэгэхээр яг энийг яриад байгаа юм л даа. Ерөөсөө Монгол Улсад яг хүнсний хяналтын бодлого алдагдсаны нэг жишээ. Хүнсний хяналтын бодлого нь жишээлбэл импортын хүнс дээр өөр гааль дээр байж байдаг. Дотоодынх нь болохоор дотоодын үйлдвэрлэлийн хүнсний бүтээгдэхүүнүүдийн хяналт нь болохоор аймаг, орон нутаг, нийслэл дээр явж байдаг. Одоо жишээлбэл хил гаалиар хорио цээрийнх нь болохоор тусдаа байж байдаг. Энийг харин нэгтгээд энэ Хүнсний хяналт зохицуулалтын агентлаг гэдэг маань хүнсний хяналтын бодлогыг гаргаж ирээд, түүнийг хэр хэрэгжүүлэх. Тэгснээс аймаг орон нутаг дээр байгаа улсын байцаагчийг энэ агентлагт нийлүүлэх асуудал ерөөсөө энд хөндөгдөхгүй. Хяналтын бодлогын асуудлыг л гаргаж ирж байгаа.

Б.Бейсен: Надад хэдэн асуулт байна. Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа юм. 14.1 дээр хүнсний баталгаат байдлыг хангах тогтолцоо нь улсын хэмжээнд хүнсний аюулгүй байдал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүнсний хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага өөрөөр хэлбэл хяналт зохицуулалтын байгууллага бий болох юм байна лээ шүү дээ. Агентлаг. Энэ дээр Засгийн газрын саналыг авсан уу. Зөвшилцсөн үү энэ талаар. 1 дүгээрт.

2 дугаарт энэ Монгол улсад CU, GS25 гээд хүнсний худалдаа, хоолны газрын сүлжээ бий боллоо. Улаанбаатар хот 9 дүүрэг, энэ ойр аймгууд Дархан, Эрдэнэт бүгдийг эзлээд, одоо аймаг руугаа орлоо. Одоо хүүхэд залуучууд үүгээр хооллож байна. Энэ сүлжээ дэлгүүр хоол үйлдвэрлэлийн хяналт, хүнсний эрүүл ахуйн хяналт, тэгээд яаж үйлдвэрлэлийн хяналт, борлуулалтын хяналтаар ямар хяналт хийх гэж байна. Наад зах нь бол Төрийн ордонд хүртэл орж ирлээ шүү дээ. Нөгөө талаар Монголын үндэсний хоол үйлдвэрлэл маань бас ингээд багасаж байна. Энэ CU, GS25-ыг ингээд эрхийг нь худалдаж аваад эд нар ажиллаад байна уу. Давхар гадаад улсад татвар төлж байна уу. Энэ талаар судалсан юм байна уу. Лүндэг гишүүн.

С.Лүндэг: 1 дүгээрт Засгийн газраас санал авсан. Тэгээд шинээр агентлаг байгуулах тал дээр бол ямар нэгэн болохгүй гэдэг юм бол хэлээгүй. Өөрсдийнхөө дотоод нөхцөл байдлаа дайчлаад, одоо байгаа бас үүнтэй холбоотой адилхан үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа бас ийм байгууллагуудтай уялдуулаад зохицуулж болох юм байна л гэдэг санал өгсөн байгаа шүү. Тэгээд бас цаад өөр хуультай яваад манай Чинбүрэн сайд байна уу. Бас бүр цаашаагаа нөгөө FTA буюу хүнс,

эрүүл мэндийн гэдэг сэдэв рүү ч оруулж магадгүй. Тэгэхдээ тэр бол засгийн бодлого. Энэ удаагийн хууль дээр бол бид нарт энийг дотоод нөхцөл байдлаар зохицуулж болох юм байна гэдэг хариу өгсөн.

СУ-г би мэдэхгүй байна. Та нар хариулах уу.

Б.Бейсен: Лүндэг гишүүн ээ, тэр шинэ байгууллагууд хүнсний хяналт үнэхээр Монголд алдагдчихаад, хавдрын эрсдэл ихсэж байгаа шүү дээ. Хүнсний аюулгүй байдал алдагдчихаад байгаа. Тийм учраас энийг т зогсох байх гэдэг үүднээс биш, энэ албан ёсны байгууллагыг бий болгох юм уу гэдгийг Засгийн газартай тохирох шаардлагатай. Саналыг нь авахгүй бол энэ үнэхээр болохгүй. 1 дүгээр микрофон хариулъя.

Б.Батшагай: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын хяналтын газраас 2025 онд нийт дээрх 5 чиглэлээр 2040 объектыг зарласнаас худалдааны чиглэлээр 520 объектыг бол эрсдэлийн үнэлгээгээр үнэлээд, улсын хэмжээнд бол төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж байгаа.

Бейсен гишүүний асуусан тэр СУ болон бусад сүлжээ болон дотоодын бид нарын ярьдгаар 8 нэрийн барааны дэлгүүр гэдэг ч юм уу ил задгай худалдаалалт дээр бол ТХШТХ-ийн 5.1-д заасан төлөвлөгөөт бус хяналт шалгалт буюу иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын бас ирүүлсэн өргөдөл, гомдлын хүрээнд тухай бүр нь бол төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж ажилладаг.

Б.Бейсен: Тэр хяналтыг би асууж байгаа нь СУ, GS25 дээр удаан хугацаагаар хоол нь үйлдвэрлээд хадгалчихдаг. Тийм учраас Монголын бүх хотын хэмжээнд, аймгуудаар энийг эзэлсэн ийм хоолны газрыг төлөвлөгөөтэй гэнэтхэн хяналт шалгалт хийхгүй бол энэ хоолны хордох асуудал их байгаа шүү. Энэ дээр бас анхаарах шаардлагатай байгаа юм. 3 номер хариулна гэж байна уу.

Д.Энхмаа: Таны асуултад хариулъя. Одоо энэ хоол үйлдвэрлэл үйлчилгээтэй холбоотой н түрүүн Бат-Эрдэнэ гишүүн ярьсан. Өмнөх худалдаа болон хоол үйлдвэрлэл үйлчилгээтэй зохицуулалт бол байгаагүй байсан, тусгагдаагүй байсан. Тэгэхээр энэ хуулиар бол 7 дугаар зүйл дээр 7.1.4 дээр хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд зохистой дадлыг нэвтрүүлэх гэж оруулсан. Мөн хүнсний сүлжээний үе шатад хадгалалтын зохистой дадлыг бас нэвтрүүлэх, мөн хүнсний сүлжээний нэг үе шатаас нөгөө үе шатад хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх, түгээх, хүргэх шатад тээвэрлэлтийн зохистой дадлыг нэвтрүүлэх, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний худалдаа, борлуулалтын шатад худалдаа үйлчилгээний зохистой дадал нэвтрүүлэх, мөн мал эмнэлгийн үйлчилгээний зохистой дадал нэвтрүүлэх, мал амьтныг эрүүл өсгөх, тэжээх үед холбогдох зохистой дадлыг нэвтрүүлэх гэж бүүр тодорхой тусгаж оруулсан байгаа.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хууль санаачлагчийн танилцуулгатай холбогдуулан санал хэлэх гишүүд байна уу. Нэрсээ өгнө үү. Бат-Эрдэнэ гишүүн байна. Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Бат-Эрдэнэ гишүүн саналаа хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Хэд хэдэн юмыг л ойлгохгүй л байна л даа. Бид нар Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хөндөж байгаа гэж ойлгож байгаа. Хууль өөрөө нэг мөр

байх ёстой. Одоо та хэдийн оруулж ирж байгаагаар 12.6, 12.11 хоёр чинь хоорондоо зөрчилдөж байна. 1 дүгээр асуудал нь энэ.

2 дугаар асуудал нь 14^{1.3} Хүнсний хяналт зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гэдэг байгууллагыг та хэд бий болгох гэж байна. Яаманд чинь энэ чиг үүрэг байгаа шүү дээ. Төрийн хэмнэлтийн тухай хууль өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа. Би та хэдэд уншаад өгье.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17 дугаар зүйл

“17.1.Засгийн газар хэмнэлтийн талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

17.1.1.Чиг үүргийн давхардалтай эсвэл чиг үүрэг ойролцоо харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа төсвийн байгууллага төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх зэргээр удирдлагын зардлыг хэмнэнэ.” гэж байгаа юм. Монгол Улсын төсөв сүүлийн хэдэн жилийн дотор 31 их наяд төгрөг хүртлээ нэмэгдсэн. Тэгэхдээ эрүүл мэндийн салбарт ахиц гарсангүй. Хүн амын эрүүл мэнд хүндэрсэн хэвээрээ л байгаа. Хүнсний аюулгүй байдал дээр ахиц гарсангүй. Хүн амын санхүү мөнгө, карматай холбоотой асуудал дээр ч ахиц гарсангүй. Хаана ахиц гарсан бэ гэхээр төр данхайсан. Уг нь төсөв тэлэх хэрээр иргэд нь баяждаг байвал энэ болж байгаа. Гэтэл төр нь баяжаад, иргэд нь ядуураад байгаа байхгүй юу. Тэгтэл хуулиар дамжуулаад агентлаг байгуулах асуудал орж ирж байна. Засгийн газар яагаад санал өгөхдөө энэ тухай хөндөөгүйг би сайн ойлгохгүй байна. Хууль зүй, дотоод хэргийн яам хуулийн бүх л зүйлийг ширхэгчилж үзээд та бүхэнд хариу өгөх ёстой. Засгийн газраас Улсын Их Хурал руу хариу өгөх ёстой. Өргөн барих процесс дээр энэ явагдах ёстой. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн үйлдэл гэж би харж байгаа юм. Хуулийн ач холбогдол өндөр үү гэвэл өндөр. Бид нар засаад сайжруулаад, ажлын хэсгээ байгуулаад, тодорхой хэмжээний үйл ажиллагааны хүрээнд засах ёстой юмнуудыг боломжоор нь засаад явах ёстой л гэж ойлгож байгаа. Гэхдээ бид нар төр данхайж байгаа энэ системийг төрийн албан хаагчид, Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын гишүүд нь өөрсдөө дэмжээд байвал хэзээ ч Монгол Улс хөгжихгүй.

Би энийг дахиж хэлье. Саяхан аялал жуулчлалыг хөгжүүлэх төвийг буцааж байгуулахаар Соёл, спорт, аялал жуулчлалын яам санаархаж оруулж ирснийг сошиалаар нэг юм болж байж татан буулгасан. Татан буулгах жагсаалтад орчихсон байгаа. Одоо явж байгаа. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар дээр.

Тэгтэл 1 хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулж ирэх хэлбэрээр дахиад бүр чиг үүрэг нь хяналт зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны тэр байгууллагыг хүнс, хөдөө аж ахуй чиглэл дээр оруулж ирж байгаа нь болохгүй асуудал. Одоо яах юм. Байгаль орчны тухай хуульд тэгвэл нэмэлт, өөрчлөлт оруулаад Байгаль орчны хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг оруулж ирэх юм уу. Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт хийгээд эрүүл мэндийн ийм хяналтын захиргаанд төрийн захиргааны байгууллага байгуулах асуудлыг оруулж ирэх юм уу. Ингэсэн дор бол эсвэл салбарын хяналтуудаа татан буулгаад, мэргэжлийн хяналтын байгууллагаа буцаад байгуулчихсан нь дээр шүү дээ. Тэгээд энийгээ хэдүүлээ эргэж хармаар байна. Энэ болохгүй асуудал.

Б.Бейсен: Гишүүд санал хэлж дууслаа. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалт үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар санал дэмжигдлээ.

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар санал дэмжигдлээ.

Малчны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 59,1 дүгээр санал дэмжигдлээ.

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 59,1 дүгээр санал дэмжигдлээ.

Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар санал дэмжигдлээ.

Таримал ургамлын үр, сортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар санал дэмжигдлээ.

Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 59,1 хувиар санал дэмжигдлээ.

“Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 12 гишүүн дэмжиж, 54,5 хувиар санал дэмжигдлээ.

Энэ санал дээр Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье гэж байна. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Дэгийн тухай хуулийн 35.14-ийн зүйл заалтыг үндэслээд бас татгалзсан шалтгаанаа хэлэх нь шаардлагатай болов уу гэж бодож байгаа.

Бид нар Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын тохируулагч агентлаг гэсэн хэсэгт “Хүнсний хяналт зохицуулалтын газар” гэж нэмсүгэй гэдэг Улсын Их Хурлын тогтоолын асуудлыг ярьж байгаа. Бид нар ингэж болохгүй гэдгийг бас Улсын Их Хурлын гишүүддээ хэлмээр байна. Манай хууль санаачлагчид бас энэ хэсгээ татаад авчхаасай. Яг энэ жишиг чинь явна шүү. Төрийн хэмнэлтийн тухай хууль өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа. Өнөөдөр төрийн өмчит маш олон газруудыг татан буулгах асуудал Засгийн газар дээр явагдаж байгаа. Өнөөдөр Засгийн газар дээр тохируулагч агентлаг шүү. Энэ хэрэгжүүлэгч биш, Засгийн газрын тохируулагч агентлаг. Бодлогоо гаргана гэсэн үг. Байгаль орчны яам энийг оруулж ирнэ. Эрүүл мэндийн яам энийг оруулж ирнэ. Бүх яам ийм байдлаар буцаагаад агентлагуудтай болно. Энийг бид нар төсөв батлагдахаас өмнө орж амжих юм уу. Тэгээд ингээд Улсын Их Хурлаар ороод батлагдчихлаа гэж бодъё. Төсөв санхүүгийнх нь асуудал яаж шийдэгдэх юм. Байр савных нь асуудал яаж шийдэгдэх юм. Дахиад хэдэн хүнтэй байх юм. 20 хүнтэй байх юм уу. Улс орон даяар гээд 600 хүнтэй байх юм уу. Энэ болохгүй шүү дээ. Энэ болохгүй. Тэгээд бүр тохируулагч агентлагийн түвшинд оруулж ирж байгаа асуудал байж болохгүй.

Тэгснээс Улсын Их Хурлын гишүүд хэдүүлээ нийлж байгаад үнэхээр асуудал цалгардаад байгаа бол тэр салбарын хяналтуудыг бүгдийг нь буцаагаад татаж аваад, Мэргэжлийн хяналтын байгууллагыг буцаагаад байгуулцгаая. Үнэхээр асуудал болохгүй байгаа бол. Харин хуулиар дамжуулаад Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр дамжуулаад агентлаг байгуулах тухай асуудал Төрийн хэмнэлтийн тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа энэ цаг хугацаанд төр данхайчихлаа гээд ард түмэн чинь өнөөдөр гудамжинд орилж байгаа энэ цаг хугацаанд төсөв чинь хэдэн их наядаараа тэлж байгаа, ард түмний амьдрал сайжрахгүй байгаа энэ цаг хугацаанд төр нэмж агентлаг байгуулж болохгүй ээ. Болохгүй. Би энэ дээр маш хатуу байр суурьтай байна.

Тийм учраас би татгалзсан. Хууль санаачлагчид яг энэ хэсгээ татаад авчхаач гэдгийг би хүсэж байна. Явцын дунд. Баярлалаа.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүний саналыг бас протоколд тусгаарай. Ер нь Их Хурлын дарга Улсын Их Хурлын чуулган дээр бас Мэргэжлийн хяналтын албыг дахин байгуулна гээд дуугарах шиг болсон. Ер нь энэ асуудал дээр хүнсний аюулгүй байдал алдагдсан, мэргэжлийн хяналтын албыг тараасантай холбоотой бүх салбар салбар дээр алдагдсан уу гэвэл алдагдсан. Бас анхаарч бодууштай асуудлууд байгаа. Бас дараагийн одоо чуулган, Их Хурлаар бас хэлэлцэгдэх байх. Тэр үед бид бас саналаа хэлнэ.

Байнгын хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн хэлэлцүүлнэ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа. Одоо Эдийн засгийн байнгын хороотой бид нар хамтарсан хуралдаантай шүү. Гишүүд бас хүлээж байгаарай.

18.16 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ